



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 09-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 - 4
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	5 - 77

- 1. Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2022 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 08, 2023 оны 01 дүгээр тогтоолуудын хэрэгжилтийн талаарх мэдээлэл сонсох* 5 – 49
- 2. Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2022 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 07 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээлэл сонсох* 49 - 68
- 3. Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2022 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 05 дугаар тогтоолын хэрэгжилт болон Жижиг, дунд үйлдвэрийн газрын үйл ажиллагааны талаарх тайланг хэлэлцэх* 68 - 77

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга Г.Ганболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 16 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 56.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 25 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ж.Бат-Эрдэнэ, Г.Тэмүүлэн, Ж.Эрдэнэбат;
Тасалсан: С.Ганбаатар.

Нэг.Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2022 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 08, 2023 оны 01 дүгээр тогтоолуудын хэрэгжилтийн талаарх мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд М.Ганхүлэг, Дарханы арьс ширний цогцолбор төрийн өмчит хязгаарлагдмал хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Дондогдорж, мөн газрын мэргэжилтэн Ц.Төмөрбаатар, Г.Чимэдцэрэн, Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнзориг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Эдийн засгийн хөгжил, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Солонго, Хөгжлийн банкны Эрсдэлийн удирдлагын газрын захирал З.Батырбек, Хөгжлийн банкны хуульч Д.Оргил, “Ди Би Эм лизинг” компанийн Санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа хариуцсан нэгжийн захирал Н.Бадрал, “Эмээлт эко аж үйлдвэрийн парк” компанийн гүйцэтгэх захирал Б.Мягмар, Маркетинг, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн О.Амарбаясгалан, Дарханы арьс ширний цогцолбор төрийн өмчит хязгаарлагдмал хувьцаат компанийн Төсөл хөгжүүлэлт, судалгааны хэлтсийн дарга Ч.Бат-Эрдэнэ, тус компанийн цахилгааны инженер Д.Баярмаа, Гадаад харилцаа, олон нийттэй харилцах хэлтсийн мэргэжилтэн Б.Жамух, Монголын арьс ширний үйлдвэрлэлийн холбооны гүйцэтгэх захирал Т.Баярсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 2022 оны 08, 2023 оны 01 дүгээр тогтоолуудын хэрэгжилтийн талаарх мэдээллийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд М.Ганхүлэг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут, Т.Энхтүвшин, Ж.Батжаргал, Г.Дамдинням, Ц.Анандбазар, Ц.Туваан, Н.Наранбаатар, Г.Ганболд нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд М.Ганхүлэг, Дарханы

арьс ширний цогцолбор төрийн өмчит хязгаарлагдмал хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Дондогдорж, Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнзориг, “Эмээлт эко аж үйлдвэрийн парк” компанийн гүйцэтгэх захирал Б.Мягмар, Монголын арьс ширний үйлдвэрлэлийн холбооны гүйцэтгэх захирал Т.Баярсайхан, Хөгжлийн банкны Эрсдэлийн удирдлагын газрын захирал З.Батырбек нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Анандбазар, Ц.Туваан, Ж.Батжаргал, Г.Дамдинням, Д.Батлут, Г.Ганболд нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2022 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 08, 2023 оны 01 дүгээр тогтоолуудын хэрэгжилтийн талаарх мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 12 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2022 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 07 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд М.Ганхүлэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, мөн яамны Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга А.Нарантуяа, Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Наранчулуун, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Д.Отгонжаргал, Монголын сүүний нэгдсэн холбооны тэргүүн Г.Ганхуяг, мөн холбооны тэргүүлэгч гишүүн Р.Цогтбуян нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2022 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 07 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээллийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд М.Ганхүлэг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Ц.Туваан, Ц.Анандбазар, Г.Ганболд нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд М.Ганхүлэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, Монголын сүүний нэгдсэн холбооны тэргүүн Г.Ганхуяг, мөн холбооны тэргүүлэгч гишүүн Р.Цогтбуян нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2022 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 07 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 13 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2022 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 05 дугаар тогтоолын хэрэгжилт болон Жижиг, дунд үйлдвэрийн газрын үйл ажиллагааны талаарх тайланг хэлэлцэх

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд М.Ганхүлэг, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, мөн газрын Бодлого зохицуулалтын хэлтсийн дарга А.Гэрэлзаяа, Зээл, төслийн хэлтсийн дарга Н.Энхтөр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2022 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 05 дугаар тогтоолын хэрэгжилт болон Жижиг, дунд үйлдвэрийн газрын үйл ажиллагааны талаарх тайланг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын тавьсан асуултад Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь, Т.Аубакир, Г.Ганболд нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2022 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 05 дугаар тогтоолын хэрэгжилт болон Жижиг, дунд үйлдвэрийн газрын үйл ажиллагааны талаарх тайланг сонсов.

Уг асуудлыг 13 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 34 минут үргэлжилж, 16 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 75.0 хувийн ирцтэйгээр 13 цаг 59 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Г.ГАНБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордны “Их эзэн Чингис хаан”
танхим
10 цаг 25 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Г.Ганболд: Байнгын хорооны гишүүдийн өдрийн амгаланг айлтгая.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн А.Адьяасүрэн, Ц.Анандбазар, Ж.Батжаргал, Д.Батлут, Г.Ганболд, Г.Дамдинням, Н.Наранбаатар, Ш.Раднаасэд, Ц.Туваан, Т.Энхтүвшин нар хүрэлцэн ирж хуралдааны ирц 62.5 хувьтай тул 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Өнөөдрийн хурлаар хэлэлцэх асуудлын дараалалыг танилцуулъя.

Нэг. Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 2022 оны 08, 2023 оны 01 дүгээр тогтоолуудын хэрэгжилтийн талаарх мэдээлэл сонсох.

Хоёр. Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2022 оны “Засгийн газарт Засгийн газарт чиглэл өгөх тухай” 07 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээлэл сонсох.

Гурав. Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2022 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 05 дугаар тогтоолын хэрэгжилт болон жижиг, дунд үйлдвэрийн газрын үйл ажиллагааны талаарх тайланг хэлэлцэх гэсэн гурван асуудал хэлэлцэхээр төлөвлөсөн байна.

Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөтэй холбогдуулаад асуулт асуух, санал хэлэх гишүүн байна уу? Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг баталъя.

**Нэг. Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны
2022 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 08,
2023 оны 01 дүгээр тогтоолуудын хэрэгжилтийн талаарх
мэдээлэл сонсох**

Хэлэлцэх асуудлын дарааллын дагуу Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 2022 оны 08, 2023 оны 01 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээллийг сонсоно.

Хэлэлцэх асуудал Үйлдвэрлэлийн бодлогын байнгын хорооны 2022 оны 08,

2023 оны 01 дүгээр тогтоолоор хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг ахиулах, кластер хөгжлийг хангах, Дархан арьс ширны цогцолбор, Эмээлт эко аж үйлдвэрийн парк болон “Шинэ Ховд” үйлдвэр технологийн паркийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх чиглэл өгсөн байгаа.

Уг асуудалтай холбогдуулаад ажлын хэсгийг танилцуулъя.

М.Ганхүлэг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд, М.Дондогдорж Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Ц.Төмөрбаатар Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн, Г.Чимэдцэрэн Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн, П.Сайнзориг Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч, Б.Солонго Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Эдийн засгийн хөгжил, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, З.Батырбек Хөгжлийн банкны Эрсдэлийн удирдлагын газрын захирал, Д.Оргил Хөгжлийн банкны хуульч, Н.Бадрал “Ди Би Эм лизинг” компанийн Санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа хариуцсан нэгжийн захирал, Б.Мягмар “Эмээлт эко аж үйлдвэрийн парк” компанийн гүйцэтгэх захирал, О.Амарбаясгалан Маркетинг, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн, М.Дондогдорж Дарханы арьс ширний цогцолбор төрийн өмчит хязгаарлагдмал хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Ч.Бат-Эрдэнэ Төсөл хөгжүүлэлт, судалгааны хэлтсийн дарга, Д.Баярмаа тус компанийн Цахилгааны инженер, Б.Жамух тус компанийн Гадаад харилцаа, олон нийттэй харилцах хэлтсийн мэргэжилтэн, Т.Баярсайхан Монголын арьс ширний үйлдвэрлэлийн холбооны гүйцэтгэх захирал гэсэн ийм ажлын хэсэг байна.

Уг асуудалтай холбогдуулаад мэдээллийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд М.Ганхүлэг танилцуулна. Ажлын хэсгийн 3 номерын микрофоныг өгье.

М.Ганхүлэг: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Хүнс, хөдөө аж ахуйн яам арьс ширний үйлдвэрүүдтэй холбогдолтой мэдээллийг Та бүхэндээ танилцуулъя.

Юуны түрүүнд тогтоолын төслийн эхний гол агуулга салбарын хувьд боловсруулах үйлдвэрүүдтэй холбогдолтой асуудлыг цогцоор нь авч үзэж, зах зээлийн эрэлт нийлүүлэлт, хэрэгцээгээ тодорхойлж, одоогоор үйл ажиллагаанууд нь эхлээд байгаа аж үйлдвэрийн паркуудыг нэгдсэн бодлогоор ханган ажиллах гэдэг эхний заалтын дагуу танилцуулгаа эхэлье.

Арьс ширний салбарын хувьд бид бүхэн жилдээ 19.9 сая 2022 оны байдлаар арьс ширнийг нийтдээ бэлтгэж байна. Үүнээс адуу, үхэр, хонины арьс, ямааны арьс гээд графикаар сүүлийн 4 жилээр энэхүү слайд дээр бид бүхэн харуулсан байгаа юм.

Нийтдээ арьс шир боловсруулах үйлдвэрүүдийн суурилагдсан хүчин чадал маань 2023 оны байдлаар нийт 13 үйлдвэр хагас боловсруулах суурилагдсан хүчин чадалтай, нийт 18 үйлдвэр гүн боловсруулах хүчин чадалтайгаар ажиллаж байгаа ийм үйлдвэрүүдтэй байгаа.

Цаашдаа бид бүхэн томоохон 4 төслийг хэрэгжүүлэхээр байгаа.

Г.Ганболд: Слайд нь яагаад гарахгүй байна. Жижиг дэлгэц рүү өгвөл сайн байна.

М.Ганхүлэг: Нийтдээ бэлтгэж байгаа арьс ширний түүхий эдийн дундаж статистик 20 орчим сая арьс байгаа юм.

Арьс ширний үйлдвэрүүдэд боловсруулсан арьс 2023 оны байдлаар одоогийн байгаа боловсруулсан арьс 5.3 сая арьс гэж гарсан байна.

Дулааны аргаар бэлтгэсэн малын арьс 2 сая орчим, хавар, зуны чанар муутай арьс. Энэ 03 сарын 20-ноос 06 сарын 20-ныг хүртэлх энэ хэмжээ нь 2 орчим сая арьс байгаа.

Боловсруулаагүй түүхий арьсны экспорт, адууны шир, үхрийн ширний хувьд 0.5 сая ширхэг. Баяр наадмын үеэр боодог, хорхог хийсэн хонь, ямааны арьс бол 0.4 сая орчим. Нийт арьсны 10.2, бусад болон агуулах болон хаягдаж байгаа арьсны хэмжээ бол 9 орчим сая гэдэг ийм тооцоолол гарсан байгаа юм.

Эдгээр 4 томоохон төслийг бид бүхэн өнөөдөр голчлон танилцуулна.

Нэгдүгээрт, “Шинэ Ховд” аж үйлдвэрийн парк байгаа.

Хөрөнгө оруулалтын хувьд 118.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалттай. Үүнээс дэд бүтэц нь 36.2 тэрбум, барилгын хувьд 82.7 тэрбум, нийтдээ 2271 ажлын байр бий болгох. 1 сая ширхэг арьс, 3 мянган тоннын ноос, 300 тонн ноолуур. Ингээд бусад түүхий эдүүдийг боловсруулах хүчин чадалтай “Шинэ Ховд” аж үйлдвэрийн паркийн төсөл байгаа.

Хоёр дахь нь, Дархан арьс ширний цогцолбор байгаа. 25 га болон 180 га гээд хоёр төсөл байгаа. Үүн дээр 25 га-гийн мэдээллийг энэ дээр оруулсан байна.

516 тэрбум төгрөгийн нийт хөрөнгө оруулалт шаардлагатай. Үүнээс дэд бүтэц нь 119, барилга нь 397, нийтдээ 2300 орчим ажлын байр бий болгож, 4 сая богийн арьс, 400 мянган бодын арьс боловсруулах хүчин чадалтай үйлдвэр байгаа юм.

Эмээлтийн аж үйлдвэрийн парк 734.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай.

10 мянган ажлын байр бэлтгэх. Жилдээ 7 сая ширхэг арьс шир боловсруулах хүчин чадалтай арьс ширний үйлдвэр байгаа.

Дорнод аймагт байгуулагдах Зүүн бүсийн хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, технологийн парк нэртэй төсөл байгаа.

Энэ бол дэд бүтцийн хөрөнгө оруулалт 9.7 тэрбум, барилга нь 67.4 тэрбум, нийтдээ мянган ажлын байр бэлтгэх ийм 4 гол төслүүдийг өнөөдөр Та бүхэнд танилцуулна.

Дэлгэрэнгүй танилцуулгыг нь би товчлоод явчихъя гэж бодож байна.

Нэгдүгээрт Дархан арьс ширтэй холбогдолтой асуудлыг нэг талд нь гарга.

Хувийн хэвшлийн хийсэн бүтээн байгуулалтын үйл ажиллагааг одоогийн байгаа энэ дэд бүтцийн ажлуудыг бүгдийг нь мэргэжлийн байгууллагуудаар шалгуулаад энэ дээр хэчнээн хэмжээний хөрөнгө оруулалтууд ороод ямар хэмжээнд хийгдсэн байгаа вэ гэдэг дээр дүгнэлт гарга гэдэг чиглэл өгөгдсөн.

Энэ дагуу гурван яамны хамтарсан тогтоол гарч бид бүхэн ажлын хэсэг байгуулан ажилласан.

Барилга, хот байгуулалтын яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Эрчим хүчний яам гээд гурван сайдын тушаалтай ажлын хэсэг байгуулагдсан.

2023 оны 03 сарын 10-ны өдөр энэхүү ажлын хэсэг маань байгуулагдаад нэг сарын хугацаанд газар дээр нь очиж хийгдсэн 6 дэд бүтцийн ажлыг Барилга хөгжлийн төв, Эрчим хүчний төвийн нарийвчилсан үнэлгээгээр гаргуулж авсан.

Ингээд 03 сарын 11, 12-ны өдөр бүтэн очиж ажиллаад, 03 сарын 28-ны өдөр үндсэндээ дүгнэлтээ гаргаад, Хөгжлийн банк, хувийн хэвшлийн бүх туслан гүйцэтгэгч компаниуд, бүх хүмүүсийн оруулсан энэхүү ажлын хэсэг дээрээ дүгнэлтээ гаргаад бүгдийг нь гарын үсэг зураад баталгаажуулсан дүнг би Та бүхэнд танилцуулна.

Энэ бол Эрчим хүчний төв болон Барилга хөгжлийн төвийн яг өөрсдийнх нь гаргасан мэргэжлийн дүгнэлтийн санал байгаа юм.

Энэ дүгнэлт батлагдсанаас хойш 04 сарын 07-ны өдөр гарын үсгээ зураад бүх мэдээллүүдээ тодорхой болгоод явснаас хойш ер нь албан ёсны 7 удаагийн уулзалт, албан бусаар бараг 10 гаруй удаа ерөнхийдөө уулзаж ярилцсан.

Тэгээд ажлын хэсгийн Хөгжлийн банктай бид бүхэн янз янзын хувилбаруудаар хоорондоо мэдээллүүд солилцоод ажилласан. Энэ ажлын хэсгийн тоон мэдээллүүд энэ дээр оруулсан байгаа юм.

Тэгээд Барилга хөгжлийн төв болон Эрчим хүчний төвийн дүгнэлтээр дараах энэ 6 дэд бүтцийг үнэлсэн байгаа. Үүн дээр цахилгаан дамжуулах агаарын шугам дэд станцын бүтээн байгуулалтын

ажил байгаа. Энэ гүйцэтгэгч болохоор Сопремакс гэдэг компани. Төсөвт өртөг нь 13.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй.

Гүйцэтгэгчээс ирүүлсэн нь бид 8.1 тэрбум төгрөгийг оруулчихсан байна гэдэг санал гарсан.

Ажлын хэсгийн дүгнэлтээр 3.1 тэрбум төгрөгийн ажил хийгдсэн байна гэдэг дүгнэлт гарсан. Ажлын явц нь 24.3 хувьтайгаар энэ дээр гарсан байгаа.

Гадна дулаан, цэвэр, усан хангамжийн шугам сүлжээний дэд бүтцийн ажил байгаа. Энэ ажил дээр “Бурхант” гэдэг компани ажилласан. Төсөвт өртөг нь 14.3 тэрбум. Гүйцэтгэгчээс ирүүлсэн санал нь 8.7. Ингээд ажлын хэсгийн дүгнэлт 5.4 тэрбумыг үүнд оруулсан байна. Ажлын явц 46.6 хувьтай байна гэдэг дүгнэлтийг гаргасан.

Гадна холбоо дохиоллын ажлыг үндсэндээ гүйцэтгэлийн хяналтад бид бүхэн аваагүй. Энэ далд хийгдсэн үйл ажиллагаа байсан.

Технологийн уур үүсгэгч хоёр дээр дүгнэлт гаргаагүй.

Цэвэрлэх байгууламжийг “Тэгш констракшн” гэдэг компани гүйцэтгэсэн.

Төсөвт өртөг нь 41.2 тэрбум. Гүйцэтгэгчээс ирүүлсэн санал нь 16.3 тэрбум. Ажлын хэсгийн дүгнэлтээр 5.1 тэрбум төгрөгийг гүйцэтгэсэн байна. Ажлын явц нь 12.7 хувьтай гэдэг дүгнэлтийг гаргасан.

Үйлдвэрүүдийн гадна дулаан, ус хангамжийн ариутгах татуургын хос шугамын ажил байгаа. Үүнд төсөвт өртөг нь 16.3 тэрбум, гүйцэтгэгчээс ирүүлсэн

нь 11.4, эрчим хүчний үндэсний төвийн дүгнэлтээр 7.6 буюу 46.6 хувийн гүйцэтгэлтэй гэдэг ийм “Евро стандарт Танари” гэдэг компани гүйцэтгэсэн.

Ингээд бүх дэд бүтцийн ажлуудыг нь газар дээр нь очиж үзээд үндсэндээ дүгнэлтүүдийг гаргасан.

Дараагийн слайд дээр хоорондын харьцуулсан дүгнэлтүүд байгаа юм. Энэ дээр өөрийн төсөвт өртөг, гүйцэтгэгчийн санал, Үндэсний аудитын газраас дүгнэлт гаргасан тэрхүү дүгнэлт нь ажлын хэсгийн ажилласан дүнгүүдийг Байнгын хорооны гишүүдэд бүгдийг дэлгэрэнгүй хүргүүлсэн.

Цаашдаа гүйцэтгэх үлдэгдэл төсөвтэй холбогдолтой мэдээллүүдийг оруулсан байгаа.

5 сар гэхэд ажлын хэсгийн дүгнэлт гаргаад, түүнээс хойш Хүнс, хөдөө аж ахуйн яам, Хөгжлийн банк яг нэгдсэн байр суурьтайгаар саналаа илэрхийлээд хувийн хэвшлийнхнийг хэд хэдэн удаа хүлээсэн.

Хувийн хэвшлийнхэн төлөөлөн удирдах зөвлөлөө хуралдуулъя, тодорхой асуудлуудаа бид бүхэн ярилцаж байна гэдэг ийм байдлаар.

Тэгээд нэг, хоёр удаа албан бичгүүд өгөөд хугацаа хожих байдалтай явсаар байгаад 2023 оны 10 сарын 31-ний өдрийн уулзалтын тэр саналын дагуу 2024 оны 01 сарын 05-ны өдөр эцсийн байдлаар саналаа ирүүлсэн.

Энэ санал дээр гол агуулга нь Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны 12 сарын 31-ний өдрийн А27 тоот тушаалаар батлагдсан тэрхүү үнэлгээг дахин үнэлэх саналаа ирүүлсэн.

Ингэхдээ аудитын үнэлгээний дүнг суурь үнэлгээ болгож тооцъё. Зах зээлийн үнийн индексээр дахин тооцож, үнэлгээг шинэчлэх гэдэг энэ байдлаар буюу ажлын хэсгийн саналаасаа ухарсан байдалтай байр сууриа илэрхийлсэн.

Ажлын хэсгийн үнэлгээтэй санал нийлэхгүй байгаа бөгөөд өөрсдийн үнэлгээний олон улсын стандарт, Үнэлгээний тухай хууль, Аудитын тухай хууль гээд эдгээр хуулиудтай уялдуулж дахин үнэлж Хөгжлийн банканд шилжүүлнэ гэдгээ илэрхийлсэн мэдээллийг өгсөн.

Мөн дээрээс нь Хөгжлийн банканд газраа шилжүүлэхдээ нэг га газрыг нэг тэрбум төгрөгөөр тооцон тодорхой хэсгийг шилжүүлнэ гэсэн агуулгаар байр сууриа илэрхийлсэн.

Тэгээд ажлын хэсэгтээ хийж хийж буй хэлцлийн улмаас тодорхой асуудлууд тулгарсан.

Түүнтэй холбогдолтой асуудлыг Засгийн газрын шийдвэрээр хэрэгжүүлэх иймэрхүү саналуудыг илэрхийлсэн гээд.

Ингээд яг ерөнхий тойм утгаар нь хэлэх юм бол ажлын хэсгийн дүгнэлт, энэ зүйлүүд дээр бүх талаасаа нийлээд гарын үсгээ зураад хүлээн зөвшөөрөөд явж байна гээд.

Яг ингээд хэлцэл юмнуудаа хийе гэдэг энэ байр суурь дээрээ очихдоо тодорхой хугацаа аваад ингэж явсаар байгаад өнөөдөр хамгийн эцсийн байдлаар хүлээн зөвшөөрөхгүй. Бид дээрээс нь газраа нэмж үнэлнэ, аудитын дүгнэлтээрээ явна.

Одоогийн үнэ ханш дээр дахиж нэмэгдүүлнэ гэдэг ийм ухарсан байр сууриудыг илэрхийлээд үндсэндээ

нөхцөл байдал ойлголцох хэмжээнд очихгүй болоод байгааг Байнгын хорооны гишүүдэд илэрхийлье.

Хөгжлийн банк болон бид бүхэн ярилцаад үүн дээр тодорхой ойлголцлын түвшинд хүрэх боломжгүй байгаа учраас шаардлагатай тохиолдолд энэхүү бүтээн байгуулалтын ажлыг төр үндсэндээ өөрсдийн бүрэн эрхийн хэмжээнд шилжүүлэн аваад энэ ажлыг гүйцэтгэх, тусгай хэрэгцээнд авах хүртэлх арга хэмжээг авбал ямар вэ гэдэг иймэрхүү нөхцөл байдал руу хүртэл орж байна.

Тэгэхээр өнөөдөр Байнгын хорооны гишүүд Та бүгдийн санал бодлыг үүн дээр солилцье.

Бид бүхэнд үүсэж байгаа хэд хэдэн эрсдэлүүд байгааг Та бүхэндээ би хэлэх нь зөв өө.

Төслийн талбайд хийгдсэн бүтээн байгуулалтын дэд бүтцийн ажил дөрөв дэх жил рүүгээ орж байна.

Тэгэхээр энэ дэд бүтцийн ажлыг ойлголцохгүй явсаар байвал цаашдаа ашиглах боломжгүй болох өндөр эрсдэлүүд байгаа. ТЭЗҮ болон байгаль орчны үнэлгээтэй холбогдолтой асуудлууд, энэ дэд бүтцийн цэвэрлэх байгууламжийн зураг, төсвийн ажлууд үнэгүйдэх асуудлууд байна.

Тийм учраас энэ дээр тодорхой шийдлүүдийг зайлшгүй гаргах шаардлагууд тулгарсан гэдгийг хэлэх нь зөв болов уу.

Энэ нь Дархан арьс, ширтэй холбогдолтой хоёр дахь асуудал байгаа.

Гурав дахь асуудал нь, “Шинэ Ховд” үйлдвэр, технологийн парктай холбогдолтой мэдээлэл байгаа.

“Шинэ Ховд” үйлдвэр, технологийн паркийн үндсэндээ 5 дэд бүтцийн ажил өнгөрсөн 2023 онд хийгдэж эхэлсэн байгаа. 2024 онд дуусах төсөв нь улсын төсөвт орсон. Дэд бүтцийн ажлууд нь хийгдээд ажлууд нь үргэлжлээд явж байна.

Парк байгуулах өнөөгийн байдлууд байна. Уурын, дулааны дэд станц шугам сүлжээний дэд бүтцийн нөхцөл байдлууд 2023 онд хийгдэж байгаа. 23 хувийн гүйцэтгэлтэй байна.

Авто зам, явган хүний зам, гэрэлтүүлэг, ногоон байгууламж гээд дэд бүтцийн ажлууд, саарал ус зайлуулах, усан хангамж, ариутгах татуургыг цуглуулах гол шугам сүлжээний зураг төсвүүд иймэрхүү байдалтай байна.

Цахилгаан хангамжийн дэд станц, шугам сүлжээний зураг төсөв боловсруулах дэд станц 30.0 хувийн гүйцэтгэлтэй.

Мэдээлэл холбооны сүлжээ, зураг төсөв боловсруулах, барих ажлын бүтээн байгуулалтын ажил 60.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Түүхий эдийн цэвэрлэх байгууламжтай холбогдолтой асуудал. Энэ хуучин тоног төхөөрөмжийг ашиглах боломжгүй гэдэг мэргэжлийн байгууллагын дүгнэлт гарсан учраас 2024 оны төсөвт цэвэрлэх байгууламжийг шинээр байгуулахаар болсон байгаа.

Дорнод, Зүүн бүсийн хөдөө аж ахуйн аж үйлдвэрийн паркийн төслийн дэд бүтцийн 9.7 тэрбумын төсвийг 2023, 2024 оны улсын төсвүүдэд тусгахаар Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас хүргүүлсэн.

2024 оны улсын төсөвт тусгагдаж чадаагүй байгаа. Одоогоор зураг төсвийн ажлуудыг дуусгах байдалтайгаар үргэлжлээд явж байна.

Дараагийн төсөл “Эмээлт эко аж үйлдвэрийн парк”-ийн төлөөллүүд энд ирсэн байгаа.

Тэгэхээр тодорхой нэмэлт мэдээллүүдийг Та бүхэндээ өгөх байх.

Ямартай ч хүнс Хөдөө аж ахуйн яамнаас тодорхой энэхүү төслийг дэмжиж явуулна гэдэг байр сууриа илэрхийлээд Засгийн газрын хуралдаанаар оруулаад ажлууд нь үндсэндээ төлөвлөгөөний дагуу явагдаж байна.

2024 оны 2 сард техник, эдийн засгийн үндэслэл албан ёсоор эхний байдлаар бэлтгэж дуусна.

Ингээд энэ ондоо гэрээгээ байгуулаад үйл ажиллагааг нь эхлүүлэхээр ажиллаж байна. Эмээлт.

“Шинэ Ховд” 2024 онд хийгдэх томоохон ажлууд нь улсын төсвийн 11.3 тэрбумын хөрөнгөөр дэд бүтцийн ажил 100 хувь дуусахаар үндсэндээ тусгагдсан.

Улсын төсвийн 1.9 тэрбум төгрөгийн хөрөнгөөр цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулахаар ажиллаж байна. “Шинэ Ховд” аж үйлдвэрийн паркийн хувьд.

Дарханы хувьд улсын төсвийн 11.9 тэрбумыг тусгасан. Үүнд цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмжийн худалдан авалт, гүйцэтгэгчийг шалгаруулах байдлаар тусгагдсан.

Дорнодын хувьд зураг төсөв бусад ажлууд нь 2024 ондоо дуусгана.

Эмээлтийн хувьд техник, эдийн засгийн үндэслэлийг Дэлхийн банкнаас хүлээн авна. Дэлхийн банк дээр зээлийн хэлэлцээр байгуулж үйл ажиллагааг нь эхлүүлэх гэсэн ийм ерөнхий байдалтай төслүүд ажиллаж байна. Баярлалаа. Та бүхэнд.

Г.Ганболд: М.Ганхүлэг сайдад баярлалаа.

Мэдээлэлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд нэрээ өгье.

Ц.Туваан гишүүнээр тасаллаа.
Н.Наранбаатар гишүүнээр тасаллаа.
Д.Батлут гишүүн асуулт асууя.

Д.Батлут: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Уг нь арьс ширний үйлдвэрлэлтэй холбоотой хөдөө аж ахуйг дэмжих төсөл нь Монголд их хэрэгтэй төслүүд л дээ. Харамсалтай нь яригдаад 10 жил боллоо.

Тэгээд 10 жилийн хугацаанд ямар ажил хийгдсэн бэ гээд харахаар тодорхой хэмжээгээрээ бүтээн байгуулалтын ажил хийгдсэн ч гэсэн өнөөдөр хүртэл хэрүүл маргаантай, хоорондох дотоодх ойлголцлоо олж чадаагүй, бүтээн байгуулалтын ажил хийгдэх гэхээсээ илүүтэй нэг шүүхийн хаалга татсан хэлбэр дээр л зогсож байна.

Тэгэхээр энэ 10 жилийн хугацаанд бид энэ томоохон үйлдвэрлэлүүдийг байгуулаад ашиглах боломж бололцоо байсан уу гэвэл байсан.

Тэгэхээр өнөөдөр бид яагаад энэ түвшинд хүрчхэв гэдгээ нэг бодож үзэх хэрэгтэй гэж харж байгаа.

Тэгээд би Та бүхнээс нэг хэдэн асуулт асууя.

Энэ арьс ширний үйлдвэр, хөдөө аж ахуйн чиглэлийн бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрийг заавал төр хийх ёстой юм уу, заавал төр хийх ёстой юм уу?

Нэг ёсондоо төрийн хөрөнгө оруулалттай ажил хийгдэхээрээ л заваарсан хэрүүл маргаан болоод засаг төр дамжсан, хүн хүний сонирхол орсон асуудлууд болж хувирдаг.

Яг энэ чинь үндсэндээ гацаа болгож байгаа юм. Үүнийг хийчих, энэ томоохон хөрөнгө оруулалтуудыг хийгээд ажиллах хувийн хэвшил Монголд байхгүй байгаа юу? Гаднын хөрөнгө оруулагч нар байхгүй байгаа юу?

Би түрүүн мэдээллүүдээс авч үзэх юм бол 8.5 сая арьс шир боловсруулах, 10 мянган тонн ноос, ноолуур боловсруулах хэмжээний хүчин чадлыг бий болгоно гээд зорьчихсон байна. Боломжийн зах зээл гэж харж байгаа.

Тэгээд бид нар ингээд нэг тийм төр аливаа ажилд оролцохоороо л заавал нэг завааруулсан, ужгирсан, үр дүн гардаггүй. Одоо больчих л доо. Сүүлдээ уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрээс дэд бүтцийн зардалд гээд 50 тэрбум орчим төгрөг авна гэнэ.

Энэ чинь болж бүтэж байгаа ганц үйлдвэр саагаад л байж байх юм уу бид.

Тэгээд тэр баялаг бүтээж байгаа уурхайчдын асуудал, өмнө нь тулгамдаж байгаа асуудал зөндөө байдаг. Тэр орон нутагт нь ажил амьдралд нь тулгамдаж байгаа олон асуудал байсаар байтал бид нэг бүтэх бүтэхгүй нь мэдэгдэхгүй тодорхойгүй байгаа төсөл дээр л 50, 60

тэрбумаар нь аваад л байж байх юм уу? Больчихье л доо энэ чинь одоо.

Харин тэр хийж чадах гадна, дотнын хөрөнгө оруулагчдыг нь судалж байгаад хийх юм бол маш хурдан хугацаанд чанартай, хямд өртгөөр босно гэж харж байгаа.

Тэгээд бид үндсэндээ 10 жил хий хоосон тоо хөөж ярьсан, энд тэнд очсон, маргаан хөөж ярьсан, тэр нь ч болохгүй, энэ ч болохгүй байгаа, ингэлээ тэглээ гэдэг л.

Ингэж арга хэмжээ авах гэж оролдож байна, тэгж арга хэмжээ авлаа, тэгж уулзлаа л гэсэн яриа хэлцлээс өөр юмгүй л сууж байна шүү дээ.

Байнгын хорооноос гарсан тогтоол байгаа. 2022 оны 10 сарын 26-ны өдрийн 08 тоот. Энэ дээр тодорхой заачихсан. Тусдаа дэд бүтэц бүхий төрийн өмчит үйлдвэрийн газар байгуулах шийдвэрийг гаргаж техник, эдийн засгийн үндэслэлээ, зураг төсөв боловсруулж байгааг таслан зогсоож, гаргасан шийдвэрийг Улсын Их Хуралд танилцуулах гээд заачихсан байна шүү дээ.

Улсын Их Хурал чинь шийдвэрээ гаргачхаад байхад, Байнгын хороо шийдвэрээ гаргачхаад байхад яагаад үүнийг хэрэгжүүлж ажиллахгүй байгаа юм бэ?

Бид үүнийг ахиад шинээр хувийн хэвшлийн оролцоотой шийдэх боломж бололцоо байгаа юм уу? Нөхөд өө.

Г.Ганболд: Ажлын хэсгийн 3 номерыг өгье.

М.Ганхүлэг: Д.Батлут гишүүний асуултад хариулъя.

Тантай агуулгын хувьд би санал нэг байгаа. Төр ерөөсөө аж үйлдвэрийн паркуудын бүтээн байгуулалтын барилгын ажлуудыг огт хийхээргүй байгаа.

Аж үйлдвэрийн паркийнхаа тухай хуулиараа дэд бүтцийн ажлуудыг үндсэндээ гүйцэтгэж, төр дэд бүтцийг ажлаа ашиглана, хувийн хэвшил, олон улсын байгууллага, хөрөнгө оруулагч нар өөрсдийн үйл ажиллагаа явуулах тэр боломжийг олгох гэдэг энэ байр суурь дээрээ бид бүхэн байгаа юм.

Яг таны дэвшүүлж байгаа хувийн хэвшлээ дэмжиж, бие дааж ажиллахыг нь дэмжиж, энэ үйл ажиллагаа эхэлсэн юм байна лээ. Энэ Дархан арьс ширний цогцолбор дээр байгаа 180 га газрын энэ бүтээн байгуулалтын ажил хувийн хэвшил Хөгжлийн банкнаас тодорхой хэмжээний зээлээ аваад энэ ажлууд нь эхэлсэн.

Өнөөдөр яг үнэндээ би танд ажлын хэсгийн явцын уулзалтын үр дүн, энэ юмнуудаа танилцуулахад үнэхээрийн хоорондоо ойлголцож үр дүн гаргахад ингэж оролдлогуудыг хийсэн. Маш олон удаагийн уулзалт хийсэн. Гар хөлийн үсгээ зураад, за зү болоод явдаг. Эргээд ирэхдээ дахиад тэс өөр бичиг бариад ирдэг, дахиад тэс өөр агуулга болоод ирдэг.

Үнэхээрийн нэг жилийн хугацаанд ойлголцох гэж нэлээн чармайж ажилласан.

Тэгээд үүний цаана давхар явж байгаа тэр эрүүгийн тодорхой асуудлаар шалгагдаж байгаа энэ асуудлуудыг нь хурдлуулах, тодорхой нэг талд нь гаргах гэдэг хууль хяналтынх нь чиглэлийн юмыг нь эрчимжүүлэх шаардлагууд таны саяын хэлж байгаагаар байгаа.

Тэгэхээр энэ төслийн үйл ажиллагаа цаашдаа эрчимтэй явуулахад энэ талаас нь харахгүй бол зөвхөн тойрч суугаад хэлцэл хийгээд явахад үнэхээр асуудал мухардаж байгаа тухай би яг бодитоор нь өнөөдөр танд танилцууллаа.

Тэгэхээр Хүнс, хөдөө аж ахуйн яам болон Монгол Улсын Засгийн газар энэ арьс, ширний үйлдвэрийн байгууламж огт барихгүй гэдэг дээрээ байгаа. Дэд бүтцийн ажлуудыг нь хийгээд энэ дээр аж ажиллая.

Дээрээс нь хэлж байгаа тэр Туркүүд, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөрөнгө оруулагч нар, Италиуд өөрсдөө энэ дэд бүтцийн ажлуудыг ирж үзээд хэрвээ Та бүхэн яг тодорхой асуудлаа шийдчих юм бол хөрөнгө оруулалтаа хийе гэдэг саналуудыг удаа дараа хийгээд байгаа юм.

Тэгээд Хөгжлийн банк болон бид бүхний байр суурь маш тодорхой. Авъя. Авахдаа мэргэжлийн байгууллагуудын дүгнэлт гаргуулчихъя гэсэн. Тэд дүн, дүгнэлтээ гаргасан. 21.4 тэрбум төгрөг хийсэн байна гэдгээ тогтоогоод бүгдээрээ гарын үсгээ зурчихсан. Яг одоо ингээд хэлцлээ хийе гэхээр хугацаа хождог. Ингээд ийм байдалд хүрчхээд байгаа учраас энэ асуудал дээр яг тодорхой зоригтой алхам авах нь зөв үү, яах вэ гэдэг тухай бид бүхэн ярих болсон байна л гэдэг байдлаар ажлын хэсэг танилцуулаад байгаа юм. Тийм.

Г.Ганболд: Д.Батлут гишүүн тодруулъя. Д.Батлут гишүүний микрофоныг өгье.

Д.Батлут: Харин тийм. Одоо ингээд л харамсалтай л даа.

10 жил болж байгаа учраас. Тэгээд л 10 жилийн өмнө гарсан нэг ТЭЗҮ нь одоо хэд болчихсон явж байгаа юм. Мэдэхгүй. Жил өнгөрөх тусам л ТЭЗҮ, үнэлгээ, технологи гээд л бүх зүйл өөрчлөгдөж байгаа.

Одоо бид нар ингээд барьж байгууллаа гэж бодоход ямар хэмжээний үйлдвэр байгуулагдах юм бол. Сайн мэдэхгүй байна. Би лав. Магадгүй технологийн хувьд 10 жил хоцорчихсон тийм технологи байж байх уу? Энэ дээр нэг хариулт өгөөдхөөрэй.

Бид нарын ажлаа төлөвлөхгүйгээс. Дээрээс нь олон талт арга барилаар ажиллахгүйгээс болоод л бүхий л зүйл гацаатай, хоцрогдчихсон, хэрүүл маргаантай шүүхийн шийдвэр дээр л явж байна шүү дээ.

10 жил хайран хугацаа байгаа биз. Тэгээд дээрээс нь үргүй баахан зардал гаргачихсан.

Тэр нэг технологийн хувьд ямархуу.../минут дуусав/

Г.Ганболд: Санал хэлсэн үү? 3 номерын микрофоныг өгье. 3 номер.

М.Ганхүлэг: Д.Батлут гишүүний асуултад хариулъя.

Эрсдэл байгаа. 4 дэх жилдээ орж байгаа юм. Яг энэ дэд бүтцийн ажлууд хийгдээд. Тэгээд энэ барилгын тодорхой дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг цаашлаад энэ хэвээрээ үргэлжлэх юм бол өөрөө ашиглахгүй байх эрсдэл рүү хүртэл орно.

Яг одоо бид Италитай хамтарсан, энэ газар дээр нь очиж үзэх, тодорхой техник, эдийн засгийн үндэслэлүүдийг

гаргах чиглэлийн ажлууд дээр зөвлөмжүүдийг аваад ажиллаж байгаа.

Үндсэндээ одоогийн явж байгаа энэ төслийг үргэлжлүүлээд ажиллуулаад явуулахад олон улсын стандартад нийцсэн парк байгуулаад явах боломжтой гэдэг дүгнэлт гараад явж байна. Тийм.

Г.Ганболд: Т.Энхтүвшин гишүүн асуулт асууя.

Т.Энхтүвшин: Баярлалаа. Дархан арьс ширний цогцолбор байгуулах энэ асуудал 2020-2024 оны Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт байж байгаа. Том зорилт байж байгаа.

2022 оны 06 сарын 15-нд Үйлдвэржилтийн байнгын хорооны тогтоол гарсан байгаа. Засгийн газар луу чиглэл өгсөн.

Түүнээс хойш 1 жил 6 сарын хугацаа өнгөрч байна. Тэгээд хамгийн гол нь бид энэ 1 жил 6 сарын хугацаанд энэ Байнгын хорооны тогтоолоор өгсөн чиглэл маань яаж хэрэгжсэн байгаа юм, хэрэгжилтийг нь яаж хангаж явж байгаа юм, ямар ажил нь эхлээд явж байгаа юм гэдэг юмнуудаа л нэлээн тодорхой л ярих хэрэгтэй байна л даа.

Тухайлбал, бид “Ховд үйлдвэр, технологийн парк” гээд саяхан Монгол Улсын Засгийн газраас үйлдвэр, технологийн парк болгоод зарлачихсан.

Ховдын цэвэрлэх байгууламж баригдсан юм уу, баригдаагүй юм уу? Тоног төхөөрөмж нь оччихсон. Тэнд олон жил гадаа байж байгаа.

Энэ ажил угсрагдсан юм уу, хийгдсэн юм уу? Үйлдвэр, технологийн паркийн үйл ажиллагаа хөдөлсөн юм уу, хөдлөөгүй юм уу?

Түүн дээр нь хэчнээн аж ахуйн нэгж, байгууллага газар аваад хэчнээн арьс, ширний үйлдвэр, ноос, ноолуур угаах үйлдвэр барьж байгаа юм. Энэ жил 6 сарын хугацаанд. Энэ дээр нэг хариулт авах хэрэгтэй байна.

Хоёрдугаарт, бид бас Засгийн газарт чиглэл өгсөн байж байгаа. Эмээлт аж үйлдвэрийн паркийг яаралтай барьж эхлүүл ээ. Дэлхийн банк дэмжиж байгаа гээд.

Тэгээд зураг төсөл нь хийгдсэн юм уу, техник эдийн засгийн үнэлгээ нь хийгдсэн юм уу, үйл ажиллагаа нь эхэлсэн юм уу? Энэ асуудал дээр бас нэг хариулт авах хэрэгтэй байж байна.

Гурав дахь асуудал бол Дарханы арьс, ширний үйлдвэр байна. Дэд бүтэц нь хийгдсэн. Тодорхой хугацаагаар.

Тэгээд одоо энэ хөрөнгүүд Хөгжлийн банкн дээр байгаад байна уу, Хүнс, хөдөө аж ахуйн яам мэдээд байна уу?

Нөгөө төрийн өмчтэй нэг компани байгуулчихсан байсан. Давхар. Төрөөс цалин аваад. Түүний үйл ажиллагаа зогссон уу, зогсоогүй юу?

Тэр дахиад юу гэдэг юм 2 тэрбум төгрөг гаргаад дахиад Дархан дээр зураг төсөл хийгээд явж байгаа шүү дээ. Энэ ажил чинь зогссон уу, зогсоогүй юу? Энэ дээр нэг тодорхой хариултуудыг хэлж өгмөөр байна.

Тэгээд ер нь цаашдаа энэ Дарханы арьс, ширний үйлдвэрийг цаашдаа яах зорилготой байгаа юм. Үнэхээр юу гэдэг юм худалдаж аваад хувийн хэвшилд нь өгөөд төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд цаашдаа явуулах юм уу.

Энэ дээрээ Хүнс, хөдөө аж ахуйн яам жоохон дорвитой ажиллах хэрэгтэй байна. Зүгээр л бид жил 6 сарын өмнө л асууж ярьж байсан. Цагдаа дээр шалгагдаж байгаа, Авлигалтай тэмцэх газар шалгагдаж байгаа, үнэлгээ хийж худалдаж авах гэж байгаа гэдэг л яригдаж байсан. Одоо ч гэсэн жил 6 сарын дараа сонсоход энэ асуудал яригдаж байна шүү дээ.

Тэгээд яах ёстой юм, ямар ажил хийгээд явж байгаа юм гэдэг дээр л та хэд маань нэг гүйцэтгэлээ дорвитой гаргаад яриад өгөөч.

Байнгын хорооны тогтоолын биелэлтийг л сонсож байгаа шүү дээ. Энэ жил 6 сарын хугацаанд Та бүхэн маань яг юу хийсэн байна аа. Тогтоол хэрэгжсэн байна уу, хэрэгжээгүй байна уу?

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан ажлууд чинь хэзээ дуусах юм?

Ийм гурван асуулт дээрээ тодорхой хариултыг авчихмаар байна.

Г.Ганболд: Ажлын хэсгийн 3 номер.

М.Ганхүлэг: Т.Энхтүвшин гишүүний асуултад хариулья.

“Шинэ Ховд” аж үйлдвэрийн паркийн 5 дэд бүтцийн ажил 2023 онд 30.0 хувь, 23.0 хувь гэсэн гүйцэтгэлтэйгээр хийгдээд эхэлсэн байгаа.

2024 онд бүрэн дуусахаар үлдэгдэл санхүүжилт нь улсын төсөвт ороод хийгдээд явж байна.

Энэ дэд бүтцийн ажлууд тодорхой хэмжээнд үндсэндээ ажлууд нь эхлээд дуусахаар ажил нь явагдаж байгаа гэдгийг хэлбэ.

Мөн дээрээс нь цэвэрлэх байгууламжтай холбогдолтой асуултыг асуулаа. Цэвэрлэх байгууламжийн хувьд хуучин байсан тоног төхөөрөмжийг ашиглах боломжгүй гэдэг дүгнэлт гарсан.

Тийм учраас 2024 оны улсын төсөвт цэвэрлэх байгууламжийг шинээр хийхээр орсон байгаа.

“Шинэ Ховд” аж үйлдвэрийн паркийн дэд бүтцийн ажлууд нэг үеэ бодвол эхлээд тодорхой ажлын гүйцэтгэлүүд нь хийгдээд явж байна.

Энэ онд энд үйл ажиллагаагаа явуулах аж ахуйн нэгжүүдийн сонгон шалгаруулалтуудыг зохион байгуулагдаж барилга, байгууламжийн ажлууд эхлүүлнэ.

Эмээлтийн техник, эдийн засгийн үндэслэл нь хийгдэж байгаа. “Эмээлт аж үйлдвэрийн парк”-ийнхан хүрэлцэн ирсэн учраас нэмэлт мэдээллийг Та бүхэнд дэлгэрэнгүй өгөх нь зөв байх.

Дэлхийн банкны санхүүжилтээр хийгдэх техник, эдийн засгийн үндэслэлийг 2 сард дуусгахаар ажиллаж байна. Бусад төлөвлөлтийн ажлууд явагдаж байна.

Дархан арьс, шир дээр. Хөгжлийн банкныхан яг тэр эд хөрөнгөтэй холбогдолтой асуудал дээрээ нэмэлт тайлбар өгөх нь зөв байх.

Нэг жилийн хугацаанд Байнгын хорооны дүгнэлтийн дагуу ажлын хэсэг байгуулагдаад саналаа маш тодорхой

болгосон байгаа. Саналаа маш тодорхой болгосон байгаа.

Одоогийн хийгдсэн байгаа дэд бүтцүүдээ бүгдийг нь мэргэжлийн байгууллагуудаар үнэлүүлсэн. Энэ үнэлгээгээрээ хүлээж авахад бэлэн байгаагаа удаа дараа илэрхийлсэн. Хамтарсан ажлын хэсгийн дүгнэлтүүд дээрээ гар хөлийн үсгээ зураад хүлээж авахад бэлэн байгаа.

Хүнс, хөдөө аж ахуйн яамны зүгээс яг хууль эрх зүйн хувьд Хөгжлийн банк болон хувийн хэвшлийн хоорондын харилцаанд шууд оролцохгүйгээр саналаа илэрхийлж, цаашдаа яах вэ гэдэг энэ агуулгаар Ажлын хэсэг дээрээ байр сууриа илэрхийлээд явж байгаа.

Тэгэхээр одоогийн байгаа дэд бүтцийн ажлыг хувийн хэвшил дээрээ байгаа. Үүнийг Хөгжлийн банк руу шилжүүлэн авах дээрээ тодорхой саналын зөрүүтэй байдлууд дээрээ яг эцэслэсэн энэ дүнгүүдээ тохирох дээр ярьсан асуудлаасаа ухраад байгаа ийм асуудлууд л үүсчхээд л байгаа юм л даа.

Тэгээд Эмээлт болон Хөгжлийн банкныхан нэмэлт тодорхой мэдээлэл өгчих нь зөв байх.

Г.Ганболд: Тодруулъя. Т.Энхтүвшин гишүүн.

Т.Энхтүвшин: Би түрүүн нэг асуулт асуусан.

Дарханы арьс, ширний үйлдвэр дээр нэг төрийн өмчит компани байгуулчхаад байгаа шүү дээ. Тэр чинь татан буугдсан юм уу, татан буугдаагүй юм уу?

Хоёрдугаарт, 5 тэрбум төгрөгөөр. Би түрүүн 2 тэрбум төгрөг гээд хэлчих

шиг болсон. 5 тэрбум төгрөгөөр хийгдэж байгаа тэр зураг төслийнх нь ажил зогссон юм уу, зогсоогүй юм уу? Заавал юу гэдэг юм хувийн хэвшил хийгээд, тэгээд Хөгжлийн банкны асуудалтай холбогдуулаад, цагдаагийн байгууллага, холбогдох хууль хяналтын байгууллагаар шалгагдаж байхад нь дахиж төрийн өмчтэй компани байгуулаад төрөөс санхүүжүүлээд, дахиж шинээр газар аваад, дахиж дэд бүтэц хийгээд, дахиж зураг төсөл хийх тийм шаардлага байгаа юм уу, байхгүй юм уу?

Тэр татан буугдсан юм уу, татан буугддаг юм уу? Үүнийг нь Байнгын хорооны тогтоол дээр татан буулга гэсэн байж байгаа шүү дээ. Зураг төслийн үйл ажиллагааг зогсоох, үйл ажиллагааг нь татан буулга гэдэг асуудал тавьсан. Энэ дээр нэг хариулт хэлээдхээч. Жоохон тодорхой хэлээд явчихмаар байх юм.

Г.Ганболд: Ажлын хэсгийн 3 номер.

М.Ганхүлэг: Т.Энхтүвшин гишүүний асуултад хариулья.

Байнгын хорооны тогтоолын тогтоол дээр 2023 оны 01 сарын 18-нд яг саяын заалт дээр өөрчлөлт оруулсан.

Татан буулгах гэдэг энэ агуулгыг нь аваад, энэ асуудлыг үндсэндээ нэгдсэн зохион байгуулалтад оруулаад тодорхой шийдэл гаргах гэдэг ийм байдлаар өөрчилсөн байгаа.

Тэгээд төрийн өмчит компанийн үйл ажиллагаа саяын тэр зураг төсөвтэй холбогдолтой 2.4 тэрбум төгрөгийн асуудал байгаа. Энэ зураг төсвүүдийн үйл ажиллагааг түр зогсоосон байдалтай байгаа.

25 га дээрх энэ бүтээн байгуулалтын ажлуудыг шаардлагатай тохиолдолд нэгдсэн зохион байгуулалтад оруулаад 205 га-г нь төлөвлөлт болгоод, нэг, хоёр үе шаттайгаар явуулах нэг төрлийн хувилбар байж болох юм гэдэг байдлаар Хүнс, хөдөө аж ахуйн яам судлан ажиллаж байгаа.

Яагаад гэх юм бол энэ 180 га дээрх бүтээн байгуулалтын асуудлыг бид хараад яг үнэндээ тодорхой байр сууриа илэрхийлээд.../минут дуусав/

Г.Ганболд: Ж.Батжаргал гишүүн асуулт асууя. П.Сайнзориг дарга. Ажлын хэсгийн 2 номер. Ажлын хэсгийн 1 номерын микрофоныг өгье. 1 номер.

Б.Мягмар: Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны эрхэм гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

“Эмээлт эко аж үйлдвэрийн парк” хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Мягмар байна.

Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 08 тоот тогтоолын 1.3 дахь заалтад Арьс, ширний үйлдвэрүүдийг Улаанбаатар хотоос нүүлгэн шилжүүлэх бодлогын хүрээнд түүхий эдийн бодит нөөц, үйлдвэрүүдийн чиглэл, хүчин чадлын хэрэгцээг тооцож “Эмээлт эко аж үйлдвэрийн парк”-ийн техник, эдийн засгийн үндэслэлийг шинэчлэн боловсруулах бүтээн байгуулалтыг хэрэгжүүлж ажиллах чиглэлийг өгсөн.

Энэ хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 5 сарын 24-ний өдрийн 193 тоот тогтоолыг Засгийн газрын хуралдаанаар орж батлуулсан байгаа.

Энэ тогтоол дотор “Эмээлт эко аж үйлдвэрийн парк”-ийн инженерийн суурь дэд бүтцийг Улаанбаатар хотын өрсөлдөх чадвар, нөхөн сэргээлтийг дэмжих төслийн хүрээнд санхүүжүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаад дотоодын хөрөнгө оруулалтын бусад эх үүсвэрүүдээс санхүүжүүлэхийг холбогдох салбарын сайд нар.../минут дуусав/

Г.Ганболд: 1 номерын микрофон гүйцээж хариулъя. 1 номер.

Б.Мягмар: Түүнтэй холбоотойгоор төслийн бэлтгэл ажлыг хийж, техник, эдийн засгийн үндэслэлийг төслийн хүрээнд хийж байгаа.

Техник, эдийн засгийн үндэслэл бол үндсэндээ эхний хоёр шатны тайланг сонссон.

2024 оны 2 дугаар сард эцсийн тайм техник, эдийн засгийн үндэслэлийг хүлээж авахаар бэлтгэл хангаж байгаа.

Төсөл маань үндсэндээ төслийн ажлын хэсгийг бодлого зохицуулалт салбар, хоорондын уялдаа холбоог хангаж ажиллах ажлын хэсгийг Нийслэлийн Засаг даргын А/861 тоот тогтоолоор Нийслэлийн Засаг даргын нэгдүгээр орлогчоор ахлуулсан зохион байгуулалтыг зохицуулалтыг хийх ажлын хэсэг ажиллаж байгаа.

Энэ төсөл маань үндсэндээ 4 бүрэлдэхүүн хэсэгтэй байхаар төлөвлөгдсөн байгаа.

Үүний нэгдүгээр бүрэлдэхүүн хэсэг нь “Эмээлт эко аж үйлдвэрийн парк”-ийн дэд бүтцийн асуудал буюу засаглал.

Хоёрдугаар бүрэлдэхүүн нь, Хан-Уул дүүргийн 20 дугаар хороонд үйл ажиллагаа явуулж байгаа арьс, ширний үйлдвэрүүдийг нүүлгэн шилжүүлэх, тухайн үйлдвэрүүдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх.

Мөн бүрэлдэхүүн гуравдугаар хэсэгт Хан-Уул дүүргийн 20 дугаар хороонд үйл ажиллагаа явуулж байсан үйлдвэрүүдийн үлдсэн газрыг нөхөн сэргээх, Туул голын ай сав, хөрсний бохирдлыг нөхөн сэргээх бэлтгэл ажил.

Мөн дөрөвдүгээрх бүрэлдэхүүн хэсэгт нь төслийн хяналт, үнэлгээний хэсэг байгаа.

Ингээд төслийн бэлтгэл ажлын хүрээнд нүүлгэн шилжүүлэлтийн стратегийн төлөвлөгөөг боловсруулах ажил явагдаж байна.

Энэ бол 2 дугаар сард дуусахаар бэлтгэл хангаж байна. Бид нарын урьдчилсан байдлаар байгаль орчин. Энэ “Эмээлт эко аж үйлдвэрийн парк”-ийн төслийн хүрээнд байгаль орчны асуудлаар Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр олон улсын санхүүгийн корпораци холбогдох бичиг баримтуудыг хамтарч хийж байгаа.

Ингээд суурь гурван баримт бичигт 95.0 хувийн гүйцэтгэлтэй бэлтгэл ажил хангагдаж байгаа.

Түүнтэй холбоотойгоор Хот төлөвлөлт, судалгааны институт паркийн ерөнхий төлөвлөгөөний тодотголыг хийх бэлтгэл ажил.

Ерөнхийдөө Хан-Уул дүүргийн 20 дугаар хороонд үүссэн нөхцөл байдлыг “Эмээлт парк” дээр давтахгүйн тулд бид паркийг тойрсон хамгаалалтын ногоон зурвасыг хийх бэлтгэл ажлыг Хот

төлөвлөлт, судалгааны институт дээр хийгдэж байгаа.

Ингээд бид бүхэн ажлын төлөвлөлтөөр 2024 оны хаврын чуулганаар зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах төлөвлөлттэй ажиллаж байгаа.

Парк дээр үйлдвэрийн нөхцөл байдлыг Хүнс, хөдөө аж ахуйн яам болон арьс, ширний үйлдвэр эрхлэгч нар буюу Монголын арьс ширний холбоотой паркийн хүчин чадлыг урьдчилсан байдлаар төлөвлөж тохиролцсон байгаа.

Үүнд нэгдүгээрт 7 сая арьс, шир “Эмээлт парк” дээр үйлдвэрлэгдэнэ.

Энэ дээр хонь, ямаа 6 сая, үхрийн шир 700 мянга, адууны шир 200 мянга, тэмээний шир 15 мянга байхаар.

“Эмээлт парк” дээр 4.8 мянган тонн завод ноос ноолуур үйлдвэрлэнэ. Үүний завод ноос нь 3.6 мянган тонн, жилдээ.

Завод ноолуур 1.2 мянга байхаар Арьс, ширний холбоо болон Хүнс, хөдөө аж ахуйн яамтай урьдчилсан байдлаар тогтоод энэ чиглэлээрээ техник, эдийн засгийн үндэслэл дээрээ тооцоолол юмаа тусгаад явж байгаа.

Г.Ганболд: Ж.Батжаргал гишүүн асууя.

Ж.Батжаргал: Баярлалаа.

Тэгэхээр Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 08 дугаар тогтоолын хэрэгжилтийг л хэдүүлээ ярьж байна л даа.

4 байршил дээр үйлдвэр, технологийн паркийн асуудал, тэр тусмаа

энэ арьс, шир боловсруулалтын асуудлыг шийднэ гээд л явцгаасан. Яг бодитой үр дүн төдийлөн харагдаж өгөхгүй байгаад байгаа юм.

Тийм учраас энэ чиглэл дээр хийж байгаа ажлуудынхаа яг бодит гүйцэтгэлүүдийг их тодорхой болгоод яг хэдэн онд наад суурь дэд бүтцүүдийн чинь ажил дуусаж жинхэнэ боловсруулах чиглэлийн үйлдвэр юмнууд нь байгуулагдах юм бэ гэдэг асуудал бидний гол анхааралд байгаад байгаа зүйл. Энэ дээр нэг тов тодорхой төсөөлөл юмаа хэлчихмээр байна. Нэг.

Хоёрдугаарт, үйлдвэржилтийн байршлын асуудал, энэ юмнуудаа хараад тэргүүн ээлжид энэ Эмээлтийнхээ асуудлыг шийдэж явах нь зохилтой юм биш үү гэдэг байдлаар Байнгын хороо тухайн үед ярьж үүнийг ер нь жоохон эрчийг нь авхуулъя гэдэг байдлаар чиглэл юмнууд өгөгдсөн. Та хэдийн судалгаа, ТЭЗҮ, тэгээд л орчны нөлөөлөл энэ тэр гээд л нэг юмнууд руугаа л яваад байгаа юм.

Тэгэхээр наад асуудлууд чинь явалгүй яах вэ. Тэр угаасаа явна. Гэхдээ ээлж дараа эрэмбийнхээ юмыг л бодмоор байна л даа. Үнэхээрийн л байгаль орчин, тэр орчиндоо нөлөөлөл багатай гэдэг нь тогтоогдоод үнэлгээ нь хийгдчихсэн бол тэр төлөвлөгдсөн газар дээрээ эхний удаа тэр хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө бүх юмаа хийгээд л суурь дэд бүтцийнхээ ажлыг хийгээд л, тэгээд л үйлдвэрүүддээ газар олголтынхоо асуудлыг шийдээд л давхар давхар явахгүй бол нэг юмыг хийж дуусгаад дараагийн юм явна гэвэл цаг хугацаа чинь биднийг хүлээхгүй ээ. Боломгүй байгаа байхгүй юу.

Тийм учраас энэ ямархуу байгаа юм. Нэг хариуг нь өгөөдхөөч ээ гэж нэг ийм зүйл байна.

Дараагийн зүйл бол наад Дарханы асуудал чинь тэгээд хэзээ шийдэгдэх юм бэ? Яг хэзээ шийдэгдэх юм?

Нэг л тийм тоймтой биш. Эрх зүйн гацаанд орчихсон юм шиг л юм л яриад л, ингээд л тойроод хоёр, гурван жил боллоо. Одоо яах ёстой юм. Яг шийдлийн юу гэж хараад байгаа юм? Энэ шийдлээ нэг тов тодорхой хэлээд өгөөч. Үүнийг чинь нэг анзаармаар байна.

Гурав дахь зүйл. Мэдээж энэ цаг хугацаа орох нь, бидэнд. Тодорхой. Тэгвэл одоо явагдаж байгаа энэ үйлдвэрүүд дээрээ энэ шилжилтийн гэдэг юм уу, энэ үед ямар арга хэмжээ авах гээд байгаа юм бэ? Энэ чинь л бидэнд нэлээн гол чухал асуудал байгаад байна. Энэ дээр манай Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үйлдвэрийнхээ бодлогыг барьж байгаа нөхдүүд юу гэж бодоод байгаа юм.

Арьс, ширний холбоо энэ холбогдох байгууллагууд нь юу гэж бодоод байгаа юм. Нэг том төсөл яриад бүх юмаа зогсоочхож болохгүй биз дээ.

Тийм учраас үүнд нэг хариулт өгөөдхөөч. Одоо Монголоос экспортлогдож байгаа арьс, шир тоо хэмжээгээрээ, үнийн дүнгээрээ хэд юм? Импортлогдож байгаа нь хэд юм? Наад зарим үйлдвэрүүд чинь яг нарийндаа гаднаас боловсруулсан арьс, шир оруулж ирээд байгаад байна шүү дээ.

Тийм учраас наад ажлын чинь явц яг нарийндаа удаашралд ороод байгаа юм билээ. Би тэгж харсан.

“Дархан минж” гээд энэ байгууллагууд чинь Туркээс арьс, шир анхан шатны боловсруулалт хийгдчихсэн юм уу, эсвэл бэлдэц оруулж ирээд

үйлдвэрлэлээ явуулаад байгаа ийм л мэдээлэл орж ирээд байгаа шүү дээ. Тэгээд энэ ямар тоо хэмжээ байна аа?

Цаашид ер нь энэ импортоо зогсоож, дотоодоосоо хангах экспортын чиг баримжаа нь ер нь яаж явна гэж хараад байгаа юм бэ? Энэ юман дээрээ нэг тодорхой хариулт өгөөдхөөч. Тэгээд би тодруулья.

Г.Ганболд: 3 номер. Ажлын хэсгийн 3 номер.

М.Ганхүлэг: Ж.Батжаргал гишүүний асуултад хариулья.

4 байршил дээрх бүтээн байгуулалтын ажлууд Эмээлтийн хувьд техник, эдийн засгийн үндэслэлээ батлаад энэ жилийн хувьд үйл ажиллагаагаа эхлүүлэх зорилготойгоор ажиллаж байгаа. 2028 онд үндсэндээ үйлдвэрлэлийн үйл ажиллагаа бүрэн дуусна гэсэн, бүтээн байгуулалтын үйл ажиллагаа бүрэн дуусна гэсэн тооцоололтойгоор ажиллаж байна.

Ховдын хувьд 2024 онд дэд бүтцийн ажлууд бүрэн дуусна.

Мөн таны саяын хэлж байгаагаар хувийн хэвшлүүдийг тэнд үйл ажиллагаагаа явуулах 17 үйлдвэр байгаа. Тийм ээ. 17 үйлд үйлдвэрийг сонгон шалгаруулах ажлуудыг 2024 ондоо хийхээр төлөвлөн ажиллаж байна.

Дорнод дахь аж үйлдвэрийн паркийн зураг төсвийн ажлууд үндсэндээ 2024 онд эцэслэгдээд, дэд бүтцийн ажлуудын саналыг улсын төсөвт оруулна.

Бид бүхэн 9.7 тэрбумаар 2 жил дараалан оруулсан. Зураг төсөв болон тодорхой шалгуураа хангахгүй байгаа учраас хойшилсон байдалтай байгаа юм.

Дархан арьс ширний хувьд яг тодорхой шийдлийн хувьд гаргахад нэлээн хүндэрчихсэн байгаа тухай би Та бүхэнд хэллээ.

Яалт ч үгүй эрх зүйн талаас нь тодорхой арга хэмжээ авч шийдэл гаргахгүй бол бид бүхэн шууд хувийн өмч дээр гэрээ байгуулаад явж байгаа асуудлыг шилжүүлэн авахад боломжгүй байгаад байна.

Байр сууриа маш тодорхой илэрхийлчихсэн. Хийсэн ажлыг нь үнэлээд гаргаад ирчихсэн. Үүгээрээ авъя гээд тэгэхээр хойшоо гэдийгээд суучихдаг. Дахиад эрүүгийн асуудал нь яг тодорхой шийдэгдээгүй байгаа учраас янз бүрийн асуудлаар бид бүхэн хандаж болдоггүй ийм байдалд орчихсон байгаа юм.

Тийм учраас бид бүхэн одоогийн харж байгаагаар улсын тусгай хэрэгцээнд аваад, хууль, эрх зүйн асуудлыг нь шийдэгдэх хугацаанд төслийг үргэлжлүүлээд явуулах нэг хувилбар байгаа юм. Ажлын хэсэг дээр бүр хэсэгчлээд зөвхөн дэд бүтцийн бүтээн байгуулалт хийгдсэн газруудаа хүлээгээд авчихъя. Бусад газруудыг нь үндсэндээ үлдээгээд явъя гэдэг байдлаар илэрхийлсэн. Бас энэ саналыг хүлээж аваагүй ээ.

Тийм учраас одоо ингээд арай өөр дорвитой байдлаар Засгийн газрын зүгээс алхам хийх ийм л сонголт руу орж байна.

Шаардлагатай гээд түрүүчийн ярьдаг хоёр дахь асуудал 180 га-гийнхаа дэд бүтцийг ашиглаад 25 га дээрх бүтээн байгуулалтынхаа ажлыг эхний үе шат гэж эхлүүлээд, тэгээд тэр явчихсан байгаа дэд бүтцийг царцаалгүйгээр ашиглаад явж байя. Шүүхийн асуудал юмнууд нь

шийдэгдсэн тохиолдолд үүнийгээ 205 га-гийн томоохон хөдөө аж ахуйн аж үйлдвэрийн парк болгоод явуулах энэ хоёр дахь асуудлыг хүртэл бид тавьсан.

Гэтэл ингэж хэсэгчилж өгөхгүй ээ. Өгсөн тохиолдолд газраа 1 га-г нь бүр 1 тэрбумаар үнэлээд арай хүлээж авах боломжгүй хүртэл ийм саналуудыг хэлээд байгаа учраас энэ дээр зайлшгүй тодорхой шалгадаг газраар нь шалгаад ингээд асуудлуудыг нь эцэслээд явахаас өөр аргагүй байдал руу оруулж байна гэдгийг өнөөдрийн түвшинд би хэлэхээр байна.

Одоогийн байдлаар ажиллаж байгаа арьс, ширний үйлдвэрүүд маань жилдээ 5.3 сая арьс, ширийг боловсруулж байгаа.

Г.Ганболд: 1 номерын микрофоныг өгье.

Т.Баярсайхан: Баярлалаа. Ж.Батжаргал гишүүний асуултад хариулъя.

Таны хэлж байгаа тэр мэдээлэл үнэн байна. Монгол мал аж ахуйн орон. Жилдээ 20 сая ширхэг арьс гарч байгаа мөртлөө “Булигар” хувьцаат компанид Өмнөд Африкаас бид үхрийн шир 2 чингэлгийг оруулж ирж туршсан. Туркээс ямааны арьс, хагас боловсруулсан болон гүн боловсруулсан ямааны арьс оруулж ирж туршсан.

Туршилтууд маш сайн болсон. Өөрөөр хэлбэл нядалгааны үеийн гэмтэлгүй арьс бид худалдаж авсан. Тэгэхдээ тэр арьс цаад талдаа 4 дүгээр зэргийн арьс.

4 дүгээр зэргийн арьсыг оруулж ирээд бид хийж үзсэн.

Өнөөдөр яагаад бид энэ 5.3-хан сая ширхэг арьсыг боловсруулаад байна вэ гэхээр нядалгааны үеийн гэмтэл маш их байгаа. Ялангуяа бодын арьсан дээр.

Богийн арьсан дээр хачиг, хувалз, хамууны арьсны гэмтэл маш их байгаа.

Өнөөдөр Монголд эдийн засгийн эргэлтэд орж байгаа ганц арьс бол ямааны арьс байна.

Өнөөдөр дээд ямааны ханш 50 мянга, доод тал нь 40 мянган төгрөгийн үнэтэй байна. Дээр нь суусан ноолуурынхаа үнээс шалтгаалаад.

Бид Турк, Европын зах зээл рүү ямааны арьсыг 1.2-оос 2.8 долларын хооронд хагас боловсруулаад экспортолж байна.

Нийслэлтэй Засгийн газрын тогтоол, Үйлдвэржилтийн байнгын хорооны тогтоолын дараагаар маш их идэвхтэй ажилласан.

Нийслэлийн хөрөнгө оруулалтаар Эмээлтийн үйлдвэр, технологийн паркийн хашаа барьсан. Бас Инновацын төвийн барилга барьж эхлэхээр болсон.

Бид Дэлхийн банкны Улаанбаатар хотын өрсөлдөх чадварыг сайжруулах төслийн хүрээн дэх зээлийн гэрээг Их Хурлаар соёрхон баталсаны дараа нийслэлдээ газар олголтыг тохироод, ингээд шууд үйлдвэрүүд нүүх ажлаа параллель хийгээд явна гэсэн тохироотой байгаа.

Тэгэхээр Та бүхнийг энэ зээлийн гэрээг Их Хурлаар соёрхон батлахад Үйлдвэржилтийн байнгын хороо тус дэмжлэг үзүүлээсэй гэсэн хүсэлт байна. Баярлалаа.

Г.Ганболд: Ж.Батжаргал гишүүн тодруулъя.

Ж.Батжаргал: Тийм. Нэг мэдээллүүд л байгаад байгаа юм.

Хийж байгаа юм ч байгаа л байх. Үр дүн л харагдаж өгөхгүй тарчлаад байгаа л улс л даа, бид хэд.

Тэгээд аль болохоор шуурхай явмаар байна. Шийдлүүдээ зөв гаргамаар байна.

Энэ тал руугаа нэг жоохон анхаараад ажиллаадхаач. Хүний бэлэн санаа, төсөл ер нь булаах гээд байдаг ийм л үйл явцаас хамааралтай удаашрал байхгүй юу, наадах чинь.

Тэр байгууллага өөрийнхөө чиглэлээр л юмаа явуулаг л дээ. Түүн дээр нь төр үзүүлэх ёстой дэмжлэгээ үзүүлээд л явах ёстой байхгүй юу.

Гэтэл тэгэлгүй асуудлыг хүндрүүлээд гурав, дөрвөн жилээр хойш нь татчихаж байгаа байхгүй юу, наадхыг чинь. Ерөөсөө гол санаа тэнд л байгаад байгаа юм билээ.

Одоо нэг бизнесийн байгууллага хууль тогтоомжийнхоо хүрээнд зээл юм авч ашиглаж. Тодорхой хэсгийг нь буруу ашигласан байж магадгүй. Гэлээ гээд.../минут дуусав/

Г.Ганболд: Ж.Батжаргал гишүүний микрофоныг өгье.

Ж.Батжаргал: Тийм байдлаар асуудлаа хандаж явмаар байна. Одоо тэр Эмээлт энэ тэр дээр бас энэ нэг балай юм нь дахиад давтагдах вий. Наад явдаг зарчмаар нь энэ юмнуудаа явуул аа.

Үүнийг нь хамгаалдаг эрх зүйн орчин бүрдүүлэх санаа оноо байгаа бол энэ хуульд заалт оруулъя гэдэг саналаа наад мэргэжлийн холбоод нь, хувийн хэвшлийнхэн нь, энэ чиглэл дээрх асуудлаа барьж байгаа яам нь бариад ороод ир ээ. Дэмжиж өгье өө.

Дээр нь тэр нэг зээлийн хэлэлцээр юмнуудаа оруулаад ирээч. Орж ирнэ гээд яригдаад өчнөөн цаг хугацаа авчхаад тэгээд Их Хурал дэмжээрэй гэж. Орж ирээгүй юмыг чинь бид яаж дэмждэг юм. Оруулаад ирээч. Тэгээд тийм цаг нь болчихсон, болзлоо хангачихсан л юм бол оруулаад ир. Дэмжье.

Үүнийг чинь хийх гэж долоо, найман жил хүлээгээд байгаа байхгүй юу.

Тэгээд яагаад шийдэл нь гарч өгөхгүй ингээд хүндрэл үүсгээд байгаад байгаа юм.

Тэгээд хамгийн гол зүйл бол одоо би байж байгаагаа шилжилтийн хугацаанд яаж дэмжиж боловсруулалтаа нэмэгдүүлэх юм бэ, тоогоо нэмэгдүүлэх юм гэдэг.../минут дуусав/

Г.Ганболд: Г.Дамдинням гишүүн асуулт асууя.

Г.Дамдинням: Энэ ч одоо тэгээд нэг үйлийн үртэй л ажил даа.

Анхнаасаа буруу хөл дээрээ босоод хулгайч хүмүүс эхлүүлээд явчихсан юм чинь тэгээд олигтой явдаггүй л юм шиг байна даа.

Бид нар одоо тэгээд төрийн шийдвэрийн үр дүнгийн алдааг л харж байна л даа.

2022 оны 10 дугаар сарын 26-ны өдөр манай Байнгын хороо бид энд тойрч

сууж байгаад л ер нь КОВИД-ын өмнөх жилүүдэд хувийн хэвشلүүд хийчихсэн байгаа ажлыг нь. Нэг 20 орчим тэрбум төгрөгийн л яриа гарч байсан шүү дээ. Тэр үед. Хийчихсэн байгаа ажлуудыг нь авъя. Дархан арьс, ширний цогцолбор дээр.

Үүнийг нь авахыг нь зөвшөөрчихье. Байнгын хороо тогтоол гаргаад өгье. Тэгээд Хүнс, хөдөө аж ахуйн яам, Эрчим хүчний яам, Барилга, хот байгуулалтын яам гээд гурван сайдын тушаал гараад, ажлын хэсэг гаргаад энэ ажлыг үнэлээд тэгээд төрд худалдаад авчихъя.

Ингээд Хөдөө аж ахуйн яамны хажууд төрийн өмчийн аж ахуйн нэгж үүсгээд төр өөрөө хийгээд явъя гэдэг ийм шийдвэр гаргаад л өгсөн. Наад 2 дугаар зүйл нь.

Тэгээд одоо ямар нөхцөл байдал руу орчихоод байгаа вэ гэхээр нөгөө 20 гаруй тэрбумын л асуудалд дэд бүтэц хийчихсэн байгаа юмаа ингээд төрд өгнө гэж байсан хүмүүс нь одоо газраа үнэлээд 180 тэрбум төгрөг, нэмэх нь хөрөнгө оруулалтын зардал гэдэг юм нэхээд. Бараг 200 гаруй тэрбум төгрөгийн юм нэхээд цаашаа хараад хэвтчихсэн.

Тэгээд ийм юм бол төр, хувийн хэвшилтэй хамтарч ажиллах гэж гүйгээд байх бас хэцүү шүү дээ. Юманд чинь үнэ цэн, хэмжээ гэж нэг юм бий.

Би одоо энэ Хөдөө аж ахуйн яамныхныг, энэ ажил хариуцсан хүмүүсийг загнаад байх ямар ч үндэслэл алга. Танилцууллаа. 7 удаа уулзсан байна. Бичиг сачиг шидэлцгээсэн байна.

Тэгээд нөгөө хүмүүс нь бид нарын энэ Байнгын хорооны тогтоол гаргаад өгөхтэй зэрэг хувийн хэвшлийнхэн маань

давуу тал олж аваад л нэхээд явчхаж байгаа байхгүй юу.

Ямар нэг юм гурван талын тэгш оролцоотой, зөв оролцоотой байж байж шийдэгдэнэ.

Төрийн өмч, төр нэг талдаа, хувийнхан нэг талдаа, ард иргэд гээд. Үүнийг оролцогч талууд гэж нэрлэж байгаа. Ямар харилцаанд байгаа юм.

Хэн нэгэн нь илүү их давуу тал эзлээд эхлэх л юм бол энэ болохоо байчхаж байгаа юм. Яг энэ тохиолдолд манай хувийнхан даварсан байна. Надтай ч гэсэн уулзаж байсан. Дэмжээд явуулья л гэдэг юм хэлж байсан.

Төр, хувийн хэвшил хамтраад хийх л ажил. Төр тэгээд энэ дээр шийдвэрийг нь гаргаж өгөөд, бодит үнээ тооцуулаад ав гэхээр зэрэг бид нарын үнэ өмнө нь өгч байсан үнээс өөр болсон гээд хэдэн арав дахин нэмээд оруулаад ирвэл үүнийг хэн авдаг юм. Болохгүй байна шүү дээ. Энэ чинь татвар төлөгчдийн мөнгө явж байгаа.

Тэгэхээр ирэх онд бид улсын төсөв дээр мөнгө тавьсан. Дарханаас сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд ярьж байгаад Дархан арьс, ширний цогцолборын цэвэрлэх байгууламжийг барихад 23.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 2024 онд 11.9 тэрбумыг нь санхүүжих ийм төсөв бид тавьсан.

Одоо Байнгын хорооны тогтоолынхоо хэрэгжилтийг бид энд асууж байгаа бол хэрэгжүүлэх боломжийг тэр хувийн хэвшлийнхэн маань олгохгүй байгаа бол Байнгын хорооны тогтоолоо цуцлаад шинэ ажлын хэсэг гаргаад ажиллачихъя.

Тэгээд гүйцэтгэх засаглалынхаа хүмүүст ажиллах боломжийг нь олгоё. Бас энэ яамныхныг чинь байнга загнаад байж болохгүй шүү дээ. Төр бас ажил хийчихье гээд зүтгээд байхад нөгөө талд нь оролцож байгаа хүмүүс нь луйварчны дүрээр хандаад байвал болохгүй байхгүй юу даа.

Энэ чинь төрийн л газар шүү дээ. Төрийн өгсөн газрыг яахаараа нэг га-г нь тэрбум төгрөгөөр үнэлээд буцаагаад газрын наймаа шиг юм хийгээд байдаг юм. Болих хэрэгтэй шүү дээ.

Яамныхан ажлын хэсэг оруулж ирэх юмаа хийгээдэх. Хамаа алга. Би ажлын хэсэг байгуулаад ахлаад Их Хурлаас Байнгын хорооноос ажлын хэсэг гаргаад ажиллая энэ дээр чинь. Тэгээд шийдээд өгье.

Миний нэг минутыг нэмээд өгчхөөрэй.

Тэгэхгүй бол энэ 150 мянган малчин өрх, 300 гаруй малчдын эрх ашиг хохирч байна. Эдийн засагт асар их хохирол учирч.../минут дуусав/

Г.Ганболд: Г.Дамдинням гишүүний микрофоныг сунгая. 1 минут нэмье.

Тэгэхээр Монголын нийт бүх малчид хараад сууж байгаа л төсөл шүү дээ. Тэгээд бид ч гэсэн сонгуулиар сайхан ажил хийчихнэ гээд л хувийн хэвшил ороод л явсан.

Итгэл даахгүй байгаа бол больчихье. Төр дэд бүтцээ хийе. Дээр нь баригдах үйлдвэрүүдийг нь хувийн хэвшлийг татаж оруулья. Ийм ажил руу явцгаая. Хэдүүлээ.

2022 оны 10 сарын 26-нд гарсан тогтоолын биелэлтийг биелэх боломж хангахгүй байгаа бол энэ яамыг яах юм. Тэр хувийн хэвшлийнхэнтэй учраа олохгүй байгаа юм чинь яах юм. Тэгээд одоо төр өөрийнхөө замаараа л явсан нь дээр шүү дээ. Энэ хэдэн мянган малчдаа бодъё.

Хоёрдугаарт, Эмээлтийн арьс, ширний цогцолборыг больчхооч дээ. Хотынхон та нар боль л доо. Энэ авлигал хорооллынхоо, замын халтиргааныхаа, автобус унааныхаа учрыг ол. Тэгэх үү, та нар. Юун арьс, шир.

Тэгээд Ховддоо хийгээд, Дархандаа хийгээд болооч дээ. Яах гэж. Танай цэвэрлэх байгууламж дийлэхгүй шүү дээ. Үүнийг болих хэрэгтэй шүү дээ.

Г.Ганболд: 3 номер.

М.Ганхүлэг: Г.Дамдинням гишүүний саналтай санал нэг байна.

Үргэлжлүүлээд ажлын хэсэг байгуулаад илүү дараагийн шатын алхмыг хийх саналыг бид бүхэн бэлдэхэд бэлэн байна.

Дарханы үйл ажиллагаа яг одоо ажлын хэсгийн дүгнэлтээ нэгмөсөн танилцуулсан. Тийм.

Ажлын хэсгийн санал юмнуудаа бэлдээд оруулаад ирэхэд бэлэн байна. Тэгээд хамтраад явъя.

Г.Ганболд: Ц.Анандбазар гишүүн асууя. 2 номер. П.Сайнзориг дарга. Байж байгаарай. Ц.Анандбазар.

Ц.Анандбазар: Монгол Улсын малчин өрх хэд билээ. 70 сая малтай гэж бахархдаг бидний гайхамшиг хэдэн жил цаашид явах вэ?

Энэ 3 жил, 8 жилийн асуудал биш ээ. 30 жилийн асуудал шүү дээ. Малыг амьсгалаас бусдыг нь хэрэглэдэг гэж монголчууд ярьдаг. Махнаас бусдыг нь хаядаг гэж үг 30 жил боллоо.

Энд ерөөсөө чадахгүй байгаа нь тодорхой байна шүү дээ. Энэ хувийн хэвшлийнхний ч буруу биш. Хувийн хэвшил гэдэг нэр зүүсэн төрийнхний хувийн хэвшлийн нэрээр бизнес хийж байгаа ажил.

Ер нь тэгээд төрийн төслөөр мөнгө хийдэг энэ юмаа хэзээ болих юм бэ? Нүүрсний хулгай, автобусны хулгай. Хулгайгүй салбар үлдэхээ болилоо.

Одоо мал аж ахуйг хулгайчтай болгох нь.

Ерөөсөө энэ зарчмын асуудал Үйлдвэржилтийн байнгын хороо байгуулагдсаны ганц асуудал байгаа.

Хөдөө аж ахуйн яамны гялайсан, энэ 4 жил хийсэн нэг сайхан ажил байгаа. Энэ бол сүүний асуудлыг шийдээд, 1 литр сүүнд мянган төгрөгийн урамшуулал олгодог болсон. Энэ бол манай Байнгын хорооны санаачилгаар танай яамны хийсэн хамгийн том ажил гэж бодож байгаа.

Нэг нэгээр нь энэ малын гаралтай түүхий эдийг үнэд оруулах ажлыг эхлүүлэх ёстой юм.

Тэгэхээр Г.Дамдинням гишүүний хэлсэн зарчмын санал зөв өө. Яаманд яг энэ үйлдвэрлэлийг мэддэг хэдэн хүн байна. Ажлын хэсэг нь ямар хүмүүс байна. Мэдэхгүй байна.

Улаанбаатар хот эндээс ер нь гарах хэрэгтэй. Парк гэдэг үгийг

хүүхдийн парктэй адилхан гэж бодоод байх шиг байгаа юм.

Метрогоо барь. Одоо энэ Улаанбаатар хотын дээр дахиад өмхий үнэртсэн том үйлдвэр барих гэж юм ярьж байна шүү дээ.

Ерөөсөө чадахгүй. Чаддаг, чаддаг юмаа хийж байж улс хөгждөг юм шүү дээ. Юун яамны ажил руу хот ороод байгаа юм бэ. Х.Нямбаатар сайд тэгж бодохгүй байна. Би орж байна гэж.

Тэгэхээр өнөөдөр хотыг гаргах хэрэгтэй.

Дээр нь энэ үйлдвэр чинь 19-хөн сая арьс боловсруулах үйлдвэрийн тухай ярьж байна шүү дээ. Та нар 5 үйлдвэр барих гээд ярьж байна. Тавуулаа дампуурна.

Монгол Улсад ганцхан үйлдвэр байхад энэ үйлдвэр ашигтай ажиллах ТЭЗҮ-тэй юм билээ. Тоо мэддэг, бизнес ойлгодог хүн хэд байна. Цаашдаа бид юу хийх вэ гэхээр Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны бодлогыг гаргамаар байна.

Монгол Улс чинь үйлдвэр барихгүй 30 жил болчихсон. Цехээ үйлдвэр гэж андуурдаг болчихоод байна шүү дээ.

Тэгээд баахан үйлдвэр ярьж, цаас хийж, цаасаараа мөнгө хийдэг. Хувийн хэвшлийнхний нэрийг барьж бизнес хийдэг төрийнхөн бий боллоо.

Энэ чинь хонины арьс нөмөрсөн чоно гэсэн үг. Энэ чононуудаас холдох ганц арга нь шинээр ажлын хэсэг байгуулна.

Г.Дамдинням гишүүнийг даргаар тавьж арьс, шир боловсруулах үйлдвэрийг гацаанаас гаргая. Энэ Байнгын хорооны бодлого байх ёстой юм. Зарчмын зөрүүтэй санал оруулж байна.

Тэгээд энэ дотроос боловсролтой сайхан залуучууд байгаа байх. Тодорхой яг сэтгэлтэй залуучуудыг дэд сайдаа оруулаад нэг жилийн дотор энэ асуудлыг шийдэж болно.

Энэ чинь чүдэнзээ хийж чадахгүй улс болчихоод байна шүү дээ, бид чинь. 8 жил нэг үйлдвэрийн дэд бүтэц яриад байхдаа яадаг юм бэ, энэ чинь. Цаг хугацаа гэж байна уу?

Миний эхлүүлсэн төслүүд одоо болтол ороогүй үйлдвэр хүртэл байна. Энэ яам, тамга гэдэг чинь яачихсан цаг хугацаа нь зогсчихсон газар байдаг юм бэ.

Дандаа бизнесийн юм боддог. Нэг ширхэг ч ажил урагшлуулдаггүй. Хариуцлага хүлээдэг нэг ч хүн байхгүй. Дандаа ардаа эзэнтэй.

Одоо нүүрсний хулгай шиг юмыг, автобусны хулгай шиг юмыг мал аж ахуйд оруулахгүй шүү. Та нар сайхан мэдээрэй. Тийм юм байхгүй. Энэ чинь малчин ардын хөдөлмөрөөр бүтдэг зүйл.

Монголын ард түмэн магадгүй мянган жил идэх хоол нь энэ байгаа юм. Та бүхэн янз бүрийн санаа оноотой бүлэглэлийн хүмүүс байдаг бол.../минут дуусав/

Г.Ганболд: Ц.Анандбазар гишүүний микрофоныг сунгая. 1 минут нэмье.

Ц.Анандбазар: Тэгэхээр зарчмын хоёр асуудал шийдье. Өнөөдрийн хурал дээр.

Нэгдүгээрт, энэ оруулж ирж байгаа саналууд аль нь ч явахгүй юм байна.

Ер нь тоо мэддэг юм уу гэмээр аймшигтай тоонууд байна шүү дээ. Нэг үйлдвэр байтугай 20 үйлдвэр барьсан ч хүрэхээр мөнгө байна. 20 үйлдвэр барьсан ч.

Энэ бүгдийг зогсоохгүй бол Монгол Улсыг дампууруулна. Мөнгөтэйн зовлон гэдэг Монголд нүүрлээд байна.

Ажлын хэсгийг байгуулъя. Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны амьдрал мэддэг, ажил мэддэг, хөдөөгийн амьдрал мэддэг гишүүдээс ороосой гэж би хүсэж байна.

Ингээд яамнаас ажлыг нь аваад, ажлын хэсгийн хүмүүсийг аваад шинээр ажлын хэсэг байгуулж бодлогыг нь гаргаж өгье.

Нэгдүгээрт, хаашаа гаргах гээд байгаа гэдгээ шийдэх хэрэгтэй. Экспортод.

Дээрээс нь тэмээ, адуу, үхрийн чинь арьсыг боловсруулах юм бол алдагдалтай юм билээ. Цөөхөн малтай учраас.

Хонь, ямаагаа эхэлж шийдэх хэрэгтэй. Үйлдвэр байгуулахад эдийн засгийн тооцоо хэрэгтэй байдаг байхгүй юу. Ашигтай үйлдвэр явдаг болохоос биш алдагдалтай үйлдвэр явахгүй.

Хот утаанаасаа салж ядаж байхад.../минут дуусав/

Г.Ганболд: 3 номер.

М.Ганхүлэг: Ц.Анандбазар гишүүний асуултад хариулъя.

Ажлын хэсгийн үйл ажиллагаанд мэргэжлийн хүмүүсийг оруулаад тал талаасаа ажиллаад явахыг дэмжиж байна.

Явж байгаа төслүүдийн хувьд техник, эдийн засгийн үндэслэлүүд нь бүгд олон улсын байгууллагын зөвлөх үйлчилгээнүүдийг аваад хийгдсэн байгаа.

Тэгэхээр ажлын хэсэг дээр тодорхой яг нарийвчлаад танд танилцуулах нь зөв байх гэж бодож байна. Мэдээжийн хэрэг мэргэжлийнхэн ажилласан зүйлүүд байгаа. Бүгдийг нь үгүйсгэлгүйгээр энэ дээр асуудлуудыг танд танилцуулах нь зөв өө гэж бодож байна.

Цаг хугацааны хувьд алдаж байгаа энэ асуудлыг би дээр танилцуулсан.

Одоо хийгдсэн байгаа бүтээн байгуулалтын ажлууд маань хүртэл ашиглагдаагүй байж үндсэндээ ашиглах боломжгүй болох хэмжээнд хүртэл энэ дэд бүтцийн ажлууд очиж байгаа учраас ерөөсөө хугацаа алдалгүйгээр ажиллах нь зөв өө.

Зөвхөн Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас бүр гадна бусад хууль хяналтын байгууллага арай өөр түвшинд энэ асуудлыг авч хэлэлцэх нь зайлшгүй зөв байна.

Тэгэхээр энэ саналын дагуу явах нь зөв өө гэдгийг дэмжиж байна.

Г.Ганболд: 2 номер. П.Сайнзориг дарга түрүүний асуултуудад хариулъя.

П.Сайнзориг: “Эмээлт аж үйлдвэрийн парк”-ийн асуудал өчигдөр яриад ч юм уу, өнөөдөр нийслэлээс шууд хэрэгжүүлээд байгаа ажил биш юм. Энэ бол Улаанбаатар хотын сүүлийн 50 жилийн хугацаанд, 60 жилийн хугацаанд энд Хан-Уул дүүрэг үйлдвэрчдийн район байсан. Энд өнөөдөр 20-иос 30 үйлдвэрүүд ажиллаж байгаа.

Тэгэхээр энэ аж ахуйн нэгж, байгууллагуудыг шууд зогсоох, хаах тухай асуудал ерөөсөө байж боломгүй.

Үнэхээр юу гэдэг юм дараагийн хаашаа шилжих вэ гэдэг асуудлыг л тухайн цаг үе дээрээ ярьж, ярьж энэ асуудлын шийдэл нь гарсан.

Өнөөдөр яг хотын төв дотроо бид химийн бодис хэрэглэдэг үйлдвэрлэлийн зонтой явж байгаа. Үүнийг бид хөрсний бохирдол, цаашдаа асуудлуудыг ярихын тулд “Эмээлт аж үйлдвэрийн парк” байгаа юм.

Бид үүний ТЭЗҮ дээр Дэлхийн банктай ажиллаж байгаа учраас эргээд тодорхой байршлуудад баригдах аж үйлдвэрийн паркуудтай уялдаж байгаа. Үүнийг бодлогын яам Хүнс, хөдөө аж ахуйн яамтай нь ярьж бид дундаж хувилбараар нь сонгосон. ТЭЗҮ хүчин чадлынхаа хувьд.

Мэдээж нийслэлийн зүгээс суурь дэд бүтцүүдээ хийе. “Эмээлт аж үйлдвэрийн парк”-ийг зөвхөн арьс, ширний үйлдвэрээр төсөөлж болохгүй байгаад байгаа юм.

Өнөөдөр 1.7 сая хүн амтай хотын хүнсний хангамжийн асуудал буюу хүлэмжийн аж ахуй хэрэглэх энэ дайвар бүтээгдэхүүнийг бүрэн ашиглаж тодорхой хэмжээнд эдийн засгийн

эргэлтэд зөв оруулъя гэдэг л бодлого байгаа.

Мэдээж энэ бүс нутгийн буюу Төв аймаг гэдэг юм уу, тодорхой ойр орчмын малчдын үйл ажиллагааг дэмжих. Энд малаас гарч байгаа түүхий эдийг нэмүү өртөг шингээе гэсэн ийм л зүйл байгаа.

Тэгэхээр энэ асуудлуудыг бид өөрөө юу гэдэг юм экологи гэдэг юм уу, технологийн давуу талтайгаар оруулж ирэх нь таны ярьж байгаа тэр байгаль орчин болон хүн амьтанд нь үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлж чадна гэж үзэж байгаа.

Тэгэхээр энэ асуудлуудыг яах вэ үе шаттай. Мэдээж таны хэлж байгаа шүүмжлэл байлгүй яах вэ. Бас их удаж байна.

Яг үнэнийг хэлэхэд бараг сүүлийн арван хэдэн жил л энэ Хан-Уул дүүрэг дэх үйлдвэрүүдийг гаргана, гаргахгүй, хаашаа вэ гэдэг асуудлууд маш олон жил яригдсан боловч шийдэгдээгүй өнөөдрийг хүрч байгаа гэдэгтэй би санал нийлж байна.

Тэгээд энэ бол нийслэл биш төрийн бодлогын хүрээнд буюу Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт ороод явчихсан юмыг бид зогсоох тухай биш. Ярих боломжгүй.

Энэ бол ТЭЗҮ 2 сард ирж хийгдэнэ. Эргээд хөрөнгө оруулалт, зээлийн хэлэлцээрүүд Улсын Их Хурлаар хаврын чуулганаар танилцуулж соёрхон баталъя.

Цэвэр дулаан, эрчим хүч болоод цэвэрлэх байгууламжийн асуудлыг нь шийднэ. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт өөрсдөө энэ асуудлыг шийдэж, 2028 он гэхэд л ийшээ үйлдвэрүүд бүрэн

шилжиж, боловсруулах процесс руугаа орно гэсэн ийм л төсөөлөл графикийн дагуу явж байгаа эд байгаа юм.

Г.Ганболд: Ц.Анандбазар гишүүн тодруулъя.

Ц.Анандбазар: Нийслэлийн дэргэд махны үйлдвэрийг дэмжих, нийслэлийг хүнсний бодлогоор хангах асуудал байж болно.

Арьс боловсруулахгүй. Та цээжлээд ав. Арьсаа Дарханд боловсруулна.

Үйлдвэр ямар аюултай дагавартай болохыг Та бүхэн мэдэхгүй байна. Одоо бид нэг зүйлийг сурмаар байгаа юм. Үйлдвэр барина гэдэг чинь дагалдаж ямар олон нөлөөлөл бий болохыг боддог болох хэрэгтэй.

Нэг үйлдвэр барихад 200 тэрбумын асуудал яригдаж байж 5 үйлдвэр барина гэдэг ийм баян Монгол Улсаас өөр улс байхгүй шүү. Баянгийн ядуу гэж зовлон байдаг. Мөнгийг зарахад ухаантай зарахгүй бол үр дүн гардаггүй юм.

Х.Нямбаатар даргад та заавал дамжуул. Энэ ТЭЗҮ хийгдээгүй байгаа арьс, ширний үйлдвэрээсээ татгалзаарай гэж хэл. Бид угаасаа дэмжихгүй. Яагаад гэхээр ийм амьдралгүй юмыг дэмжиж болдоггүй юм.

Бид мянган жил явж байна шүү дээ. Амьдралтай ТЭЗҮ, амьдралтай үйлдвэр амьдралд явдаг.

Г.Ганболд: Ц.Туваан гишүүн асууя.

Ц.Туваан: Дархан арьс, ширний үйлдвэрийн асуудал орж ирж байна.

Тэгээд бид бүхэн Үйлдвэржилтийн байнгын хорооноосоо тогтоол гаргаад өгсөн. 08 тоот. Энэ тогтоолын 1 дүгээр зүйл, заалтад нэг үг байгаа. Тэрийг та хэд анзаарсан байх.

Тэр нь бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал гээд. Ерөөсөө бүсчилсэн хөгжлийн бодлого чинь өмнө нь Хөдөө аж ахуйн яам дээр бид бүхэн зах зухаас нь яриад, тэгээд тэр үзэл баримтлалынхаа хүрээнд Дарханы арьс, ширний цогцолборыг шийдсэн байхгүй юу.

Яагаад заавал Дархан бэ гэдэг асуудлыг тэнд яриад шийдчихсэн. Тэгээд саяхан Улсын Их Хурлын тогтоолоор баталсан бүсчилсэн хөгжлийн асуудлыг би дэмжсэн. Яг энэ хөгжил талаас нь.

Тэгэхээр энэ зөв асуудал. Яг энэ талаасаа.

Бид бүхэн яагаад өнөөдөр энэ асуудал дээрээ мухардчихаад байна гээд. Өмнөх нийгмийг чинь бид муулаад л байдаг. Тэнд чинь нэг бүтэн систем байсан байхгүй юу.

Одоо бид ямар ч системгүй дур зоргоороо ингээд нэг хонинд орсон чоно шиг сэглээд яваад байгаагийн гай өнөөдөр яг гарч байна л даа.

Бид эхлээд бодлогоо гаргаад, түүндээ зориулсан хууль эрх зүйгээ батлаад, түүнийхээ дагуу стратеги, төлөвлөгөөгөө боловсруулаад, тэгээд хөтөлбөрөө гаргаж ирээд, тэгээд салбарууд, хувийн хэвшилтэйгээ уялдаад үүнийгээ төсөл болгоод явах ёстой ийм л асуудал байхгүй юу.

Тэгэхээр үүнийг бид дундаас нь сэглээд яваад байгаа.

Дархан арьс, ширний цогцолбор гээд энэ чинь бас энэ бүсчилсэн хөгжлийн бодлоготойгоо нэг уялдсан санаатай юм.

Яагаад зогссон гэдгийг бараг хүмүүс мэдэж байгаа. Үүнийг эхлүүлсэн, тухайн үед Хөдөө аж ахуйн сайд байсан хүний эсрэг бодлого гэж би харж байгаа. Хардаж байгаа. Улс төр орчихсон, энд.

180 га дээр юм тэгээд л явж байсан шүү дээ. Энэ чинь бас нэг эцэс юмаа харчихсан, бүтээгдэхүүнээ хийнэ гэж юмаа харчихсан байсан төсөл шүү дээ. Зогсоосон. Дэргэд нь 25 га газар болгоод дахиад өөр бүтэц болгоод ингээд л явсан шүү дээ.

Тэгээд Байнгын хороо үүнийг олж хараад тогтоолоо баталж өгсөн шүү дээ. Тэр зэрэгцэж явж байгаа юмаа зогсоо. Анх эхэлсэн юмаа гүйцээ гээд явсан шүү дээ.

Тэгэхээр энэ дээр улс төр орчихсон гэж би хардаж байгаа.

Хоёрдугаар асуудал нь, ер нь энэ малыг би бол жижиг, дунд үйлдвэр гэж хардаг. Хурга, тугал гарснаасаа эхлээд арьс нь сунаад бие бялдар нь өсөхийнхөө хэрээр мах үйлдвэрлээд явж байгаа.

Үүнийг эрхэлж байгаа хүмүүс буюу малчдыгаа би жижиг, дунд үйлдвэр эрхлэгч гэж байгаа юм.

Тэгэхээр өнөөдөр 300 мянган малчин жижиг, дунд үйлдвэрлэгчийн эрх ашгийг бид тоохгүй яваад байгаа асуудал байхгүй юу даа. Тэд нар чинь өөрсдийнхөө хийсэн, бүтээсэн бүтээгдэхүүнээ үйлдвэрлээд явчхаж байгаа юм.

Тэрийг нь бид Монголын төр арчаагүй. Боловсруулаад, нэмүү өртөг шингээгээд гаргах асуудлыг нь бид шийдэж чадахгүй ингээд л өнөөдөр хүрчхэж байгаа байхгүй юу.

Малчин яах юм. Арьс, ширээ үүрээд ямар Эрээн явалтай нь биш дээ. Ноосоо үүрээд Эрээн, цаашаа махаа үүрээд Вьетнам явалтай нь биш.

Тэгэхээр төр үүний дэд бүтэц талд нь заавал орох ёстой. Хувийн хэвшил үүнийг одоохондоо хараахан дийлэхгүй.

Тэгэхээр бид цогцоор асуудал ярьж байна. Сая Г.Дамдинням гишүүн ч гэсэн гаргалгаа гаргах тал дээр ажлын хэсэг байгуулья гээд. Тэрэнд нь би бас хэрвээ боломж байвал ороод явчихъя гэж бодож байна.

Арьс, ширний хувийн хэвшлийнхэн байгаа учраас энэ гадаад зах зээл чинь ер нь байгаа юм уу? Түүн дээрээ тодорхой үнэ ханштай, тоо ширхэгтэй юм хэлээдхээч.

1 минутаа авчихъя дарга аа.

Г.Ганболд: Ц.Туваан гишүүн нэмж асууя. 1 минут сунгая.

Ц.Туваан: Яг гадаад дээр хонины боловсруулсан нэг ширхэг **wet blue**_[нойтон хөх шир] хэдээр борлуулагдаж байна?

Ингээд яг таван хошуу мал дээрээ нэг хэлээдхээч. Эрэлт байна уу? Энэ асуудлыг.

Дээрээс нь арьс, ширний урамшуулал дээр яам яг одоо нэг юм хэлээдхээч. Та хэд ямар системээр явж байгаа юм? Цаг бага байгаа. Тэгэхдээ хүн ойлгогдохоор. Цахим гээд ярьж байна лээ.

Арьс, ширний холбооныхон сонсоорой. Өчигдөр бид Хөдөө аж ахуйн яаман дээр очсон. Наад арьс, ширний урамшууллын чинь болих юм ярьж байна лээ шүү. Төрийн нарийн бичгийн дарга нь.

Энэ асуудал дээр Та хэдтэй санал солилцсон юм уу? Одоо энэ чинь нөгөө үйлдвэрлэл, юм хумаа дэмжье, малчдын орлогыг тасалдуулахгүй гэдэг л бодлого дээр энэ ер нь хэрэгжихгүй байгаа гээд.

Тэгэхээр арьс, ширний урамшуулал олголтын энэ схем дээр бас Арьс, ширний холбоо ингэж хэрэгжиж байгаа гээд нэг хэлээдхээч.

Г.Ганболд: 3 номер.

М.Ганхүлэг: Ц.Туваан гишүүний асуултад хариулъя.

Бүсчилсэн хөгжлийг энэ удаагийн Засгийн газар нэлээдгүй хэмжээнд дэмжиж ажиллаж байгааг Та бүхэн маань мэдэж байгаа.

Энэ утгаараа энэ төслүүдийг бас тараан байршуулж Ховд, Дорнод, Дархан гэдэг иймэрхүү байдлаар зохион байгуулалтыг Хүнс, хөдөө аж ахуйн яам дэмжиж ажиллаж байгаа.

Шалтгаан нь баруун бүсэд нийт арьс, ширний маань 30.1 хувь үндсэндээ гарч байгаа. Зүүн бүсэд 15.8 хувь нь бэлтгэгдэж байгаа. Төвийн бүсэд 23.4, хангайн бүсэд 30 гээд.

Ингээд хангайн болон төвийн бүсийнхээ арьс, ширийг Улаанбаатар болон төвдөө. Цаашлаад баруун бүс, зүүн бүсийнхээ тоо баримтууд дээрээ үндэслээд энэ аж үйлдвэрийн паркуудыг

ингэж явуулъя гэдэг байдлаар ажиллаж байгаа юм.

Нийт 4 аж үйлдвэрийн парк Дарханыг ойролцоогоор 10, Эмээлт 7, Ховд 1, Дорнод 0.4 гээд ингээд үзэхээр нийт 20 сая арьсаа тодорхой хэмжээнд боловсруулах хүчин чадал байгаа.

Тэгэхдээ олон улсын туршлага, бусад туршлагуудыг харахад 100 хувийн хүчин чадлаараа үйлдвэрүүд бүрэн дүүрэн ажилладаггүй. 80.0 хувиа хүчин чадлаараа ажиллахад үндсэндээ амжилттай ажиллаж байна гэж үздэг туршлагууд байна.

Тийм учраас нийт арьс, ширнийхээ үйлдвэрийнхээ хүчин чадлыг 80 хувиар тооцоход одоогийн байгаа 4 үйлдвэр маань нийлээд ажиллаад явах боломжууд байна гэдэг энэ байдлаар Хүнс, хөдөө аж ахуйн яам харж Эмээлтийн ажил дээр нийслэл өөрсдийнхөө хэмжээндээ зохион байгуулалт хийгээд яв гэдэг энэ дэмжлэгийг өнгөрсөн онд гаргасан.

Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид ер нь малчдын хувьд чухал асуудал гэдэг дээр санал нэг байна.

Жилдээ бид бүхэн 9 сая ширхэг арьсыг үндсэндээ яг боловсруулж чадахгүй байгаа. 5.3 сая ширхэг арьсыг өөрсдөө бэлтгээд, үүнийхээ 1.5 орчим сая ширхэг арьсыг нь экспортод гаргаж байгаа үзүүлэлттэй байгаа юм.

Нөөц бололцоо нэлээн байгаа. Гэхдээ үүн дээр яг шаардлага хангах хэмжээний арьс, шир, ялангуяа махны техникийн зохицуулалтыг цаашдаа мөрдөж, шаардлага хангасан үйлдвэрүүдэд үндсэндээ малаа төхөөрөх асуудал дээр бид бүхэн нөгөө талдаа

анхаарах зайлшгүй шаардлагатай байгааг гишүүд маань мэдэж байгаа байх.

Тэгээд одоо энэ гаргаж байгаа 1.5 сая ширхэг арьсаа үндсэндээ дандаа хагас боловсруулж бид ашиг гаргаж байгаа.

Гүн боловсруулсан тохиолдолд бид олон улсад, Европын орнуудад гаргах шаардлагууд үүсэж байгаа.

Тийм учраас зайлшгүй томоохон олон улсын стандартад хангасан үйлдвэрүүдийг явуулж байж бид экспортын шаардлагаа хангах болчхоод байгаа юм.

Нэмэлтээр яг тэр үнэ ханштай холбогдолтой асуудлыг хувийн хэвшлийнхэн маань хэлье.

Урамшуулалтай холбогдолтой мэдээллийг М.Дондогдорж дарга.

М.Дондогдорж: Ц.Туваан гишүүний асуултад хариулья.

2023 онд нийт 3543 малчин өрхөд арьс, ширний урамшуулал олгосон. Нийт 8500 малчны хүсэлт ирснээс 2022 оноос эхлээд ноос, арьс, ширний урамшууллийг цахим системээр олгож эхэлсэн. Өмнө нь дандаа цаасан баримтаар өгч байсан.

2022 оноос эхлээд Нэмэгдсэн өртгийн албан татварын хуультай холбоотойгоор и-баримтаар баталгаажсан баримтад урамшуулыг олгож явж байгаа.

Г.Ганболд: 1 номер.

Т.Баярсайхан: Ц.Туваан гишүүний асуултад хариулья.

Сүүлээс нь явчихъя. Урамшууллын хувьд арьс, ширний салбарынхан ер нь нэг, хоёрдугаар

зэргийн арьс, ширэнд урамшуулал олгоё бодолтой байгаа.

Ер нь стандартын цаг хугацаандаа малдаа ариутгал, туулгалт, халдваргүйжүүлэлт хийсэн малчинд урамшуулал олгоно гээд Засгийн газрын журам дээр заачихсан байгаа.

Бид энэ стандартын цаг хугацаандаа ариутгал, туулгалт, халдваргүйжүүлэлт хийхээр арьс, ширний түүхий эдийн чанар сайжрах юм байна гэж уг нь ойлгож байсан. Энэ ажил маань явахгүй байгаа.

Тийм учраас нэг, хоёрдугаар зэргийн арьсанд нь урамшуулал олгоод явах нь зөв юм байна гэсэн ийм ойлголттой байгаа.

КОВИД-ын нөхцөл байдлаас шалтгаалаад Засгийн газар эдийн засгийн боломжгүй гэдэг байдлаас 2 жил урамшуулал олгоогүйгээс болоод арьс, ширний урамшууллын ажил жоохон тийм саарсан нөхцөл байгаа.

Тэгэхээр цаашдаа малчдын урамшууллийг олгоод явах нь зүйтэй гэсэн байр суурьтай байдаг.

Арьс, ширний салбар ер нь тун их ядарчихсан салбар юм байна. Бид чинь яасан үйлтэй улсууд вэ.

2012 онд Улсын Их Хурлын 74 дүгээр тогтоол гараад Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа арьс, ширний боловсруулах үйлдвэрүүдийг Улаанбаатар хотоос нүүлгэсүгэй гэсэн.

Энэ санаачилга нь Ц.Туваан гишүүнийг Хөдөө аж ахуйн яамны сайд байхад бид хамтраад гаргасан.

2014 онд Улаанбаатар хотын үйл ажиллагаа явуулж байгаа арьс, ширний үйлдвэрүүдийг Эмээлтийн Шар хөцийн хоолойд нүүлгэ гээд Засгийн газрын тогтоол гарчихсан.

Бид Эмээлт рүү нүүх юм байна гээд хүлээгээд суугаад байсан.

Гэтэл 2017 онд Дархан гээд яригдаад явчихсан.

Дархан нүүх юм байна л гээд байсан.

Одоо тэгээд сая 2022 онд Та бүхэн яг ингээд сууж байгаад тогтоол гаргаад өгсөн шүү дээ. Эмээлтийн үйлдвэр, технологийн паркийн ажлыг идэвхжүүл гээд.

Одоо тэгсэн үүнийг зогсоо гэх юм. Энэ чинь ямар учиртай юм бэ?

Бид арьс, ширний салбарыг нуруун дээрээ үүрээд явж байгаа улсууд.

Энэ 170 мянган малчин өрхийн энэ түүхий эдийг эргэлтэд оруулж байгаа хүмүүс гэж өөрсдийгөө боддог. Бид маш олон залуучуудыг сургаж байгаа. Энэ салбарыг авч явах гээд маш их хичээж байгаа.

Тэгэхээр Та бүхэн төрийн байгууллагуудын наашаа цаашаа савласан энэ зүйлээ больчихооч ээ.

Сая гаруй хүнтэй хотын хүмүүсийн хүнснээс гарч байгаа махны үйлдвэрийн дайвар бүтээгдэхүүн арьс, ширнийг хэрэглэх юм уу, 100 гаруй мянган хүнтэй хотын махны үйлдвэрээс гарч байгаа дайвар бүтээгдэхүүнийг хэрэглэх юм уу?

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны энэ 4 газар хийх гээд явж байгаа бодлогыг бид дэмжиж байгаа шүү дээ.

Бид Дарханыг ч дэмжиж байгаа, Эмээлтийг ч дэмжиж байгаа. Дорнод, Ховдыг аль альныг нь дэмжиж байгаа. Тэр битгий хэл Ховдын үйлдвэр, технологийн парк дээр бид хамтраад ажиллах гээд бүр санамж бичиг хүртэл зурахаар хоёр талдаа хий ажил хийгээд явж байгаа.

Тэгэхээр ингэж битгий саваач ээ. Хэдүүлээ 2022 онд гаргасан энэ шийдвэрээ хийгээд явах юмсан.

Гадаад зах зээлийн хувьд яг өнөөдөр хонины нэхий Эрээний ханшаар 11 юанийн л ханштай байгаа. 11 юань. Юаниар.

Хонины маань арьсны 80, 90 хувь нь хачиг, хувалз, хамууны сорвитой байгаа учраас арьс гэдэг зориулалтаар нь биш муур, нохойны хоол хийх, биотехнологи, гоо сайхны бүтээгдэхүүн хийх, цавуу, желатин хийх энэ төрлөөр нь биотехнологийг хөгжүүлэх шаардлага байгаа.

Ийм ч ажлаар бид Эмээлтэд бас энэ ажлыг хийгээд явна. Дарханд энэ ажлыг хийгээд явна гэсэн төлөвлөгөөтэй байгаа шүү.

Яг энэ мэргэжлээр Туркт мэргэжилтэн бэлтгэж байгаа.

Ямааны арьсны хувьд түрүүн би хэлсэн. 1.2-оос 2.8 долларын ханшаар Туркийн зах зээлд борлогдож байгаа.

Гадаад зах зээл хангалттай их байгаа. Зүгээр үхрийн бодын арьсны хувьд бид махны үйлдвэрт арьс малаа

нядлахгүй байгаагаас шалтгаалаад нядалгааны үеийн гэмтэл маш их байгаа. Нядалгааны үеийн гэмтэл их байгаа учраас гадаад зах зээл дээр та нар нядалгааныхаа үеийн гэмтлийг багасгачхаач гэсэн маш их хүсэлт ирж байгаа.

Зүгээр гистологи бүтцийн хувьд Монголын энэ арьс ширэн түүхий эдийн хувьд аль ч гадаад зах зээл дээр гологдохооргүй тийм бүтэцтэй арьс байдаг юм.

Тэгэхээр цаашдаа энэ их.../минут дуусав/

Г.Ганболд: Ц.Туваан гишүүн тодруулъя.

Ц.Туваан: Эмээлт дээр ер нь яах вэ, одоо ингээд хот маш их тэлж байгаа. Тийм ээ.

Эмээлт чинь тун удахгүй хотынхоо дунд орно шүү. Тэрийг бодолцоорой.

П.Сайнзориг дарга үгэндээ хотын ард иргэдийг хортой химийн бодисоос ангижруулах гээд ярьж байна.

Ц.Анандбазар гишүүний тэр салхин дээр гэдэг чинь ч гэсэн үнэн.

Тэгэхээр үүнийг сайн бодолцоорой. Тун удахгүй хотынхоо дунд бид орчихно шүү.

Хоёрдугаарт, хөдөө аж ахуй дээр. Яах вэ, хонины нэхий мэднэ. Бид хүзүүнийхээ хэсэгтээ нэг дайр, хачиг, хувалзны юм байдаг юм.

Монголын энэ хасах 50-иас нэмэх 40-д явж байгаа малын арьс уникалний

байхгүй юу. Дэлхийд гайхагдахаар суналттай.

Тэгэхээр хүзүүний хэсгийн асуудал мал баантах чинь бид хэдийн арван жилийн өмнөхөөс хамаагүй дээр болчихсон байна лээ шүү.

Тэгэхээр үүнийг яриад тэрийг нь хасаад борлуулах талын юмыг нь.../минут дуусав/

Г.Ганболд: Н.Наранбаатар гишүүн асууя.

Н.Наранбаатар: Гишүүдийн асуулт, тэгээд Та бүхний хариултаас ерөнхий нэг ойлголт авсан.

Одоо нэг базаад хэлээдэхээч. Чуулганы завсарлагаанаар бид чинь сонгогчидтойгоо ажиллана, малчидтайгаа уулзана.

Тэгээд өмнө нь нэлээн ярьж явсан шүү дээ. Малчдын гол ярьж байгаа юм бол энэ үнэгүйдээд байгаа түүхий эдийг л та нар нэг үйлдвэртэй болгоод аваадхаач л гэдэг л юм ярьж байгаа шүү дээ. Малчид маань.

Өөр нэг их бид шаардаад байгаа юм байхгүй, гайгүй.

Тэгээд одоо яг юу гэж хариулах юм? Одоо очоод бид чинь удахгүй арьс, ширний үйлдвэртэй болно. Та бүхний хаягдаад байгаа арьс, шир түүхий эдийг бид үнэ цэнтэй болгоно гээд л баахан яриад явчихсан.

Одоо эргээд уулзахаараа юу гэх вэ? Хэзээ үнэ цэнтэй болгоно гэж хэлэх вэ?

Энэ бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд технологийн паркууд энд тэнд байгуулна гээд.

Говийн бүсийн тухай ер нь дурдагдсангүй. Баруун, зүүн, төвийн л гэж байна. Говийн бүс рүү ямар үйлдвэр, технологийн парк, үйлдвэрүүд барихаар Хөдөө аж ахуйн яамнаас төлөвлөж байна вэ гэдгийг нэг тодотгоодхооч.

Базаад энэ тогтоолынхоо хэрэгжилтийг нэг товчхон хэлээдхээч. Энэ Дарханы арьс, ширний үйлдвэр цогцолбор чинь цаашаа яах юм? Явах юм уу, үгүй юм уу, зогсох юм уу? Явбал хэзээнээс яваад хэзээ ашиглалтад орохоор Та бүхэн төлөвлөж байгаа юм гэдгийг нь хэлээдхээч.

Улаанбаатар хотоос нүүлгэх чиглэл өгсөн. Тэгээд хэчнээн үйлдвэр байгаа юм, хэд нь нүүгээд гарчхаад байгаа юм гэдэг тодорхой мэдээлэл өгөөдхөөч.

Тэгээд гол нь малчдадаа, иргэддээ, бид юу гэж ярих вэ гэдэг. Энэ дээр хариулт өгөөдхөөч ээ.

Г.Ганболд: 3 номерын микрофон өгье. Ажлын хэсгийн.

М.Ганхүлэг: Н.Наранбаатар гишүүний асуултад хариулья.

Паркуудын ажлууд нэг үеэ бодвол ерөнхийдөө техник, эдийн засгийн үндэслүүд нь тодорхой болгоод дэд бүтцийн ажлууд нь хийгдээд хөдлөөд эхэлсэн байгаа. Тийм.

Ховдынх ялангуяа 2024 онд бид бүхэн дэд бүтцийг нь бүрэн дуусгая гэсэн байдалтай нэлээн амжилттай ажиллаад явж байна.

Дархан арьс, ширний хувьд яалт ч үгүй маргаантай байдал үүсэж байгаа учраас яг энэ хууль хяналтын байгууллага талаас нь нэлээн асуудлыг нь цэгцлэх.

Нэг бол түүнийг нь хүлээх сонголт бий болчхоод байгаа. Нэг бол үүнийг улсын тусгай хэрэгцээнд аваад хуулийн үйл ажиллагаа юмнууд нь явах хугацаанд бид энэ дэд бүтцийн ажлуудыг нь үргэлжлүүлээд явах ийм хувилбар луу л орохоос өөр аргагүй байдалд орж байна.

Тийм учраас энэ дээр би яг Байнгын хорооноос тодорхой хэмжээнд ажлын хэсэг байгуулаад энэ асуудлуудыг илүү өргөн хүрээнд аваад ажиллах нь зөв байна гэдэг энэ саналыг хүлээж авч байна.

Говийн бүсийн хувьд тодорхой хувийн хэвшлүүдтэй хамтарсан аж үйлдвэрийн паркууд байгуулах ажлууд бас эхэлсэн.

Говьсүмбэр аймагт мах, махны чиглэлийн гол дагнасан ийм аж үйлдвэрийн паркийг албан ёсоор манай сайдын дэргэдэх зөвлөлөөр орж батлуулаад цаашдаа энэ чиглэлээр нь дэмжиж ажиллана гэдгээ илэрхийлээд ажиллаад эхэлсэн байгаа гэдгийг хэлье.

Дэлгэрэнгүй мэдээллийг шаардлагатай бол танд хүргүүлье. Энэ талаарх мэдээллийг. Тийм ээ.

Г.Ганболд: Гишүүд асуулт асууж дууслаа. Би хоёр, гуравхан зүйл тодруулья.

Ер нь миний мэдэхийн 4 жил ерөөсөө нэг ч алхам урагшаа явсангүй. Баахан хүмүүс цалин аваад л суугаад байгаа. Хэдэн ч тэрбум төгрөгийн зардал гаргаж байгаа юм. Бүү мэд.

Тэгээд өнөөдөр энэ Арьс, ширний үйлдвэрийн захирлууд нь хаачсан юм? Хаашаа явчихсан юм? Яагаад өнөөдөр Байнгын хорооны хурал дээр хэн нь ч ирэхгүй байгаа юм? Ганц инженер ирсэн байна. Цахилгааны инженер гэнэ үү.

Энэ хүмүүс хаачихсан юм? Яамныхан. ТУЗ-ийн дарга. Яагаад энэ хүмүүсийг Байнгын хороо өчнөөн олон удаа хуралдана гээд түрүүчийн долоо хоногоос явж байхад хаашаа алга болчихсон юм? Юу хийж байгаа юм энэ хүмүүс.

4 жил нэг ч алхам ахиагүй. Бид олон удаа Байнгын хорооны хурлаар үзлээ.

Түрүүн хэлсэн. Эхнээсээ хулгайн сэтгэлээр явсан юм явдаггүй юм байна гэдгийг харуулж байна л даа.

Энэ өөрөө эхнээсээ яг юу болсон гэж. Дарханд арьс, ширний цогцолбор байгуулна гээд Дарханаас 180 га газар аваад, тэр 180 га газраа барьцаанд тавьж Хөгжлийн банкнаас 20 тэрбум төгрөг зээлээд, тэгээд хэдэн фундамент[лат.fundamentum] цутгаад.

Одоо эргээд 180 га газраа 180 тэрбум төгрөгөөр төрд буцааж шахах гэж байгаа л төсөл. Ийм л юм явсан байхгүй юу.

Тэгээд одоо яах вэ гэх дээр зэрэг Хөгжлийн банкн дээр гацчихсан. Хэдэн фундамент байна.

Одоо тэгээд яг яах юм бэ? Үүнийг. Яг ямар шийдэл байгаа юм гэхээр юу ч хэлэхгүй.

Одоо Хөгжлийн банкны удирдлагууд байгаа. Би эндээс Хөгжлийн

банкныхнаас асууна. Одоо яг ямар шатандаа явж байна аа? Хөгжлийн банк энэ өр төлүүлэх, эсвэл үүнийг нэг талд нь гаргах талаар шүүх, цагдаад хандсан эцсийн шийдвэр гаргаж байгаа юм байна уу?

Эхлээд энэ Хөгжлийн банк энэ нэг юмаа нэг эцэслэчихвэл төр Хөгжлийн банктай эсвэл гэрээг нь, зээлийг нь сунгаад ч юм уу явмаар байгаа байхгүй юу. Энэ дээр Хөгжлийн банк өөрөө ингээд санаачилга гаргахгүй болохоор зэрэг яам юм хийж болохгүй байгаа байхгүй юу.

Тэгэхээр би Хөгжлийн банкныхан яг энэ дээр яг ямар байр суурьтай, энэ нэг өр авлагыг барагдуулах тал дээр ямар бодлого барьж байна гэдгийг асууя.

Хоёрт нь, Эмээлтийн цогцолбор. П.Сайнзориг дарга аа.

Эмээлтийн арьс, ширний цогцолбор Дэлхийн банкнаас мөнгө төгрөг авах нь олон жил яригдаж байгаа зүйл л дээ.

Тэгээд энэ төсөл нь зөвхөн Улаанбаатар хотод байгаа, Хан-Уул дүүрэгт байгаа арьс, ширний үйлдвэрүүдийг нүүлгэн шилжүүлэхэд зарцуулах гэж байна уу? Эсвэл шинэ үйлдвэр барих гээд байна уу? Хэрэв нүүлгэн шилжүүлэлтэд зарцуулах гэж байгаа бол төр тэр аж аж ахуйн нэгжүүдийг нь зөвхөн цэвэрлэх байгууламж, дэд бүтцийг нь хийж өгөх гэж байна уу? Эсвэл бүр нүүлгэн шилжүүлэлтийн зардлыг нь өгөх гээд байна уу?

Энэ дээр жаахан тодорхой явахгүй бол бид нарын ойлгож байгаагаар хэдэн үйлдвэрүүдийн нүүлгэн шилжүүлэлтийн зардал өгөөд, тэгээд тэр компаниуд нь

тийшээ төрийн зардлаар нүүж очоод энд байгаа газраа мэдээжийн хэрэг эд нар өөрсдөө ашиглаад л явна.

Хэрэв нүүлгэн шилжүүлэх юм бол энэ газрыг нийслэл чөлөөлж авах гэж байна уу гэдгээ эхнээсээ их тодорхой болгож яваарай. Тэгэхгүй бол баахан мөнгө зарцуулаад тэгээд хувийнхан тэрийг нь хүртээд л, тэгээд л завшаад л үлдэнэ.

Тэгээд энэ дээр П.Сайнзориг дарга аа, та нар их зөв явахгүй бол нэг баахан газар чөлөөлөх нэг л юм яваад л, тэгээд л хайран төсөл болоод явна.

Тэгээд манайх байна шүү дээ өөрийнхөө одоо энэ суурьлагдсан арьс, ширнийхээ хүчин чадлуудыг, одоо байгаа энэ бодын ширний шевро, булигаар ч гэдэг юм уу, эд нарынхаа хүчин чадлыг тооцож яваарай.

Сая Ц.Анандбазар гишүүний хэлж байгаа 4, 5 үйлдвэр шинээр байгуулаад яг үнэхээр тэр арьс, шир нь байна уу, үгүй юу? Их зөв тооцож явахгүй бол ингээд Дарханы арьс, ширний цогцолбор дээр 10 сая гэж байгаа бол түүн шиг Эмээлт дээр шинээр хийх юм бол энэ явахгүй шүү. Аль нэгийг нь шууд татаж унагана, дампууруулна.

Энэ дээр уг нь яам бодлогоо гаргаж явахгүй бол, яам өөрөө бодлого гаргахгүй, нийслэлд ч тусдаа бодлоготой юм шиг энэ чинь яамны бодлого чинь яг үндсэндээ хэдэн сая арьс, шир боловсруулах бодлогоо гаргах нь их зөв юм байгаа юм шүү дээ.

Дараагийн асуудал байна шүү дээ. Энэ жил 23 тэрбум төгрөг байна.

Г.Дамдинням гишүүний саяын хэлээд байгаа. Үүнийг яг яах гэж байна

аа? Одоо та нар шийдвэрээ гаргасан уу? Яам хэзээ тендер зарлагдах вэ? Яг юунд зарлах гэж байна? Тэр мөнгийг юунд зарах гэж байна?

Одоо тэр Дарханы арьс, ширний үйлдвэрийг явуулахын тулд тэр мөнгөөр. Эсвэл Дарханы арьс, ширнийхээ үйлдвэрүүдийн тэр Хөгжлийн банк их яаралтай шийдвэр гаргаад явах юм бол авсныхаа дараа зөвхөн цэвэрлэх байгууламжийн тэр мөнгөөрөө хийж өгөөд тэгээд л орхих хэрэгтэй.

Тэр фундаментээ хийсэн хувийн хэвшлүүд нь дэд бүтцийг нь хийгээд өгчихсөн хойно ямар үйлдвэрээ барих нь ерөөсөө тэр хувийн хэвшлийнхэнд нээлттэй өгөөд явах тал дээр анхаарч явахгүй бол ерөөсөө ямар ч шийдэлгүй ингээд л нэг шүүх, цагдаа руу ярьчихаад л, хувийн хэвшлийнхэн нь улам үнээ нэмээд л яваад байх юм бол ерөөсөө эндээс гарц шийдэл ер нь гарахгүй нь.

Тэгээд энэ дээр нэг тодорхой хариултууд би аваадахъя.

Хөгжлийн банкныхан байна уу? Ажлын хэсгийн 4 номер.

Э.Батырбек: Г.Ганболд гишүүний асуултад хариулъя.

Хөгжлийн банкны Эрсдэлийн удирдлагын газрын захирал Э.Батырбек байна.

Яг өнөөдрийн байдлаар 34.5 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Өсчихсөн байж байгаа. 34.5 яг өнөөдрийн байдлаар.

Тэгэхээр үүнийг хоёр салгах хэрэгтэй байх.

15 тэрбум төгрөгийг тухайн үед компани байгуулаад, тэр компаниар дамжуулаад 2020 онд одоо энэ 15 тэрбум төгрөгийг Дархан арьс, ширний цогцолбор хувьцаат компанид олгосон байдаг.

Өнөөдрийн байдлаар хүү нь 9.9 тэрбум, алданги нь 4.4 тэрбум. Ингээд 29.4 орчим тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй болчихсон.

Хоёр дахь санхүүжилт нь цахилгаан, эрчим хүчний дэд бүтцийг татах зорилгоор охин компаниараа дамжуулаад 3.2 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байдаг.

Энэ нь өнөөдрийн байдлаар 3.2 тэрбум төгрөг нь хэвээрээ. Хүү нь 1.4 тэрбум, алданги нь 394.4 тэрбум төгрөг.

Ингээд нийтдээ 34.5 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байж байгаа.

Одоогийн байдлаар ямар нэгэн эргэн төлөлт хийгдээгүй.

Бид бүхэн энэ асуудлыг ер нь анхнаасаа тухайн үед байгуулагдаж байсан үнэт цаасны тэр компани маань өөрөө, хөрөнгө оруулалтын сан маань өөрөө дүрэмтэй байсан, журамтай байсан. Тэр журам болон холбогдох заалтуудыг зөрчөөд олгогдчихсон байдаг юм.

Энэ асуудлаар тухайн үед хууль, шүүхийн байгууллагад хандчихсан байж байгаа. Одоо эрүүгийн хэрэг үүсгэгдээд, шалгагдаад явж байгаа. Сая прокурор шилжээд, буцаад мөрдөн байцаалт руу шилжсэн байна лээ.

Одоо энэ асуудал маань эцэслэгдээд явах байх гэсэн хүлээлт байж байгаа.

Бид бүхэн өнгөрсөн жил хагасын хугацаанд Дархан арьс, ширний холбогдох удирдлагуудтай маш олон удаагийн уулзалтуудыг хийсэн. Харамсалтай нь түрүүн М.Ганхүлэг дэд сайдын хэлдгээр нэг асуудлыг ингээд аман дээр ярьчихдаг, тохирчихдог. Бичгээр тэрийгээ баталгаажуулж авах гэхээр маргааш нь шал өөр байдлаар авчирч өгдөг.

Иймэрхүү байдлаар ерөнхийдөө өнөөдрийг хүртэл ингээд явчихсан. Нэг ёсондоо яриандаа аман байдлаар нэг өөр юм ярьдаг, бичгийн хэлбэрээр болохоор шал өөр юм ярьж. Иймэрхүү л байдалд явж байгаа.

Эрүүгийн журмаар энэ асуудал явж байгаа. Энэ эцэслэгдээд шийдэгдэх юм бол тодорхой хэмжээний асуудлууд явах байх.

Түрүүний М.Ганхүлэг дэд сайдын хэлж байгаагаар ерөнхийдөө төр тодорхой хэмжээний нэлээн хатуу арга хэмжээг авах дээр Хөгжлийн банкны байр суурь ижилхэн байгаа гэдгийг хэлмээр байна.

Г.Ганболд: Ажлын хэсгийн 2 номерын микрофоныг өгье. П.Сайнзориг дарга.

П.Сайнзориг: Г.Ганболд даргын асуултад хариулъя.

Таны хөндөж байгаа уг асуудалтай холбоотойгоор энэ арга хэмжээ ер нь явагдаж байгаа. Улаанбаатар хотын өрсөлдөх чадвар, нөхөн сэргээлтийг дэмжих төслийн хүрээнд гэж байгаа.

Тэгэхдээ яах вэ, нэршлийн хувьд ингэж байгаа боловч аливаа олон улсын байгууллагаас авах зээлд энэ нүүлгэн шилжүүлэх зардал болон эргээд энэ

хөрсний бохирдлыг цэвэрлэх үйл ажиллагаанд зарцуулахгүй гэдэг ерөнхий чиглэлийг Засгийн газар 2023 оны 05 дугаар сарын 193 дугаар тогтоолоороо өгөгдчихсөн байгаа.

Тэгэхээр бид хэд Дэлхийн банктай ярьж байгаа энэ зээлийн хэлэлцээрээ зөвхөн энэ Эмээлтийн 539 га дээрх эхний ерөнхий төлөвлөлтийн дагуу шаардлагатай тэр дэд бүтцийн эхний бүтээн байгуулалтын ажлуудыг л хийх байгаа юм.

Дулаан, эрчим хүч, цэвэрлэх байгууламж. Эргээд яах вэ энэ замын асуудлууд бий.

Гэх зэрэг энэ асуудлуудыг л зөвхөн зээлийн хэлэлцээрээр хийнэ. Бусад асуудлуудыг хувийн хэвшил маань өөрөө хийнэ. Эргээд төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хийж болох.

Ер нь Хан-Уул дүүргийн 13, 20 дугаар хороон дахь 30.5 га газрын цаашдын нөхөн сэргээлт. Эргээд энэ асуудлуудыг нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний хувьд нарийвчлан ярилцахаар байгаа.

Үүнийг бид хэд хот төлөвлөлтийн хувьд цаашдаа ямар байдлаар авч явах вэ гэдэг асуудал байгаа.

Газрын хувьд одоогоор мэдээж хувийн хэвшлийн ашиглах эрхийн болон эзэмших эрхийн хүрээнд байгаа асуудал.

Тэгэхээр үүнийгээ бид яриа хэлэлцээрийнхээ хувьд эцэслэн шийдэж явах юм.

Тэгэхээр ер нь хотоос үйлдвэрлэлийн бүс маань гарна.

Түрүүн гишүүд маань хэлж байгаа. Ер нь хот тэлж байгаа. Удахгүй хот дотроо үйлдвэртэй болчих вий.

Тэгэхээр одоо цаашдаа технологи өөр болсон байгаа. Хог гэдэг зүйл бараг үлдэхээргүйгээр боловсруулах боломжтой буюу эдийн засгийн эргэлтэд оруулах боломж байгаад байдаг. Технологиуд хөгжсөн байна. Бид хэд л удаашралтай, аливаа зүйлийн боломжийг олж харахгүй жижиг эрх ашиг гэдэг юм уу, ойлголцож чадахгүй юмнаас болоод л бүх зүйл гацчихаад байгаа.

Тэгэхээр энэ зүйлүүдийг, алдааг ял гаргахгүй байх үүднээс эргээд энэ цэвэрлэх байгууламжуудын технологийн асуудлыг мэдээж байгаль орчин болоод суурьшлын бүсэд нөлөөлөхгүй байдлаар шийднэ.

Ер нь энэ Эмээлтийн аж үйлдвэрийн паркийг дагаад Улаанбаатар хот дагасан 14 дагуул болон хаяа хотуудын нэг болох Эмээлт, Аргалант гэсэн дагуул хотын төлөвлөлт явж байдаг. Үүнтэйгээ уялдуулж аливаа асуудлыг бид харахыг хичээж байгаа гэдэг зүйлийг хэлье.

Г.Ганболд: Ажлын хэсгийн 3 номер.

М.Ганхүлэг: Г.Ганболд гишүүний асуултад хариулъя.

2024 оны улсын төсөвт Дархан арьс, ширний цогцолборын цэвэрлэх байгууламж дээр 11.9 тэрбум төгрөгийг оруулсан байгаа. 2 жил дараалаад хийгдэхээр төсөв орсон байгаа.

Үүнийг 180 га дээрх одоогийн хийгдсэн байгаа тэр суурийг үргэлжлүүлэх байдлаар бид бүхэн техник, эдийн засгийн үндэслэлийнх нь

дагуу зураг төсвийг нь оруулаад 2024 оны төсөвт суулгасан.

Тэгэхээр энэ төсөв татагдах гэж байгаа. Дээрээс нь дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлууд дараа дараагийн жилүүдэд хүлээх ямар ч боломжгүй болж байгаа.

Тэгээд хэд хэдэн удаагийн уулзалт, хүлээцтэй байдал, ингээд янз янзын байдлаар ингээд ерөөсөө энэ үндэслэлүүдийг үндсэндээ харгалзан үзээд тодорхой хэмжээгээр энэ дээр төр өөрөө зоригтой шийдлийг гаргаад, энэ дэд бүтцийн ажлуудаа бүгдийг нь хүлээж аваад, цэвэрлэх байгууламжаа бариад, хувийн хэвشلүүдийнхээ ажлуудыг үргэлжлүүлээд, ингээд явуулах талаас нь ажиллах бүрэн боломж нь одоогоор байгаа.

Тийм учраас 2024 оны төсөвт суулгачихсан энэ цэвэрлэх байгууламжийн ажлыг, явагдсан байгаа тэр техник, эдийн засгийн үндэслэлийнх нь дагуу үргэлжлүүлээд тэр суурийг нь ашиглаад ингээд явуулах боломж нь байгаа.

Энэ дээр гол нь хувийн хэвшилтэйгээ шууд энхийн зарчмаар гэдэг юм уу, тохиролцоод явахад ер нь боломжгүй байна. Тактикийн хувьд хэлэхэд хугацаа хожих ийм байдлаар ажиллаад эхэлж байна.

Тийм учраас бид тэрийг нь хараад хүлээгээд суугаад байлгүйгээр тодорхой шийдлийг гаргая гэдэг ийм байр суурь луугаа очихоос аргагүй болоод л байна л даа. Тийм.

Г.Ганболд: Тэгээд одоо яана гэнэ ээ. Энэ чинь би ерөөсөө ойлгосонгүй.

Болох юм шиг, боломжгүй юм шиг л юм ярих юм. Би тэгээд юу гэж ойлгох вэ?

Хувийн хэвшлийн юман дээр та нар төрийн мөнгө хийж болох юм уу? Тэрийг нь чи нэг хэлээдэх дээ. Яг болох юм уу, болохгүй юм уу?

М.Ганхүлэг: Төрийн тусгай хэрэгцээнд аваад үйл ажиллагааг нь үргэлжлүүлэх тодорхой шийдлүүдийг гаргасан тохиолдолд энэ ажлууд шууд үргэлжлүүлээд явах боломжтой.

Яг одоогийн байдлаар хувийн хэвшлийн шүүхийн маргаан, энэ зүйлүүдийг нь бид хүлээх юм бол энэ асуудал дахиад түрүүчийн дурддаг эрсдэлүүд үүсэх гээд байна.

Г.Ганболд: Тусгай хэрэгцээнд авна аа? Тусгай хэрэгцээнд авахаар болдог юм уу?

М.Ганхүлэг: Яах вэ, тэрийг ажлын хэсэг дээрээ ярих нь зөв байх.

Г.Ганболд: Хувийн 180 га газрыг тусгай хэрэгцээнд авч болох уу? Тэрийг нь тодорхой хэлээдэх дээ.

М.Ганхүлэг: Газрыг үндсэндээ шилжүүлэн аваад ашиглаад явах боломжтой.

Дээр нь байгаа тэр бүтээн байгуулалтын ажлыг Эрчим хүчний төв, Барилга хөгжлийн төвийн гаргасан дүгнэлт байж байгаа. Мэргэжлийн байгууллагын. Тэр дүгнэлтээр нь бид бүхэн нөхөн төлбөр олгоод авах боломж бас байгаа. Тийм.

Г.Ганболд: Үг хэлэх гишүүн байна уу? Үг хэлэх гишүүд нэрсээ өгье.

Г.Дамдинням гишүүнээр тасаллаа.
Д.Батлут гишүүнээр. Ц.Анандбазар
гишүүн.

Ц.Анандбазар: Тэгээд одоо энэ олон жил явсан энэ үлгэрийг дуусгая.

Байнгын хорооны гишүүд ээ, сайд аа.

Ер нь нэг юм харагдаад байна. 30 жил боловсруулж чадаагүй юм чинь одоо 3 жилд, 3 сард боловсруулах боломжгүй ээ.

Та бүхнийг ойлгож байна. Та бүхнээс гадуур юм явчихсан.

Тэгэхээр одоо ганц гаргалгаа юу байна гэхээр мэдээж хэрэг дэд бүтцийг нь төр хийнэ. Хаана хийх вэ гэдгээ шийднэ.

Үйлдвэр үнэхээр ашигтай байх нөхцөлийг нь бид харахгүй бол 5 үйлдвэр Монголд багтахгүй. Гадаад зах зээлээ харах хэрэгтэй.

Тэгээд ажлын хэсэг байгуулъя. Зарчмын асуудал.

Ажлын хэсэг байгуулаад, яамныхантай хамтраад нэгдүгээрт хаашаа экспорт хийх вэ гэдгээ шийдэх хэрэгтэй байна. Энэ чинь тэгээс эхэлж байна шүү дээ.

Хоёрдугаарт, үнэхээр хийх гэж байгаа юм бол хаана байгуулах вэ гэдэг газар зүйн байрлалаа дахиад шийдэх хэрэгтэй байна.

Гуравдугаарт, энэ олон үйлдвэрийг хэдийг нь үлдээж хэдийг нь хийх вэ гэдэг шийдлээ бас гаргах хэрэгтэй байна. Улаанбаатар хотын салхин дээр ийм үйлдвэр барьчих юм бол

бид дахиад утааныхаа араас асуудалтай болчихно.

Дөрөвдүгээрт, цаашдаа банк оролцохдоо улсын газрыг барьцаалж зээл өгдөг ийм зангууны үлгэр байхгүй ээ.

Хөгжлийн банкныхан ийм зээл өгөх юм бол одоо өөрсдөө төлдөг болох хэрэгтэй.

Хөгжлийн банк ганцхан үүрэгтэй шүү дээ. Хувийн хэвшил сайн ТЭЗҮ хийгээд гаднын банкнаас зээл авахаар боломжтой болонгуут баталгаа гаргаж өгөх л ёстой юм.

Түүнээс зээл олгодог энэ юм чинь ерөөсөө лобби болоод ингээд танай банкны үлгэр эхэлсэн шүү дээ.

Одоо бид нэг зүйл ойлгохгүй бол болохгүй байна. **“Төр муу менежер”** гэдэг нэр юунаас гарсан гэхээр **“Мэдэхгүй юмыгаа мэддэг баахан дарга нар гараад, амьдралд хэрэгжихгүй төсөл хэрэгжүүлээд”** ингээд бид ядуу амьдраад байна шүү дээ.

30 жил арьсаа боловсруулж чадаагүй байж тэгээд өөр ямар үлгэр ярих вэ. Гадаадын орнууд инээж байна шүү дээ.

Тэгэхээр одоо яах вэ гэхээр ямар нэгэн даргын үгийг дамжуулдаг, нүүр нь болж суудаг энэ байдлаасаа гараад, яг ард түмнээ бодсон төсөл хэрэгжүүлж эхлэх хэрэгтэй байна.

Би та бүхний насыг хүндэлж байна.

Тэгэхдээ та нарт үйлдвэрийн туршлага алга байна. **“Үйлдвэр”** гэдэг чинь **“ашигтай юмыг л үйлдвэр гэдэг”**. **Цехийг үйлдвэр гэж хэлдэггүй.**

Үйлдвэр байгуулахын тулд асар том судалгаа хийдэг социализмын үеийн тэр судалгааг харах хэрэгтэй.

Социализмын үеийн бүх үйлдвэр ашигтай байсан шүү дээ. Сөрөг тээвэр хийдэггүй байсан. Юун үйлдвэр байтугай. Тээвэр ложистик, ханган нийлүүлэлт, урсгал, түүхий эд, гадаад татан авалт, үнэ хөлс, валютын ханш, бүх юмыг тооцож байж үйлдвэр гардаг.

Хажуу хөрш Хятад Улс бүхнийг үйлдвэрлэж байна. Ийм үед хамаагүй үйлдвэр гэдэг үгээр тоглохоо болих хэрэгтэй.

Монголд хэдхэн үйлдвэр байх боломжтойгийн нэг нь энэ арьс, ширний үйлдвэр байгаа юм.

Тэгэхээр энэ урт зангууны үлгэрээ одоо дуусгах ганц арга бол тэр өмнө өгсөн зээл, өмнө өгсөн тэр олон төслийнхөө учрыг тэр урд талын хүмүүс нь учраа олог ээ.

Тэр хуулиараа явна уу, хаагуураа явна уу. Та нар өөрсдөө шийдэх ёстой.

Шинээр эхлэх үлгэр өөрөө нэг жилийн дотор энэ үйлдвэрийн дэд бүтэц дуусах ёстой юм. Энэ чинь дэд бүтэц шүү дээ. Ямар үйлдвэр ярьж байгаа биш дээ.

Тэгээд иймхэн юмыг хийж чадахгүй байж төр гэж яриад хэдэн сайдын нүүр үзээд явах юм бол энэ чинь дэндүү онигоотой юм болно шүү дээ.

Тэгэхээр ерөөсөө зарчмын асуудал. Яаманд байгаа хүмүүс дээрээсээ их дарамттай байгаа харагдаад байна. Энэ хариулж байгаа хариултыг нь харахад ойлгомжтой байна шүү дээ.

Их Хурлаас, Байнгын хорооноос ажлын хэсэг гаргах хэрэгтэй.

Тэгээд маш ажилсаг, зөв шийдвэр гаргаад малчдынхаа нурууг тэнийлгэж малын гаралтай түүхий эд арьс, ширийг үнэтэй болгох 2025 оны ажлыг одоо эхлэх хэрэгтэй байгаа юм. Ингэж байж л бид гаргалгаанаас гарна.

Та нарын ярьж байгаа юм их олон буруу юмнууд байна. Нэг үйлдвэр барьж чадаагүй байж 5 үйлдвэр зэрэг барьдаггүй юм аа. Энэ чинь бизнесийн хууль шүү дээ. Амьдрал дээр байдаг юм. Нэг үйлдвэр.../минут дуусав/

Г.Ганболд: Ц.Туваан гишүүн.

Ц.Туваан: Хэдүүлээ одоо бас тэр ажил хэрэгч саналаа явуулаад ажлын хэсэг дээр.

Одоо нэгэнтээ гараа дүрчихсэн. Одоо үүнийгээ ажил хийвэл дуусгая.

Тэгэхээр ажлын хэсэг байгуулаад хамтраад. Хувийн хэвшлийнхнийгээ ч оруулж ирье. Тэр улсууд төрийн бодлого нь юм байна, шийдвэр нь юм байна гээд дэмжээд орчихсон хувийн хэвшлийнхнийг огт хохироож болохгүй.

Энэ чинь Монгол Улс зах зээлийн эдийн засагтай. Хувийн хэвшлийнхээ нуруун дээр, тэд нарын төлж байгаа татвар дээр амьдарч байгаа улс. Одоо тэд нарын оруулсан хөрөнгийг, тэд нарын оруулсан хөдөлмөрийг үнэгүйдүүлж болохгүй.

Тэгэхээр энэ дээр тал талаасаа сууж байгаад шийдлүүдээ гаргая.

Хоёрдугаарт нь, малчид маань маш их хүлээлттэй байсан. Одоо тэгээд

дахиад л хүлээх хэрэгтэй л болж байна л даа.

Тэгэхээр энэ дээрээ хэдүүлээ бас хурдавчилъя. Тэгэхгүй бол энэ одоо жалгын нэг хаягдаж байгаа түүхий эдийг хараад манай ахмадууд хүртэл үнэхээр их шогширч байгаа. Энэ одоо нохой ч тоож идэхгүй хаягдаад байгаа, жалгын нэг хаягдаад байгаа түүхий эд, хайран түүхий эд. Энэ чинь мөнгө шүү дээ. Тийм ээ.

Тэгэхээр энэ дээрээ хэдүүлээ сэтгэл гаргаад ажиллая.

Тэр үйлдвэр маань Дарханд ашиглалтад орчих юм бол, энэ чинь орчихсон бол, хугацаандаа явж байсан бол энэ чинь нэлээн ажлын байрууд гараад ирчихсэн асуудлууд шийдэгдээд явах л байна л даа. Тэгээд бид алдагдсан боломж гэж бас үүнийг л хэлэх болов уу гэж бодож байгаа.

Тэгэхээр тэр арьс, шир дээр Хөдөө аж ахуйн яам байдаг юм уу, энэ холбоо ч гэсэндээ тэр юуны гэмтэл бол. Мэдээж тэр 10 жилийн өмнөх, 15 жилийн өмнөхөөс малчид малаа баандуулаад, малаа эрүүлжүүлэх тал дээр сум болгон дээр, баг болгон дээр мал угаалгын асуудлууд улсын төсвөөр ч, хувийн хэвшлээр ч, орон нутгийн хөрөнгөөр ч гэсэн маш сайн шийдэгдсэн. Үүний үр дүн гарсан. Тэр тодорхой. Яг хуучны асуудал байхгүй шүү. Энэ малын паразит өвчин дээр.

Тэгэхээр энэ дээр тэр бойны үеийн асуудал дээр ч гэсэн бас ер нь нэг зөвлөмж, сургалт, гарын авлага ч юм уу, иймэрхүү юмнуудыг бас бага гэлтгүй хийгээд явах ёстой гэж бодож байгаа.

Дараагийн нэг асуудал энэ арьс, ширний урамшууллыг Хөдөө аж ахуйн

яам, дэд сайд байна, газрын дарга нь байна, мэргэжлийн холбоо нь байна.

Үүнийг чинь болино гэдэг асуудал байхгүй шүү. Улсын төсөв дээр үүнийг тавьчихсан. Олгохгүй байгаа асуудал дээр нь одоо ярина. Энэ яагаад олгогдоогүй юм гэдэг асуудал.

Улсын төсөв дээр энэ мөнгийг жил болгон Хөдөө аж ахуйн сайдын багцад баталж өгсөн. Одоо 2 жил олгогдоогүй асуудал гэдэг бол үүнийг олгох ёстой. Малчдын хувьд энэ чинь хэдэн хүн ч бай, нэг хүн байсан ч гэсэн энэ чинь орлого шүү дээ.

Тэгэхээр энэ орлогыг олгох ёстой. Энэ дээр ажиллах шаардлага байгаа юм байна.

Цаашдаа тэр шалгууруудаа тавь л даа. Энэ урамшуулалтайгаа тэр нэг, хоёрдугаар зэргийн арьс гээд нэрлээд байгаа зүйлүүдээ холбоод өгчих л дөө.

Энэ чинь нэг нь өгч байгаа, нэг нь авч байгаа шүү дээ. Муу эсгэчихсэн, ашигтай талбай дээрээ цоорчихсон арьсаа ялгаад, урамшууллын өгөхгүй ингээд явчхаж болно шүү дээ.

Харин тэгэхэд бэлэн арга хэлбэрээ олоод явж байгаа үйлдвэрлэлээ, малчид аа дэмжиж байгаа бодлогоо буцаана гээд болиулах маягийн юм яриад явж байгаад нь би эмзэглэж байна.

Тэгэхээр энэ асуудлыг дэмжихгүй байна.

Энэ чинь эргээд өөрөө малчдын эх үүсвэр талдаа. Дахиад хууль хүртэл батлагдсан шүү дээ. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлээ төлөх хүртэл хууль батлагдсан байгаа.

Тэгэхээр үүнийг бодож ажилламаар байгаа юм. Хөдөө аж ахуйн яам.

Г.Ганболд: Ж.Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Монголын төр бодвол үйлдвэржилтийнхээ бодлого, зураглалыг зүгээр сууж байгаад гаргачхаагүй байх л даа. Тодорхой нөөц бүх юман дээрээ тулгуурлаж, тодорхой судалгаан дээр тулгуурлаж 4 бүсэд ийм хүчин чадалтай ийм байх юм гэдгээ харсан байлгүй дээ. Би тэгж хийсэн байх гэж бодож байна.

Тийм учраас энэ бүсүүдэд эхэлсэн ажлуудыг ямарваа нэгэн эргэлзээгүйгээр урагшлуулах, цаг хугацаа нааш нь татах ийм л ажил руу гол анхаарлаа төвлөрүүлэх ёстой гэж. Нэгдүгээрт ингэж харж байна.

Хоёрдугаарт, тов тодорхой үйлдвэрлэлийн районоор бүс нутаг тогтоосон бол тэр үйлдвэрүүдийнхээ эрх ашгийг хамгаалмаар байна.

Иргэдийнхээ суурьшлын бүс болгож давхар төлөвлөлт хийгээд үймүүлчхэв ээ, та минь. Тэрийг хот онцгой анхаарах ёстой. Наад хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө юмандаа тов тодорхой барьж ажиллахгүй бол бид нэгийг нөгөөгөөр нь нухаад л яваад байгаа улс шүү дээ. Түүнээсээ болоод хүндрэлийг бий болгоод л байгаа улс шүү дээ.

Түүнээс үйлдвэрийн район гэж тов тодорхой тогтоогоод, тэнд үйл ажиллагаа эхлүүлчихсэн бол тэднийг бид хамгаалах л ёстой. Тэнд суурьшлын бүс бий болгочоод иргэдэд хортой нөхцөл бий боллоо гэж яриад байдаг юмаа л болих ёстой.

Тэгэхээр төлөвлөлтийн өөрийнх нь шинжлэх ухааны үндэслэлийг зөв хангаж ажиллах ёстой. Би энэ талаасаа анзаарах байлгүй дээ гэж бодож харж байна гэдгийг зориуд хэлмээр байна.

Дараагийн нэг зүйл. Засгийн газар өнгөрсөн жил боловсруулаагүй арьс, ширийг гаргах тухай асуудал шийдлээ хийчихсэн.

Тэгэхээр одоо үүнийг бид ажил болгох ёстой. Ингэхийн тулд холбоо нь ч анхаарах ёстой, энэ асуудлаа барьж байгаа яам нь ч анхаарах ёстой, наад бизнесийн байгууллагууд нь ч анхаарах ёстой.

Бид үнэхээрийн л ашиглаж чадахгүй байгаа юм бол тодорхой хэсгээ л гаргая л даа. 20 гаруй сая арьс, шир л жилд гарч байгаа.

Түүнээсээ бид 6 сая орчмыг нь л боловсруулж чадаж байна л гэж ярилаа. Тэгээд цаана нь 16, 17 сая арьс, шир гаргах тухай л асуудал байна шүү дээ. Тийм биз дээ. Үүнийгээ хийх ёстой.

Тэнд нэг том төсөл хэрэгжээд үйлдвэр байгуулагдсаны ар дээр бүх юм явна гээд сэтгэл амар сууцгаамааргүй л байна л даа. Хэдүүлээ энэ рүүгээ л орж ажиллах тухай л асуудал байна. Үүнийгээ нэгдүгээрт шийдье.

Хоёрдугаарт, наад арьс, ширний урамшуулал гэдэг чинь зүгээр хэн нэгэн өгөхгүй байгаад байгаа юм биш ээ.

Жалганд хаягдчихсан байгаа арьс, ширэнд яаж урамшуулал өгөх юм. Наад үйлдвэрүүд чинь авахгүй, хоршоод нь, үйлдвэр авахгүй байгаа учраас малчдаасаа арьс, ширээ авахгүй. Падаан, фактур гэдэг юм уу, НӨАТ бичигдэхгүй л байгаа шүү дээ. Тийм биз дээ.

Тэгэхээр яаж бид арьс, ширний урамшуулал өгөх юм. Наад арьс, ширний урамшуулал олгогдохгүй байгаа юм чинь хэн нэгэн санаатайгаар гэдэг юм уу явуулаад байгаа зүйл биш.

Угаасаа наадах чинь эргэлтэд орж өгөхгүй байгаа учраас бүртгэлгүй арьс, ширэнд яаж урамшуулал өгдөг юм. Бид энэ л талаасаа л бодож. Харин үүнийг эргэлтэд оруулах юмаа л онцгой анхаарч л ажиллах ёстой гэдэг ийм л зүйл байгаад байна шүү дээ. Энэ рүү л одоо бүгдээрээ л бодох ёстой болов уу л гэж бодох юм.

Ер нь тэгээд эцэст нь төрийн бодлого, ажлуудын хоорондын уялдаа юмнуудыг их л зөв хэдүүлээ харж хийхгүй бол болохгүй болоод байна л даа. Яах аргагүй хэн нэгний бизнесийн зөв санаа, ТЭЗҮ-г хэн нэгэн авч ашиг хийх гээд байдаг энэ нэг балай юм чинь л бидний бүх ажилд саад болоод байгаа байхгүй юу. Ерөөсөө анхнаасаа эхлэхдээ тэгж эхэлсэн юм билээ. Наадах чинь.

Тийм учраас үүнийг их зөв эхэлчихсэн эхлээд явж байсан юмыг хэн нэгэн завсар нь үймүүлчихсэн ч юм бас биш юм билээ. Наадхыг чинь газар дээр нь ч очиж үзсэн, явж байсан үйл явцуудыг нь ч харсан. Бүх юман дээрээ ийм юм байгаад байдаг байхгүй юу.

Тийм учраас одоо тэр хариуцах ёстой байгууллага, төсөл юмаа боловсруулсан улсуудаа.../минут дуусав/

Г.Ганболд: Г.Дамдинням гишүүн.

Г.Дамдинням: Бид юу яая даа. Манай Байнгын хорооны гишүүд ээ,

Нэгэнт одоо бид энэ чиглэлийн төрийн хамгийн том бодлого гаргах бүтэц сууцгааж байна.

Тэгээд нэгэнт гүйцэтгэх засаглалд байгаа, тэгээд одоо манай яамныхан, тэгээд л энэ Хөгжлийн банк гээд л, тэгээд л энэ орон нутаг гээд л, нийслэл гээд л, тэгээд л энэ холбоод гээд ойлголцохгүй байгаа бол Их Хурал оролцъё доо.

Г.Ганболд дарга аа, ажлын хэсэг байгуулаад орчихъё. Тэгээд ярилцъя.

Арьс, ширний холбооныхон маань нэг юмыг буруу ойлгоод байна.

Дархан арьс, ширний цогцолборт зөвхөн 100 мянган хүнтэй хотын арьс, ширийг янзлахгүй, боловсруулахгүй. Та нар жижиг нүдээр харахгүй.

Хойд бүсийг тэр чигт нь хамарсан л боловсруулалт хийнэ гэсэн ийм л анхны ТЭЗҮ-тэй. Монголын бүх арьсыг боловсруулна гэж явж байсан.

Ховдод нэгийг хийнэ, зүүн бүсэд нэгийг хийнэ. Ингээд л явж байсан ийм л концепцтой юм.

Яах вэ, та нарын эрх ашгийг ойлгож байна. Би өөрөө энэ Эмээлтийн арьс, ширний цогцолборын тухай асуудал Байнгын хорооны тогтоолын төсөлд орж байхад би дэмжээгүй юм.

Сая Ц.Туваан гишүүн ч хэлж байна, Ц.Анандбазар гишүүн ч хэлж байна, бусад гишүүд хэлж байна.

Манай хүн амын өсөлт сүүлийн үед их хурдацтай явагдаж байгаа. Улаанбаатар хотынхоо дунд орчих вий дээ. Улаанбаатарын утаа ярихаараа баруун хойноосоо их салхитай байна.

Тийм учраас утаа орж ирээд байна гэдэг юм ярьдаг мөртлөөсөө баруун талд нь аваачаад арьс, ширний үйлдвэр барина

гэдэг чинь бас л их л эргэлзээтэй дээ.
П.Сайнзориг дарга аа.

Сайн л хараарай. Дараа нь энэ утаа шорооныхоо асуудал дээр нэмээд өмхийний асуудалтай болчих вий дээ. Энэ чинь их олон сая арьс, шир боловсруулна шүү дээ. Технологи сайжирсан. Тэгэхдээ хэдүүлээ ер нь ямархуу юм хийх юм бол доо. Тэрийгээ бодоорой.

Тэгээд та нар хийж чадна гэж байгаа бол хийх л юм байлгүй дээ, бодвол. Тийм. Оролцоод байх юм алга.

Миний хувьд Дархан арьс, ширний цогцолбор дээр дахиад хэлье.

Төр Их Хурлаасаа чиглэл гаргаад Хөдөө аж ахуйн яам, хариуцсан яамдыг нь гуравласан сайдын гурван яамны хамтын шийдвэр гаргаад, Барилга, хот байгуулалтын яам, Эрчим хүчний яам, Хөдөө аж ахуйн яамны сайд нарын шийдвэр гаргаад ажлын хэсэг байгуулаад хувийн хэвшлийнхэндээ учраа олох гэж байхад олгохгүй гээд эрх хүүхдийн ааш гаргаад байгаа бол оролцуулаад байх хэрэггүй.

Бас нэг бодит үнээ гаргаад, бодит яриагаа хийгээд, бодит гаргасан зардлаа төрөөс нөхөн төлбөр хэлбэрээр авна гээд ярилцаж байгаа бол өөр хэрэг. Тэгвэл суугаад ажил ярьцгаая.

Үгүй ээ гэвэл тэгээд л төр өөрөө аваад л цаашаа явахаас өөр арга байхгүй.

Дэд бүтцийг нь төр л хийх юм билээ. Өөр гарцгүй. Ингэж байж бид 300 мянган малчин, 150 мянган малчин өрхийнхөө ахуй амьжиргаанд нь нэг нэмэртэй юм хийчихмээр байна.

Би саяхан шүү дээ. 4 ямаа гаргаад арьсыг нь зараад шүдлэн үхэр аваад өвлийнхөө идшийг хийж байсан байхгүй юу. Манай аав, ээж бид гурав. Хөдөө. Малын арьс тийм үнэтэй байсан үе байгаа. Тийм ээ.

Тэгэхээр үүнийг боловсруулаад гаргаж эдийн засгаа төрөлжүүлнэ гэдэг бол бид нарын зорилго мөн.

Тэгээд судалгаа, тооцоог нь хийчихсэн байгаа хамаа алга.

Би Их Хурал дээр ажлын хэсэг байгуулчихъя. Дараачийн хуралдаан дээр. Г.Ганболд дарга аа, хэдүүлээ.

Тэгээд энэ хүмүүсийг дуудаж уулзаж байгаад яг ажил хэрэгт сууж байгаад энэ хувийн хэвшлийнхэн нь хийчихсэн байгаа бол тэр хийчихсэн байгаа юмыг нь үнэхээр яг тэр аудитын дүгнэлтээр нь тооцож өгье гэдэг асуудлыг Байнгын хороогоор, Их Хурлаар оруулаад шийдүүлье.

Тэгэхгүй бол одоо энэ төсөв дээр тавьчихсан байгаа мөнгө гацлаа шүү дээ. Бөөн юм болж байж мөнгө тавиулж байгаа шүү дээ, бид нар. Ийм л байна.

Г.Ганболд: Д.Батлут гишүүн.

Д.Батлут: Сүүлийн үед яг үнэндээ ашигтай том төсөл бүр дээр л мэдээлэлд ойрхон байдаг хүмүүс, дарга цэрэг нарын оролцоо байснаас будилаан хутгадаг нөхцөл байдал салбар бүр дээр гарч эхэлж байна л даа. Гарч байна. Гарсаар ч байгаа юм байна.

Яг л ийм нөхцөл байдал энэ арьс, ширний салбар дээр бас нүүрлээд байна гэж харж байгаа юм. Тухайлах юм бол Дарханд шүү дээ.

Яах вэ, гишүүд янз янзын өөр мэдээлэлтэй байгаа байх.

Тэгээд энэ нөхцөл байдлуудыг бид яаралтай засаж залруулахгүйгээр цаашдаа энэ өөрөө нэг голдиролд ороод явах боломж бололцоо хомс юм.

Яг ийм байдлууд нүүрлэснээрээ өнөөдөр 300 мянган малчны олж болох ёстой байсан орлого жалгын нэг хог болоод явчхаж байгаа.

Тэгээд энэ дээр бид төр нь төр шиг байгаад, хувийн хэвшилтэйгээ хамтраад хийх ёстой юмнуудаа нэг тодорхой болгоод явах хэрэгтэй байгаа юм. Хамгийн гол нь энэ олон хүний мэдээлэлд ойрхон байдаг, ашигтай орлоготой, юм болгон дээр олдог тэр нэг сүлжээг л бүгдээрээ таслан зогсоочихмоор байгаа юм даа. Ингэхгүй бол ажил явахгүй дээ.

Дархан дээр юу болсныг мэдэж байгаа шүү дээ. Бүгдээрээ.

Тэгэхээр энэ бодит нөхцөл байдалдаа тулгуурласан зөв гарц гаргалгааг манай яамныхан, бодлогын байгууллагууд нь олооч ээ.

Тэр хууль хяналтын байгууллагад нь өгдөг бол өгөөд шийдлүүдээ гаргах хэрэгтэй.

30 жил бид ийм нөхцөл байдалд явж байна. Одоо цаашдаа яах юм. Ахиад л ийм байдлаар явах юм уу. Хэрвээ арьс, ширний үйлдвэрүүдийг бид ашиглалтад оруулаад, эргэлтэд оруулчих юм бол тэр малчин өрхүүд ч гэсэн тодорхой орлоготой. Дээрээс нь өртөг шингэсэн үйлдвэрлэл бий болж, бид дотооддоо үйлдвэрүүд бий болгосноороо эдийн засгаа солонгоруулах бодит боломжууд ч гэсэн бүрдэнэ шүү дээ.

Яг өнөөдөр бид нарт юу саад тээг болж байна гэвэл яг ийм нэг мэдээлэлд ойрхон байдаг олон хүний эрх ашиг л нөлөөлөөд байгаа шүү. Нөхдүүд ээ. Үүнээс ангид ажилламаар байна гэдгийг хэлье. Баярлалаа.

Г.Ганболд: Гишүүд үг хэлж дууслаа.

Ер нь хэдүүлээ нэг шийдвэртэй л юм хийхгүй бол болохгүй нь. Гишүүдийн дийлэнх нь ажлын хэсэг гаргая гэсэн санал байна.

Бид үүнийг дараагийн Байнгын хорооны хурал дээр ярилцъя.

Тэгэхдээ ер нь би хөндлөнгийн хүний нүдээр гэдэг юм уу, төрд ажиллаж байсан хүний нүдээр харахад энэ Хөгжлийн банкны шүүхийн шийдвэр гарахаас нааш үүнийг шийдэх боломжгүй юм байна, ер нь.

Эсвэл бид хувийн хэвшлийнхэнд гай бололгүй Дарханы арьс, ширний үйлдвэр гээд төрийн компаниа татан буулгаад зүгээр тэр хувийнх нь өөрсдөө ажлаа бодог. Дунд нь бас хэдэн хүн цалинжиж, төрийн мөнгийг ингэж сууж байхаар эсвэл болимоор байна шүү дээ. Бүр татан буулгах хэрэгтэй байна, бүр.

Тэгээд тэр хувийнх нь өөрсдөө зүгээр тэр хөрөнгө оруулалтаа олно уу, байна уу. Тэр газраа барьцаанд тавиад дахиж үргэлжлүүлнэ үү. Энэ юмыг нь нэг талд нь гаргахгүй бол одоо бид энэ жилийн арван хэдэн тэрбум төгрөгийг та нар одоо 23 тэрбум 2 жил дамнах. Тэрийг ашиглаж ч чадахгүй юм байна, ер нь. Ашиглаж чадахгүй, боломжгүй. Хуулийн хувьд боломжгүй, наадах чинь. Хувийн хэвшилтэй учраа олоогүй үед хувийн

хөрөнгө дээр Та нар төрийн мөнгөөр юм хийнэ гэж байхгүй.

Тэгэхээр сая гишүүдийн хэлж байгаа шиг эсвэл тэр хувийн хэвшлийнхэнтэйгээ яг тийм бодитой гаргасан зардлаа Хөгжлийн банкныхаа тэр асуудлыг шийдвэрлүүлээд тэгээд төр лүү өгье гэх юм бол тэрийг нь шууд аваад ингээд 100 хувь явуулах, эсвэл тэр хувийнханд гай бололгүй төр тэр Дарханы арьс, ширний үйлдвэр гэж юмаа татан буулгаад өөрсдөө замаараа явцгааг. Энэ шийдвэрийг ер нь ойрын үед гаргах хэрэгтэй.

Тэгэхгүй бол би яг 4 жил харлаа. Яг 4 жил харлаа. Яг 4 жил харахад нэг ч алхам ахисангүй. Бөөн хар зардал. Тэр арьс, ширний үйлдвэрийн захирал гээд нөхдүүд нь гадаад, дотоод явсан, нэг туршлага судалсан, бөөн мөнгө төгрөг үрсэн ийм л хэдэн нөхөр байна шүү дээ.

Өр дээр өрний нэмэр. Тэгээд үүнийгээ хэдүүлээ гацаанаас гаргахгүй бол ард түмнээс уучлалт гуйгаад юу гэх вэ, зүгээр одоо тэгээд дараагийн тэр боломжтой үйлдвэрүүдээ өөд нь татаад.

Ер нь цаашдаа төр ийм юм руу орохоо болиод энэ байгаа суурилуулагдсан хүчин чадал, тэр шевро, булигаар байна уу, тэр “Дархан минж” байна уу, тэд нарт харин тэр хөнгөлөлттэй зээл олж өгөх тал дээр нь л бид төр дэмжих ёстой юм байна, ер нь.

Мэргэшсэн. Өөрсдөө тэр үйлдвэрлэлээрээ дагнаад бас харьцангуй туршлага хуримтлуулчихсан мэргэжлийн тийм хүмүүст бид харин хөнгөлөлттэй зээл олж өгөх тал дээр л төр анхаарах ёстой.

Түүнээс одоо бид төр дундуур нь ороод тэрийг хийгээд явна гэдэг бол маш буруу болчихоод байна.

Тэгээд үүнийг анхаараад хэдүүлээ ойрын үед яам, Байнгын хороодтойгоо хэдүүлээ сайд нартай хамтарч уулзалт хийж байгаад хувийн хэвшлийнхнийг Та нартай уулзах уулзалт дээр ч гэсэн манай Байнгын хороо ер нь зохион байгуулалтын асуудалд нь оролцье.

Яг үнэхээр хувийнхан эсвэл зүгээр энэ гаргасан бодит зардлаа гээд байгаа юм уу, эсвэл түрүүнийх шиг 1 га газраа 1 тэрбум гээд 180 тэрбум төгрөг нэхээд байгаа юм уу.

Хэрэв тийм юм нэхэж байгаа бол хаях хэрэгтэй байхгүй юу. Битгий тэд нарт гай бол. Тэд нар өөрсдөө тэрийгээ зарна уу, үрнэ үү, тэр үйлдвэрээ цааш нь явуулаг.

Тэгээд энэ дээр хэдүүлээ яаралтай нэг арга хэмжээ авахгүй бол болохгүй байна.

Тэгээд Байнгын хорооны гаргасан тогтоолын хэрэгжилт үнэхээр бид нарын одоогийн дүгнэж байгаагаар ер нь нэг ч ахиц гараагүй юм байна гэсэн ийм л дүгнэлтэд хүрэхээр байна.

Тэгээд цаашдаа энэ саяын гишүүдийн хэлсэн зүйлүүдийг П.Сайнзориг дарга анхаарна биз дээ.

Ер нь нэгэнт эхлээгүй. Түрүүн тэр Арьс, ширний холбооны тэргүүн ярьж байна лээ. Мундаг ахиц гарсан. Хашаагаа бариад авсан гэж байх шиг болсон. Эмээлт дээр нэг том хашаа барьсан юм шиг байна. Миний ойлгож байгаагаар. Тийм ээ.

Тэр том ахиц байж магадгүй. Гэхдээ ер нь тэгээд юм хийчхээгүй дээрээ, эсвэл байршлийг нь өөрчлөх. Монгол Улс чинь газар мундсан биш. Тэртээ тэргүй дэд бүтэц нь шинээр хийх гэж байгаа газар бол ер нь болж өгвөл жаахан зайтайдуу л байхад буруугүй шүү. Саяын хэлж байгаа бас нэг үнэрний хэрүүл нэмэгдэх вий дээ.

Гэхдээ яах вэ орчин үеийн технологи бол шал өөр болсон. Цэвэрлэх байгууламж өөр болсон. Бид үйлдвэрүүдтэй очиж үзсэн. Мэдэж байгаа. Гэхдээ тэрийг анхаарч тэр төслөө яг яаж хэрэгжүүлэх вэ гэдгийг анхнаас нь сайн зөв зохион байгуулалттай хандаарай гэдгийг хэлье.

Тэр Хөгжлийн банкныхан ч гэсэн ер нь энэ асуудлаа шүүх дээр бушуухан шиг шийдэж нэг талд нь гаргаж төр нь авч явах юм уу, эсвэл хувийнхан нь авч явах уу гэдгийг нь шийдэлд хүрэх нь зүйтэй байна гээд.

Ингээд Байнгын хорооноос гаргасан тогтоолын хэрэгжилтийг хэлэлцэж дууслаа.

Ажлын хэсэг гаргах эсэх асуудлыг дараагийн Байнгын хорооны хурлаар хэлэлцэнэ.

Ажлын хэсэгт баярлалаа.

**Хоёр.Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны
2022 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 07 дугаар тогтоолын
хэрэгжилтийн талаарх мэдээлэл сонсох**

Дараагийн хэлэлцэх асуудлын дарааллын дагуу дотоодын сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, тус салбарт төрөөс үзүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлэх асуудлаар “Засгийн газарт чиглэл өгөх тухай” мэдээллийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд М.Ганхүлэг танилцуулна.

Ажлын хэсгийг танилцуулъя.

М.Ганхүлэг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд, Д.Довчинсүрэн Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, А.Нарантуяа Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга, Г.Наранчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Д.Отгонжаргал Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг

зохицуулах газрын мэргэжилтэн, Г.Ганхуяг Монголын сүүний нэгдсэн холбооны тэргүүн, Р.Цогтбуян Тэргүүлэгч гишүүн гэсэн ийм ажлын хэсэг байна.

Ажлын хэсгийн 3 номерын микрофоныг өгье.

М.Ганхүлэг: Байнгын хорооны гишүүддээ дараагийн танилцуулгаа танилцуулъя.

Өнөөдөр манай гурван асуудал орж байгаа.

Хоёр дахь нь энэ сүү, сүүн бүтээгдэхүүнтэй холбогдолтой асуудлууд байгаа юм.

Байнгын хорооноос 2022 оны 06 сарын 15-ны өдрийн тогтоолоор Хөнгөн

Үйлдвэрийн хөгжлийн дэд хороо 2022 оны 01 дүгээр тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцээд дараах чиглэлүүдийг өгье гээд сүү, сүүн бүтээгдэхүүнтэй холбогдолтой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүл гэдэг чиглэлийг өгсөн.

Салбарын ерөнхий мэдээллээс эхэлье.

Эрүүл мэндийн яамны мэдээллээр 2.8 сая хүн гэдэг тооцоолол гарсан байгаа.

Нэг хүний жилийн сүүний хэрэглээ нийт хүн амд 167.5 мянган тонн, сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээ 188.5 мянган тонн гэсэн хэрэглээ гарсан.

Бид бүхний нөөц үндсэндээ яг ашиглах боломжтой нөөц жилд гүү, үнээ, ингэ, хонь, ямааны сүүгээ бүгдийг нь оролцуулаад 614.2 сая литр сүү бид бүхний нийт ашиглах боломжтой нөөц байгаа юм.

Монгол Улсад нийтдээ 210 үйлдвэр цех, 82 хөргөлтийн төв, 36 тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах болон хадгалах үйлдвэрүүд байна.

Сүү, сүүн бүтээгдэхүүний боловсруулалтын хувьд 2022 онд нийтдээ 113.6 сая литр сүүг боловсруулсан үзүүлэлттэй байгаа.

Нийт сүү, сүүн бүтээгдэхүүнийхээ 60 хувийг зуны улиралд бид дотоодоосоо хангаж байна. Сэрүүний улиралд 30 хувийг дотоодоосоо хангаж байгаа үзүүлэлттэй байгаа.

60 хувь нь ойролцоогоор 367.3 сая литр сүү болж байгаа. Үүнээсээ 113.6 сая литрийг нь бид бүхэн үйлдвэрийн аргаар

боловсруулж сүү, сүүн бүтээгдэхүүн хийж байна.

253.7 сая литрийг нь гар аргаар бэлтгэж байна.

Шингэн сүүнийхээ дотоодын хэрэгцээгээ зуны улиралд бид бүхэн 100 хувь хангаж байна.

Сүү, сүүн бүтээгдэхүүнийхээ 63.2 хувийг дотоодоосоо хангаж байна. Үлдсэн хувиа бид гаднаас импортоор оруулж ирж байгаа юм.

Тогтоолоос өгөгдсөн эхний гол асуудлын хүрээнд бид бүхэн энэ сүүний урамшууллийг нэмэгдүүлэх, үргэлжлүүлэн олох асуудлыг зохион байгуулсан.

- 2020-2021 онд 8 үйлдвэр цехэд 8.6 сая литр сүүг бэлтгэж, 2375 малчин фермер 4.2 тэрбум төгрөгийн дэмжлэгийг авсан үзүүлэлттэй байгаа юм. Энд 4 аймгийн 13 сум хамрагдсан.
- 2021-2022 онд 4 аймгийн 17 сум болж нэмэгдсэн.
- 2022-2023 онд 7 аймгийн 20 сум болж нэмэгдсэн.
- 2023-2024 онд 10 аймгийн 27 сум болон нэмэгдсэн.

Ингээд хамгийн сүүлийн жилийн үзүүлэлтээр 24 үйлдвэр, цехэд нэг литр сүүнд мянган төгрөгийн урамшууллийг олгож эхлээд байгаа.

2023 оны 11 сараас эхлэн энэ сүүний урамшууллийг хоёр дахин нэмэгдүүлээд ажиллаж байна.

Бүх төрлийн малын сүүнд олгох ийм байдлаар Засгийн газрын тогтоолыг өөрчилж нэмэгдүүлсэн байгаа. Хуучин зөвхөн үхрийн сүү байсан. Бусад бүх төрлийн сүүнд урамшууллийг олгож байгаа.

11 сард 2.7 сая литр сүү 1954 малчин фермер өнгөрсөн оны 11 сард хамрагдсан.

Сүүлийн 3 жилийн хугацаанд сүү, сүүн бүтээгдэхүүнийг дэмжих урамшууллийг олгож эхэлснээр сэрүүний улиралд бэлтгэж байгаа дотоодын үйлдвэрлэл маань 52 хувиар өссөн үзүүлэлттэй гарсан байгаа юм.

Тогтоолын гол нэг заалт нь энэ сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдийг дэмжих, тодорхой хууль, эрх зүй татварын таатай нөхцөлийг бий болгох чиглэлээр арга хэмжээ авч ажиллаарай гэдэг ийм чиглэлийг өгсөн.

Энэ хүрээнд хүнсний хувьсгалын хөтөлбөрийг Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн санаачилгаар хэрэгжүүлж байгаа.

36 дугаар тогтоолыг баталсан. Зөвхөн сүү, сүүн бүтээгдэхүүн биш 19 нэр төрлийн 158 нэр төрлийн бүтээгдэхүүнийг гаднаас энэ тоног төхөөрөмжийг оруулж ирэхэд гаалийн албан татвараас чөлөөлсөн.

Энэ дотор сүү, сүүн бүтээгдэхүүний чиглэлийн 22 нэр төрлийн тоног төхөөрөмж бүтээгдэхүүнүүд орсон байгаа.

Уурын генератор, хөргөх төхөөрөмжийн компрессор, хийн компрессор, дулаан солилцооны аппарат,

халаах, хөргөх төхөөрөмж, хөргөх төхөөрөмжүүд, нөөцийн савууд гэдэг тодорхой нэр төрлийн бүтээгдэхүүнийг 2027 оны 01 дүгээр сарын 01-нийг хүртэлх хугацаагаар гаалийн албан татвараас чөлөөлсөн арга хэмжээг салбарын түвшинд авч авч хэрэгжүүлж байна.

Эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зээлүүдийг энэхүү 36 дугаар тогтоолын хүрээнд олгоод ажиллаж байна.

Хүнс, хөдөө аж ахуйн салбар хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр өнгөрсөн 2023 онд 1800 гаруй аж ахуйн нэгж энэхүү зээлд арилжааны 10 банкаар дамжуулан хамрагдсан байгаа. Урт хугацаатай, бага хүүтэй хүүгийн тодорхой урамшууллын төрөөс дэмжлэг үзүүлэн олгож байгаа.

Энэ салбарт сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлүүд нэлээдгүй хэмжээгээр хамрагдан ажиллаж байна.

Хүнсний боловсруулах үйлдвэрийн эргэлтийн хөрөнгийг дэмжих зээл байгаа. 2 жилийн хугацаатай, 18 хүүтэй хувийн хүүтэй бизнесийн зээлийг 5 хувь болгон олгож байна.

Энд 368 аж ахуйн нэгж 360.2 тэрбум төгрөгийн хүсэлт илгээсэн. Үүнээс 214 аж ахуйн нэгжид нь зээлийг олгосон байгаа.

Сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуй байгуулах чиглэлийн зээлд 34 тэрбум төгрөгийг төсөвлөсөн. 5 жилийн хугацаатай, 6 хувийн хүүтэй зээлийг 89 иргэн, аж ахуйн нэгж 20.2 тэрбум төгрөгийн хүсэлт гаргасан. Ингээд 50 иргэн, аж ахуйн нэгж 6.6 тэрбум төгрөг батлагдсан. Үүнээс 49 иргэн, аж ахуйн

нэгжид 5.6 тэрбум төгрөгийг олгоод байна.

Хүүхдийн сүү, сүүн тэжээл боловсруулах үйлдвэр байгуулах чиглэлээр нийтдээ 8 аж ахуйн нэгжид 18.8 тэрбум төгрөгийг олгоод байна.

Хоногт 20 мянган литр шингэн сүү боловсруулах, хуурай сүү үйлдвэрлэх үйлдвэр байгуулах энэ төслийн хүрээнд 35.2 тэрбум төгрөгийг төсөвлөсөн. Ингээд 2 аж ахуйн нэгж 17.5 тэрбум төгрөг олгохоор ажиллаж байна.

Нийт зөвхөн сүү, сүүн бүтээгдэхүүн биш нийт хүнсний үйлдвэрлэлийн чиглэлийг дэмжих 1800 гаруй аж ахуйн нэгж 982 тэрбум төгрөгийн зээл олгохоор төсөвлөсөн байсан. Өмнөх 2023 оны 12 сарын эцсийн байдлаар 85 орчим хувьтайгаар үндсэндээ олгогдсон байгаа.

Тэгэхээр дараагийн жилүүдэд үлдсэн хувиуд дээрээ зээлүүдийг олгоод явна гэдгийг хэлэх байна.

Хөрөнгө оруулалтын хувьд хувийн хэвшлүүдийг дэмжих чиглэлээр ажиллаж байгаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бяслагийн үйлдвэр байгуулах төслүүд Хөвсгөл аймгийн 18 суманд хэрэгжээд явж байна. 2 үйлдвэр нь бүрэн ашиглалтад орсон байна.

Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих бяслагийн төсөл, цөцгийн тосны үйлдвэрлэлийн төсөл, Орхон цагаан идээ боловсруулах үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн төсөл, орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих бяслаг төсөл гээд тухайн орон нутгийн иргэдийн өөрсдийнх нь санаачилгаар уламжилсны дагуу зураг төсөв, тодорхой төслийн

шаардлага хангасных нь дагуу эдгээр төслүүдийг 2023 он, 2024 онуудад тусгаад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар иргэд, аж ахуйн нэгжүүдийг дэмжээд ажиллаж байгаа гэсэн мэдээлэл энэ дээр харагдаж байна.

Цаашид ямар арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх вэ. Энэ салбар дээр гол хийгдэх ажлууд дээр махны техникийн зохицуулалт мөрдөгдөж эхэлсэн байгаа.

2025 оны 01 сарын 01-нээс бүх нийтээр мөрдөж эхлэхээр байгаа.

2023 оны 01 сарын 01-нээс бид бүхэн цэцэрлэг, сургууль, эмнэлгийн хэрэгцээгээр хангаж байгаа. Өмнө нь дурдсан арьс, ширний салбар дээр ч гэсэн маш чухал асуудал байгаа.

Сая бид бүхэн махны үйлдвэрлэлийн 180 гаруй компаниуддаа бүгдийг нь төхөөрөх болон боловсруулах аж ахуйн нэгжүүд дээр бүрэн аттестатчиллын шалгалтыг зохион байгуулаад 01 сард дуусаж байна.

Бага эрсдэлтэй гарсан бүх аж ахуйн нэгжүүдээ бид экспортын хүсэлт мэдээллүүдийг нь олон улсын түвшинд нь баталгаажуулаад олгоод цогц арга хэмжээ аваад хэрэгжүүлж байгаа.

Одоо дараагийн түвшиндээ энэ сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн худалдаанд мөрдөгдөх техникийн зохицуулалтыг 2024 ондоо гаргая. Ингэснээрээ эрүүл, аюулгүй үйлдвэрлэлийг явуулах, цаашлаад энэ салбарын яг технологи энэ зүйлүүдийг бас.../минут дуусав/

Г.Ганболд: 3 номерын микрофоныг өгье.

М.Ганхүлэг: Хүнсний аюулгүй байдал талаасаа асуудлууд шийдэгдэх боломжууд нь бүрдэнэ.

Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн зохистой дадалыг хялбаршуулан нэвтрүүлэх чиглэлээр эрүүл Эрүүл мэндийн яамтай бид бүхэн хамтран ажиллаж байгаа.

Тэгэхээр үүнтэй холбогдолтой саналыг Эрүүл мэндийн яамтай хамтран гаргаж гаргаж байна.

Мөн 2024-2026 онд Засгийн газрын тодорхой зорилтын хүрээнд **“Хүүхэд бүрт нэг аяга сүү”** хөтөлбөрийг зохион байгуулахаар ажиллаж байна.

2024 онд шинээр боловсруулсан стандарт ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн ундны сүүний стандарт, хөргөлтийн агуулахын стандартуудыг батлах зайлшгүй шаардлагатай.

Энэ төрлийн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

2024 онд шинэчлэн боловсруулах дараагийн 11 нэр төрлийн хүнсний стандартууд байгаа. Тэгээд эдгээр стандартуудыг боловсруулах ажлууд хийгдээд явж байна.

Танилцуулга дууслаа.

Г.Ганболд: Танилцуулгатай холбогдуулж асуулт асуух гишүүд нэрсээ өгье.

Ц.Туваан, Ц.Анандбазар гишүүнээр тасалъя. Ж.Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Тэгэхээр энэ тогтоолын хэрэгжилтийг хангах талаар

нэлээн ажлууд зохион байгуулсан юм билээ. Би тэр тайлан юмнуудыг нь бүгдийг нь үзсэн.

Тэгэхээр одоо бид энэ сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх хүрээнд анхаарах ёстой хоёр, гурван асуудал байгаад байгаа юм уу гэж ойлгоод байгаа.

Нэгдүгээрт, сүү төдийлөн ашиглаж чадахгүй байгаа бүс нутгууддаа сүү боловсруулах нөөцдөө тохирсон жижиг цех, үйлдвэрүүдийг байгуулах асуудал бидний гол асуудал байгаад байх шиг байгаа юм.

Наад сүү, сүүн бүтээгдэхүүний чинь нэр төрөл ер нь эрс нэмэгдчихсэн. Түүнийгээ дагаад сүүн бүтээгдэхүүний импорт их өндөр гарч ирээд байгаа шүү дээ.

Тэгэхээр зэрэг мэдээж алслагдсан бүс нутгаас бид сүү шингэн хэлбэрээр нь авчрах боломж байхгүй.

Тэгэхээр тэрийг ямарваа нэгэн байдлаар боловсруулж хэрэглэх тухай л асуудал байгаад байгаа юм.

Өмнөх нийгмийн үед ер нь бүх суманд сүү, цөцгийн тосны завод гэж байгуулаад, тэр хэмжээгээрээ бид масло гэдэг юм уу, ээдэмцэр гэдэг юм уу, эднийгээ хийгээд болж байсан.

Тэгвэл одоо наад бяслаг гэдэг юм уу, энэ чиглэлээрээ аль бүс нутагтаа ямар төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх юм гэдэг талаар бодож чиглүүлж байгаа бодлого юу байна аа? Нэг ийм зүйл.

Хоёр дахь зүйл. Угаасаа үндэсний үйлдвэрүүдийн шингэн сүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэхийн тулд газар тариалангийн бүс нутагтаа бид

эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх, сүү цуглуулах тухай л асуудал байгаа л даа гол нь.

Тийм учраас энэ өндөр ашиг шимтэй малын хөгжүүлэлтийн тухай асуудал байгаад байгаа. Олон жил ярьж байгаа. Гаднаас сайжруулагч үржлийн мал оруулж ирье гэдэг юм яригдаад төдийлөн урагшаа ахиж чадахгүй яваад байгаа.

Тэгэхээр энэ талаар ойрын хугацаанд яг хийгдчих гээд байгаа юм нь юу байна аа? Тодорхой хэмжээний нөөц бүрдүүлээд, түүндээ тулгуурлаж дотоодын арай өртөг хямдтай, өндөр ашиг шимтэй мал үржлийн ажлыг бид хийх зайлшгүй шаардлага байгаад байгаа. Энэ бол бэлэн суурь нь бидэнд байгаа юм.

Энэ газар тариалангийн төвийн бүс нутагтаа угаасаа үүнийгээ түшиглэсэн сүүний чиглэлийн, махны чиглэлийн өндөр ашиг шимтэй мал аж ахуй хөгжүүлэлтийг бид хийсэн.

Яг энэ бүс нутгаа түшиглэж үүнийгээ өргөн хүрээтэй хийх ёстой юм. Энэ тал дээр та хэдийн өнөө гаднаас оруулж ирэх гээд байгаа үржлийн малын чинь асуудал юу байна вэ гэдэг асуудал.

Дараагийн нэг зүйл. Тэр хуурай сүүний үйлдвэрлэл дээр 2 аж ахуйн нэгж тодорхой хөрөнгийн судалгаа юмнууд хийгдээд дэмжигдчихсэн тухай ярилаа.

Энэ байршил нь хаа байгаад байна? Бид яах аргагүй импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн асуудлыг онцгойлон дэмжих ёстой. Бид гаднаас хэдий хэмжээний хуурай сүү оруулж ирээд байгаа билээ. Үүнийгээ нөхөж чаддаг үйлдвэрийг бий болгох ёстой л доо.

Тэгэхээр энэ хаана байгаад байна? Одоо ямархуу үе шатдаа явж байгаа юм? Энэ асуудлыг ер нь нэлээн хурдавчлах тухай асуудал байгаад байна гэж.

Гуравдугаарт, үнэхээрийн ашиг шимийг нэмэгдүүлье гэж үнэхээр ярьж байгаа бол тэжээлийнх нь орчныг бид бүрдүүлэх ёстой.

Тийм учраас сүүний чиглэлийн, махны чиглэлийн аж ахуйнуудаа түшиглэсэн ашиг шимд чиглэсэн найрлагатай тэжээл үйлдвэрлэлийн асуудлаа бид дэмжих ёстой.

Хэд хэдэн төсөл яригдаад бас гурав, дөрвөн жил болчихлоо.

Тэжээл үйлдвэрлэлийн томоохон төслүүдийн саналууд оччихсон. Тэгээд санхүүжилт.../минут дуусав/

Г.Ганболд: 3 номер. Ажлын хэсгийн 3 номерыг өгье.

М.Ганхүлэг: Ж.Батжаргал гишүүний асуултад хариулья.

Жижиг кластер жишиг хуурай сүүний болон бяслаг, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлүүдийг хэрхэн дэмжиж байгаа тухай асуулт асуулаа.

Өмнө дурдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэд хэдэн аймгууд дээр жишиг үйлдвэрүүдийг барих ажлууд зохион байгуулаад явж байна.

Мөн дээрээс нь хувийн хэвшлийнхний үйл ажиллагаан дээр тодорхой төслүүд хэрэгжээд явж байна.

Сүүний кластер ферм байгуулах чиглэлээр 10 өрх, 200 үнээтэй төсөл Төв аймаг дээр хийгдэж байна.

Цогцолбор фермийн аж ахуй бас хийгдэх чиглэлээр 200 үнээтэй 6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл Төв аймаг дээр.

Хөргөлтийн төв 4 сум, 5 өргөлтийн төв нийтдээ 13 тонны өргөлтийн төв байгуулах ажил Төв аймаг дээр.

Хорголжин тэжээл боловсруулах үйлдвэрийг байгуулах 10 га газрын хүчин чадалтай. Нийтдээ хүчин чадал нь цагт 4 тонны хүчин чадалтай төсөл Орхон аймаг дээр.

Малын тэжээлийн үйлдвэр 2 га газрын хүсэлтүүд Төв аймаг дээр гээд.

Ингээд эдгээр газрууд дээр мэргэжлийн туслалцаа, мэдээллүүд өгөөд бүх шатын газрын болон бусад чиглэлийн зөвшөөрөл олгох чиглэлүүд дээр нь туслалцаа үзүүлээд ажиллаж байгаа туршлагауд байна.

Дээр дурдсан тодорхой орон нутгуудад хэрэгжиж байгаа төслүүдийг цаашид орон нутгийн түвшинд үргэлжлүүлээд аваад явах боломжтой.

Түрүүчийн дурдаж байгаа 36 дугаар тогтоолоор энэ хүнсний хангамжийн гол нэр төрлийн бүтээгдэхүүнүүд дээр сүү, сүүн бүтээгдэхүүний нэр төрлүүд орж байгаа учраас аль ч аж ахуйн нэгжүүд өөрсдөө хоршоо, тодорхой зохион байгуулалтад ороод энэ 5 жилийн хугацаатай 5-аас 6 хувийн хүүтэй зээл, эргэлтийн хөрөнгө болон хөрөнгө оруулалтын зээлүүдийг аваад ажиллах бүрэн боломж нь байгаа.

Тэгэхээр бид бүхэн одоо яг Хүнс, хөдөө аж ахуйн яамны зүгээс өөрсдийн бие даасан үйлдвэр, аж ахуйн нэгжүүд

хийх гэхээсээ илүүтэй аж ахуйн нэгжүүдийг тодорхой зээлээр дэмжих энэ бодлогоо л цаашдаа уялдуулж дэмжиж ажиллах нь зөв гэсэн байр суурьтай байгаа.

Урамшуулал олгох километрийн радиус дээр 300 километр болгож өөрчилж энэ бүс нутгийн хөгжлийг илүү нэмэгдүүлэх чиглэлийн ажлууд хийгдээд явж байгаа гэдгийг нэмж хэлье.

Сайн чанарын үйлдвэр, гарцыг сайжруулах чиглэлээр бид бүхэн Франц болон Орос, Беларус гэсэн гурван улстай хэлэлцээрийн түвшинд ажиллаж байгаа.

Жишээ нь, Беларусаас 9 мянган толгой үхэр оруулж ирэх чиглэлийн ажлууд хийгдээд явж байгаа.

Г.Ганболд: Ж.Батжаргал гишүүн тодруулъя.

Ж.Батжаргал: Тийм. Явж байгаа үйл явцуудаа мэдээд байгаа. Хэрэгжиж өгөхгүй удчихаад байгаа юм.

Тийм учраас би тодруулаад байгаа юм. Наад үржлийн үхэр оруулж ирэх, махны, сүүний чиглэлийн үхэр оруулж ирэх асуудал чинь нэлээдгүй хугацаанд яригдаад одоо хэр нь олигтой шийдэлд хүрэхгүй байгаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр одоо яг хэд хаанаас орж ирэх гээд байгаа юм бэ гэдэг асуудал.

Энэ дээрээ тов тодорхой хариу өгчихмөөр байна гэж. Нэг.

Мэдээж би төрийн байгууллагуудыг гэдэг юм уу, төрийг өөрөө хөрөнгөө гаргаад үйлдвэр байгуулчих гэж хэлээгүй.

Тэгэхээр аль болохоор бид энэ сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэгцээгээ дотоодоосоо хангах ийм л бодлого байгаад байгаа.

Тэгэхээр эрчимжсэн аж ахуйн бүс нутагтаа бид шингэн сүүний үйлдвэрлэлийнхээ чиглэлийн юмыг давуу бариад, байнгын ашиглаж чадахгүй байгаа бүс нутгууд дээрээ тэр сүүн бүтээгдэхүүний жижиг үйлдвэрүүдийг дэмжих хэлбэрээр дотоодынхоо хэрэгцээг хангах бодлого бидэнд хэрэгтэй байгаа байхгүй юу. Наад бяслаг.../минут дуусав/

Г.Ганболд: 3 номер.

М.Ганхүлэг: Тодорхой геополитикийн асуудлаас үүдсэн бас ийм асуудлууд байгаа юм.

Тэгээд хэлэлцээрүүд хийгдээд явж байна. Манай Мал эмнэлгийн ерөнхий газар болон сайдын түвшинд тодорхой уулзалтууд зохион байгуулаад явж байгаа.

2 сард бас нэг томоохон уулзалт товлосон байгаа. Иэр уулзалтаар нэлээн асуудлууд яригдана.

01 сарын 17-ноос 22-ны хооронд бүх сайд нарын түвшний уулзалт Германд зохион байгуулагдана.

Энэ дээр тодорхой санамж бичгүүдийг байгуулах. Байгуулсан хэлэлцээрүүдээ үргэлжлүүлэх чиглэлээр ажлууд хийгдэхээр байгаа.

Хуурай сүү боловсруулахтай холбогдолтой “Сүү” хувьцаат компани, ТЭСО хувьцаат компани гэсэн 2 үйлдвэр дээр нийтдээ 5 мянган тонны хүчин чадалтай хуурай сүүний үйлдвэрийн зээлүүдийг аваад өргөтгөл юмнуудаа хийхээр ажиллаад явж байна.

Г.Ганболд: Ж.Батжаргал гишүүн тодруулъя.

Ж.Батжаргал: Тийм ээ.

Тэгээд би юу гэж хэлээд байна гэхээр энэ сүүнийхээ нийлүүлэлтийг, үйлдвэрлэлийг нэмэгдүүлье л гэж ойлгож байгаа бол хэдүүлээ тодорхой сайжруулагч үржлийн малыг гаднаас оруулж ирээд, түүн дээрээ үржлийн ажлаа явуулаад, дотоодын хямд өртөгтэй, өндөр ашиг шимтэй малын хөгжүүлэлтийг л хийх ёстой юм билээ.

Тэгэхгүйгээр одоо шууд Францаас **“Монбельярд”** /MONTBELIARDE/ оруулж ирээд тэрний анхны өртөг гэдэг юм уу, үйл ажиллагаанд шаардлагатай байгаа зардлаа нөхөөд ашигтай ажиллахад нэлээн тийм төвөгтэй тооцоо гараад байгаа шүү, наадах чинь.

Тэгээд энэ талаа бид бодож энэ асуудлаа хиймээр байгаа юм.

Хоёр дахь зүйл. Энэ тэжээл үйлдвэрлэлийнхээ юмыг жоохон явуулахгүй бол болохгүй болчхоод байна.

Дэлхийн банк 4 газар тэжээл үйлдвэрлэлийг дэмжье гээд ярьчихсан. Төсөл, бүх юмыг нь аваад 3 жил гаран болж байна. Анхны санхүүжилт ч хийгдээгүй.

Тэгэхээр чинь бид байгуулсан аж ахуйг.../минут дуусав/

Г.Ганболд: Ц.Туваан гишүүн.

Ц.Туваан: Манай Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дотор хоёр дэд хороо байдаг.

Тэгээд түүний Хөнгөн үйлдвэрийн хөгжлийн дэд хороо гээд одоо хэн ахалж байна. Ц.Анандбазар гишүүн хэвээрээ байгаа юу? Тийм.

Энэ дэд хорооноос ингээд нэг ажлын хэсэг гараад ажилласан юм. Тийм. Энэ ажлын хэсгийг нь би бас ахлаад ажилласан.

Тэгээд эндээс нэг Байнгын хорооны тогтоол болгож гараад, тэгээд Засгийн газар луу явуулсан.

Тогтоол нь бид нарт байна л даа. Энэ тогтоол үндсэндээ 07 тоот тогтоол. 6 зүйл, заалттай. Бараг 7 ч шахуу зүйл, заалттай ийм тогтоол гараад явсан.

Тэгээд энэ дээр хэрэгжилтийн тайлангаа өнөөдөр хэлэлцэж байна. Энэ блд бас манай Байнгын хороо маш тийм шуурхай асуудлуудыг авч хэлэлцэж байгаад баярлаж байгаа.

Гүйцэтгэл бол би 60 орчим хувьтай юм уу. Тайлангаас харахад. Яах вэ мэдээж ор хийгдээгүй, асуудал яриагүй хоёр зүйл, заалт байна.

Тэгэхээр энэ дээр 60 орчим хувийн тайлан ирүүлсэн байна. Бас ч гэж ажлыг манай салбарын яам хийсэн байна.

Тэгээд энэ дээр сүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, ард иргэдийг шингэн сүүгээр хангах л асуудал л даа.

Тэгээд энэ дээр өмнө нь. Би бас өмнө нь энэ салбарт Хөдөө аж ахуйн дэд сайдаар ажиллаж байсан. Тэгээд тэр үед Хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулаад яг үйлдвэр, цехэд тушаасан сүүнд урамшуулал олгож болно гэдэг заалтыг Хүнсний тухай хуульд оруулаад. Тэгээд түүнээс хойш 6 жил орчим гацаж

байгаад дахиад 2020 оноос энэ хэрэгжсэн. Маш үр дүнтэй хэрэгжиж байгаа ажлуудын нэг.

Энэ тайлан дотор байна л даа. Анх Улаанбаатар, Төв, Сэлэнгэ, Дархан-Уул гээд энэ 4 аймгийн хэмжээнд л 13 сумын хүмүүс ашиглаж хэрэгжиж байсан бол одоо 10 аймаг болоод өргөжчихсөн байгаа. 10 аймгийн 24 үйлдвэр, цех гээд.

Тэгэхээр энэ бодлого маш зөв явж байгааг харуулж байгаа.

Тэгэхдээ Монгол Улс хөдөө аж ахуйн орон. Тэгээд малын дэлэнд байгаа сүү ярих юм бол бусад улсуудаас ичмээр. Тийм ээ. Тэрийгээ ашиглаж байгаа байдал.

Сүүний чиглэлийн эрчимжсэн фермерийн аж ахуйнуудыг цаашид төр бодлогоор маш сайн дэмжиж өгч байж энэ хэрэгцээгээ хангах гэсэн ийм л асуудлуудыг бид энэ тогтоол дотроо оруулж өгсөн байгаа юм.

Тэгээд тодорхой хэмжээний үр дүн гарсан.

Тэгээд энэ дотроос маш чухал заалт нь 1 дүгээр заалт дотроо байгаа юм. 1.1 дотроо.

Одоо энэ сэрүүний улирлын сүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор **“хугацааг сунгах, хамрах хүрээг өргөжүүлэх”** гээд.

Бид хугацаа сунгах дээр алхам хийгээгүй байна. Дотроо.

Энэ дээр ерөөсөө фермерүүдийн ярьж байгаа нэг асуудал бол ерөөсөө энэ сэрүүний гэж байгаа юм бол яг энэ сэрүүний улирлынхаа хугацаагаа 06 сарын 01, ядахдаа 05 сарын 15 хүртэл,

ногоо цухуйтал үүнийгээ унгачхаач ээ гэдэг асуудал ярьсан. Энэ дээр алхам хийгээгүй байна.

Ингэхээр бид дутуу л ажиллаж байгаа.

Харин урамшууллын хэмжээг нэг дахин нэмэгдүүлсэн. Энэ бол яалт ч үгүй Засгийн газрын хийсэн, Байнгын хорооны өгсөн чиглэлийн дагуу хийсэн сайн ажлуудын нэг гэдгийг хэлэхээс өөр арга байхгүй.

Дараагийн нэг асуудал нь сүүний холбоон дээрээс. Дарга 1 минутаа авчихъя. Нэгмөсөн асуучхаад.

Г.Ганболд: Ц.Туваан гишүүнд 1 минут өгье.

Ц.Туваан: Сүүний холбоо яг одоо өнөөдрийн байдлаар сүүний үнэ хэдтэй байна аа? Яг үйлдвэрүүд хэдээр авч байна?

Тэгээд Та бүхэн энэ тулгамдаж байгаа асуудлаа товчхон нэг минутад багтаагаад бид нарт хэлээдхээч. Нэгэнт холбоо энд оролцож байгаа учраас.

Хоёрдугаарт, Мал эмнэлгийн ерөнхий газраас яг энэ мал эмнэлгийн нэгдсэн системийг авторууд нь, энэ хариуцсан газрын дарга нар нь байна.

Та бүхэн энэ сүүний гарал үүсэл тал дээр нэг асуудлууд гараад байдаг шүү дээ. Одоо нөгөө гарал үүслийг нь тогтоож албажуулах энэ тэр гээд. Энэ асуудал дээрээ та хэд ер нь ямар ахиц гаргаж байгаа юм бэ?

Гурав дахь асуудал нь, Хөдөө аж ахуйн яаман дээр манай Батсүмбэр суманд гэхэд солонгын долоон өнгө шиг 7 үүлдрийн өнгийн үхэр яваад байна.

Тэгэхээр үнээний үүлдэр гэдгийг ер нь цэгцлэх тал дээр та хэд маань яг энэ салбарын бодлого барьж байгаа хүмүүсийн хувьд.../минут дуусав/

Г.Ганболд: Ажлын хэсгийн 3 номер.

М.Ганхүлэг: Ц.Туваан гишүүний асуултад хариулъя.

Тогтоолын дагуу танилцуулга дээр ороогүй асуудлын нэг нь сүүний урамшуулыг олгохдоо цахимаар олгож байгаа гэдгийг би нэмээд танилцуулах нь зөв байх.

“Нүүдэлчин” гээд малчдад зориулсан **аппликэйшн** байгаа.

Тэрхүү тэрхүү аппликэйшнээр дамжуулаад өөрийнхөө сүүний үйлдвэрүүдэд тушаасан сүүгээ бүртгүүлээд, тэр мэдээллийнх нь дагуу урамшууллийг олгоод явдаг ийм цахим системийг бий болгоод хэрэгжүүлээд ажиллаж байгаа.

Тогтоолын 6 дахь заалт байгаа.

1 дэх заалт дээр хугацаатай холбогдолтой санал хэлж байна. Хугацааны хувьд дахиад өөр нэг агуулга байгаа юм. Энэ бол одоо хэрэгжих хугацаа нь 2025 оны 06 сарын 01 байсныг 2026 оны 12 сарын 31 болгож сунгасан.

Тэгэхээр 2026 оны 12 сарын 31-ийг хүртэлх хугацаанд литр тутамд 500 төгрөг байсныг 1000 төгрөг болгож нэмэгдүүлсэн энэ байдлаараа цаашдаа олгоод явъя гэдэг чиглэлийг энэ дээр нэмэгдүүлж оруулсан байгаа.

Дээрээс нь зөвхөн ундны сүү үйлдвэрлэх цехэд тушаасан сүүнд

урамшуулал орохоо олгохоор заасныг сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд тушаасан болгож өөрчилсөн.

Нэр төрлийг нь олон болгосон. Ямаа болон бусад нэр төрлүүдийг гээд.

Тэгэхээр тогтоол дээр зөвхөн 500-г 1000 болгохоос гадна ийм нэмэлтүүдийг бас хийсэн байгаа гэдгийг нэмж хэлье.

Мал эмнэлгээс нэмэлт хариулт өгье.

Г.Ганболд: 2 номер.

Д.Довчинсүрэн: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

Мал эмнэлгийн нэгдсэн системээр дамжуулаад хүнсний аюулгүй байдал, мал эмнэлэг, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага нийцэж байгааг тухайн орон нутгийн малын эмч нар маань баталгаажуулаад тухайн сумд ажиллаж байгаа байцаагч нар давхар баталгаажуулалт хийгдээд явж байгаа.

Тэгээд энэ сүүний урамшуулал авах бас нэг гол журамдаа заасан юм нь болохоор энэ мал эмнэлгийн нэгдсэн системээрээ дамжуулаад явж байгаа.

Эхлээд хүмүүс ойлгохгүй жаахан асуудал гарч байсан. Одоо харьцангуй асуудал гарахаа больсон. 3 жил хэрэгжсэний бас нэг үр дүн нь энд явж байгаа.

Ер нь сүү нийлүүлэлт маань геометрийн прогрессоор дээшээ ер нь нэлээн их өсөлттэй байгаа. Жилд 25-аас 30 орчим хувийн өсөлттэй байгаа.

Тэгээд энэ болгон дээр мал эмнэлгийн байгууллагын

баталгаажуулалт давхар явж байгаа гэдгийг Та бүхэнд хэлье.

Г.Ганболд: 1 номер. Холбооныхон 1 номер уу? 1 номерын микрофоныг өгье.

Г.Ганхуяг: Сайн байцгаана уу? Монголын сүүний нэгдсэн холбоо Г.Ганхуяг.

Сүүний үйлдвэрүүд маань 1500-аас 2100-гийн хооронд сүүгээ хүлээж авч байгаа. Бүс нутгийнхаа байдлаас болоод. Энэ дээр ложистикийн хол ойр гэдгээсээ шалтгаалж байгаа.

2100 дээр нэмэх нь 1000 төгрөг гээд 3100 хамгийн үнэтэй нь авч байна. Хамгийн хямдхан нь 1500 дээр нэмэх нь 1000 төгрөг гээд 2500-гаар сүүгээ авч байгаа.

Манай яамны тайлангаас харахад анх эхлэхдээ 8 сүүний үйлдвэр сүү худалдаж авч байсан бол одоо 24 үйлдвэр сүү худалдаж аваад явж байгаа юм байна.

Манай сүүний урамшуулал бусад урамшууллын системийг бодвол маш шударга, зөв болж чадсан. Энэ дээр манай холбоо болон манай фермерүүд маш баяртай байдаг.

Яагаад гэвэл яг үнээ сааж байгаа, дэл доор сууж байгаа “А” данстай хүнийхээ данс руу шууд урамшууллын мөнгө нь ордог. Ямар нэгэн ченжээс падаан авна ч гэдэг юм уу, бусад урамшуулал шиг дамжлага байхгүй шууд явдгаараа маш үр өгөөжтэй, өргөн түмнийг хамарсан шударга систем болсон.

Яамныхан хөнгөлөлттэй зээл бид нарт олгохоор шийдээд явж байгаа.

Тэгэхдээ энэ хөнгөлөлттэй зээл яг манай эрчимжсэн аж ахуй дээр байгаа онохгүй байгаа нь саяын тайлангаас харагдаж байна л даа.

87 иргэн 67 тэрбум төгрөгийн зээл хүсээд 49 иргэн 5.2 тэрбум төгрөгийн зээл авсан гэхээр нийт хүсэж байгаа 67 тэрбумаасаа зөвхөн 5 тэрбумыг нь авч чадаж байна гэхээр энэ бодлого маань байгаа онохгүй байгаа юм уу, эсвэл өнөөдрийн манай фермерүүдийн бодит нөхцөл байдлаас энэ арилжааны банкнуудын тавьж байгаа босго өндөр байна гэдэг нь харагдаад байгаа.

Тэгээд энэ дээр яам маань анхаараад цаашдаа явна биз.

Нөгөөтээгүүр 5 жилийн хугацаа гэдэг нь яг ферм байгуулсан хүмүүсийн хувьд эргэн төлөлтөө хийх боломжит хугацаа бас биш.

Яг энэ фермийн аж ахуй эрхэлж байгаа хүмүүс, манай холбооноос тодорхой эдийн засагч нарын тооцоолсноор 8 жилд эргэж төлөгдөхөөр байгаа.

Тэгэхээр энэ 5 жил гэдэг тоо маань өөрөө богинодоод байгаа байх.

Дараа нь, ер нь Монгол орон даяар энэ жил маш хүйтэн өвөл болж байна. Тэжээлийн асуудлууд маш хурцаар тавигдаж байна. Тэжээл маш үнэтэй боллоо. Тэжээлтэй холбоотойгоор нөгөө урамшуулал маань 1000 мянган төгрөг болж байгаа хэдий ч нөгөө талдаа сүүний өртөг маань өсөөд байна.

Тэгэхээр яам болон манай Байнгын хороо маань тэжээл дээр онцгой анхаарч бидэнд дэмжлэг үзүүлээч ээ.

Монгол Улс онцгой байдлын үед ашигладаг тэжээлийн фондтой улс. Тэгвэл түүн дээрээ нэмээд улирлын хамаарлаас гарах тэжээлийн фондтой болох шаардлага үүсээд байна. Энэ нь зөвхөн эрчимжсэн аж ахуй биш бэлчээрийн аж ахуйд ч гэсэн хэрэгтэй байгаа.

Ер нь жил болгон улам хүнд болох нь тодорхой байна. Зун болгон ган болох нь тодорхой болоод байгаа учраас тэжээл дээрээ онцгой анхаарч өгөөч ээ.

Энэ фондыг тухайн орон нутаг болон аж ахуйнууд нь хамтраад хийх боломжтой.

Тэгээд энэ дээр гарах зээлийг хөнгөлөлттэйгөөр урт хугацаатай явуулж өгөөч ээ.

Нөгөөтээгүүр ногоон тэжээл, дарш тариалж байгаа, олон наст тэжээлийн ургамал тарьж байгаа компаниудад тулгамдаад байгаа асуудал үрийн асуудал байгаа.

Яг найдвартай чанартай үр тогтмол нийлүүлэгдэхгүй байгаа.

Хувь хүн болон ченжүүдийн гараар дамжиж орж ирсэн үрүүд нь чанарын шаардлага хангахгүй, маш их асуудалтай байгаа. Тэгээд энэ асуудалтай үрийг тарьсан улсууд маш их зардал чирэгдлээрээ намар нь хохироод байх жишээтэй асуудлууд байна.

Урамшууллын хувьд манай фермерүүд хугацаагаа 06 сарын 01 болтол сунгавал маш.../минут дуусав/

Г.Ганболд: Ц.Туваан гишүүн тодруулъя.

Ц.Туваан: Тийм. Энэ манай Байнгын хорооны тогтоол урамшуулал олгох хугацааг сунгах гэдэг нь. Тийм.

Ер нь саяын холбооны хэлж байгаа хугацаа шүү. Тэр дээрээ бодоод Та бүхэн ажиллаад болж өгвөл одоо 04 сарын 01 байгааг 05 сарын 15 ч юм уу. Тийм ээ. Ийм байдлаар судалгаагаа хийж үзээрэй. Салбарын яам учраас.

Хоёрдугаар асуудал нь, түрүүн миний асуултад хариулт авчихъя.

Энэ үүлдэр, угсаа. Тийм ээ. Цэвэр үүлдрийн үхэр дээрээ одоо яг Монгол орны нөхцөлд тохирсон ямар үүлдэр байгаа юм бэ? Яг энэ дээрээ нэг бодлого болгоод цэгцлэхгүй бол энэ дээр тэр олон үүлдэр байна. Хоорондоо ямар нэгэн байдлаар дур зоргоороо эвцэлдүүлэг хийснээс болоод ашиг шим нь буурах асуудал яваад байна.

Тэгэхээр **“Холштайн”** /Holstein_[Holland]/ юм уу, **“Монбельярд”** /MONTBELIARD/ дээр юм уу, **“Свицийн бор”** /Brown Swiss/ дээр юм уу, **“Алатау”** /Ala Tau/ дээр юм уу. Энэ дээрээ барьж байгаа бодлого.../минут дуусав/

Г.Ганболд: 4 номерын микрофон өгье.

Р.Цогтбуян: Та бүгдэд энэ өдрийн мэнд хүргэе.

Ж.Батжаргал гишүүний асуултад түрүүн давхар Ц.Туваан гишүүн хоёр хоёулаа зэрэг асууж байна.

Тэгээд ер нь Монгол оронд бэлчээрийн мал аж ахуй, эрчимжсэн мал аж ахуй гэж хоёр тусад нь салгаж байгаа.

Нэгдүгээрт нь, 56 үүлдэр, омгийн мал манай бэлчээрийн мал аж ахуйд батлагдсан үүлдэр омгийн таван хошуу мал дээр явж байна.

Газар тариалан, мал аж ахуй хөгжсөн бүс нутагт, ялангуяа Төв аймаг, Сэлэнгэ, Дархан, Орхон гэсэн аймгууд дээр, Хэнтий гэсэн аймгууд дээр мах, сүүний хосолмол ашиг шимтэй. Саяын нэрлэгдээд байгаа **“Хар тарлан”**, **“Алатау”**, **“Симменталь”**, дээр нь Францаас орж ирж байгаа, Европын Холбооноос орж ирж байгаа үхрүүдийг үржүүлж байгаа. Хувийн хэвшлүүд нэлээн сайн үржүүлж байгаа.

Дээрээс нь үүнийг үүлдэр угсааг нь сайжруулахын тулд Монгол Улсын Малын удмын сангийн үндэсний төв гэж энэ генбанк байгаа. Энэ банк дээр энэ оруулж ирсэн үүлдэр угсаа сайжруулж байгаа үхэр, түүний цэвэр гүн үлдээсэн үрүүд хадгалагддаг.

Үүгээр манай техникчид маань зохиомол хээлтүүлгүүдийг бас давхар хийгээд явж байгаа.

Сайжруулагчаар ашиглаж байгаа энэ элит үхрүүдийг сая манай дэд сайд ярилаа.

2 сард орж ир орж ирэх хэлэлцээрүүдээ хийж байгаа. Орж ирэх юм бол мэдээж газар тариалангийн бүс нутаг, энэ газар тариалангаа түшсэн тэжээлийн бааз суурин дээрээ тулгуурласан бүс нутгуудаараа үржүүлж сүүний хангамжийг нэмэгдүүлэх, цаашлаад эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх бодлого ингэж явах байгаа юм.

Зүгээр сумдаар нэг бух тавьчхаад замбараагүй тугал гараад яваад байна гэдэг асуудал нэг талдаа шийдэгдчихсэн.

Энэ нь удмын сангийн систем дээр бүртгэлтэйгээр энэ асуудлууд шийдэгдээд, хэнийх ямар үнэтэй байна, байгалийн хээлтүүлэг болоод зохиомол хээлтүүлгээр хийж байна вэ гэдэг мэдээлэл судалгаанууд нь бас цахимаар гараад явж байгаа.

Тэр тэжээлийн үрийн асуудал дээр бас давхар, тэжээлийн нэг болон олон наст ургамлыг Монгол оронд тариалах, нутагшуулах ажлыг тодорхой хэмжээнд хийгээд явж байгаа.

Энэ сортын үрүүдээр бодлогын хүрээнд оруулж ирээд явж байгаа зүйлүүд байгаа.

Цаашлаад энэ дээр үр үржүүлэгчдийн холбоодууд, бусад холбоодуудтай хамтарч нутагшсан элит нэгдүгээр импортлогдсон үрүүдийг тарих бүс нутгийг тогтоож явж байгаа. Салбарын хүрээнд.

Г.Ганболд: Ц.Анандбазар гишүүн асуулт асууя.

Ц.Анандбазар: Өнөөдрийн ярьж байгаа ажил дээр яамыг нэг удаа магтахгүй үнэхээр болохгүй.

Монгол Улсын Их Хурал, яам хоёр хамтарч хэрэгжүүлсэн цөөхөн, энэ 4 жилийн хүрээнд амжилттай хэрэгжсэн нэг төсөл нь энэ сүүний урамшуулал байгаа юм.

2022 оны 04 сарын 06-нд манай хөнгөн үйлдвэрийн дэд хорооноос ажлын хэсэг гарсан.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваанаар ахлуулсан, Д.Өнөрболор, Сайнхүүгийн Ганбаатар гэсэн гишүүдтэй бид аймгуудаар явж яам, Тамгын газар,

үйлдвэрүүдтэй уулзаж сүүний урамшууллын 2022 онд эхэлж тавьсан.

Үүний дараа 2022 оны 06 сард Байнгын хорооны тогтоол гарч Засгийн газарт чиглэл өгсөн. Их Хурлын олон чиглэлийг мартдаг яамд байдаг юм билээ.

Харин энэ чиглэлийг ажил хэрэг болгож чадсан Хөдөө аж ахуйн яам Х.Болорчулуун сайд, дэд сайдад, танай хамт олонд Байнгын хорооны өмнөөс тусгайлан баяр хүргэе.

Яагаад гэхээр энэ “дэлэнт мал дээшээ” гэж малын сүүг эргэлтэд оруулах, үнэд оруулах асуудал Монгол Улсын төрийн бодлого байгаа юм.

Монгол 70 сая малтай. 70 сая малтай атлаа сүүний хэрэглээгээр дэлхийд сүүлээсээ 20-д ордог. Нэг номерт Америкийн Нэгдсэн Улс ордог.

Сүүгээ огт хэрэглэдэггүй. 70 сая малтай атлаа гадаадаас сүү импортлодог ийм улс дэлхийд байдаггүй. Энэ нь Монгол.

Хөгжлийн ийм доор түвшинд байгаагаа мэддэггүй байсан. Нэг ч гэсэн малын гаралтай түүхий эдийг үнэтэй болгосон. Сая манай сүү үйлдвэрлэгчдийн холбооныхон ярьж байна. Их зөв юм ярьж байна.

Ингээд нэг нэгээр нь явуулах юм бол энэ чинь малын гаралтай түүхий эд мянган юм байхгүй шүү дээ. Маш амархан шийдэж болох байгаа юм.

Тийм болохоор танай яамныханд тусгайлан баяр хүргэж байгаа юм.

Үүний хэрэгжүүлэлтийн цаашдын арга хэмжээг манай холбооныхон зөв ярьж байна.

Бэлчээрийн мал аж ахуйгаас сүүгээ авах нь сүүний үйлдвэрүүдийн амь байгаа юм.

Бэлчээрийн мал аж ахуйд сүүгээ өгөх гэхээр жилийн турш урамшуулал хэрэгтэй байгаа юм. Түрүүн 06 сарын 01 гээд их даруухан хэлчихлээ. Сүүний урамшуулалгүй улс дэлхийд байдаггүй юм. Энэ урамшуулыг жилийн турш өгөх хэрэгтэй. Мянган төгрөг ч эцсийн үнэ биш гэж би бодож байгаа.

Тэгэхээр цаашдаа бид сүүг дэмжиж, сүүний хэрэглээг сайжруулах юм бол үйлдвэр өөрөө эдийн засгийн хувьд ашигтай болох ёстой.

Одоо 6-хан үйлдвэр байснаа 20 үйлдвэр ажиллаж эхэлсэн гэж байна шүү дээ. Үүн шиг том тоо хаа байна.

Таны сая хэлсэн тоон дээр 2.4 сая литр сүү саалаа гэж байна. 2023 онд.

2.4 сая литр сүүг нэгж малд оногдуулах юм бол сард Монгол Улс маань 2 литр сүү саадаг улсад орж байгаа юм. 2-хон литр сүү.

Тэгээд энэ чинь хүүхдийн тоглоом шиг инээдэмтэй тоо байгаа биз дээ. Цаашдаа бид 20 сая, 200 сая гэдэг тоо руу хүрэх хэрэгтэй байгаа юм.

Үүний тулд яах вэ гэхээр энэ сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг бодлогын хэмжээгээр дэс дараатай хөгжүүлэх ёстой.

Энэ хүрээнд түрүүчийн санал тавьсан маш чухал асуудал байгаа. Үнээгээ жилийн турш саахад аманд нь хийдэг тэжээлийн асуудал Монгол Улс даяар маш хомсдолтой болж байна. Одоо үнээ тэжээдэг юмыг Дорнод,

Сүхбаатараас цагаан өвс авчирч тэжээх л юм ойлгож байна шүү дээ.

Гэтэл монголоор дүүрэн тэжээлийн аж ахуй байсан. Булганд Борбулан гэж Баяннуур сумд байсан тэжээлийн аж ахуй дампуурсан. Үүнийг сэргээж байгаа.

Энэ төсөл дээр ямар мөнгө төгрөг тавьж байна? Дэд сайдаас асуухыг хүсэж байна.

Тэшиг суманд Монголын анхны цөцгийн тосны үйлдвэр барьсан. 75 хувийн гүйцэтгэлтэй байгаа. Хөвсгөл, Булган, Эрдэнэт, Улаанбаатарын нийт хэрэглээний бараг 30 хувийг хангах хүчин чадалтай үйлдвэр болж байгаа.

Ганцхан сумд барьсан үйлдвэр л Улаанбаатар хотын 30 хувийг хангаж байна шүү дээ.

Тэгэхээр бидэнд санаачилга дутаж байгаа болохоос биш үйлдвэр барьж чадахгүй юм уу, эсвэл хийж болохгүй асуудал байхгүй байгаа. Гол нь манай малчид маань сүү, сүүн бүтээгдэхүүнээ үйлдвэрлээд зах зээлд хүргэж чадахгүй байгаа юм.

Сүүний үйлдвэр ч гэсэн их том хуучирсан технологитой байсан шүү дээ. /минут дуусав/

Г.Ганболд: Ц.Анандбазар гишүүний микрофоныг сунгая. 1 минут.

Ц.Анандбазар: 60 тонны машинаар бензинээ тээдэг. 4 тонны машинаар сүүгээ тээдгээс болж энэ үйлдвэрүүд явахгүй байгаа юм.

Логистикийн асуудлыг өөрчлөх хэрэгтэй.

Дээр нь та түрүүн ярьж байна. Сүүний гаралтай үнээ импортлох гэж байгаа гээд. Булган аймгийн Тэшиг сумын үйлдвэр байгуулагдаад эхэлсэн. Танай сайдад би 100 сүүний гаралтай үнээ өгөөрэй гэж хүсэлт тавьсан. Хэдийг өгөх гэж байна вэ? Та энэ Их Хурлын Байнгын хорооны хурал дээр хариуцлагатай мэдэгдэх хэрэгтэй байна.

Энэ цөцгийн тосны үйлдвэр Хөвсгөлийн 6 сум, манай Булганы 8 сум, Эрдэнэт хотыг тэгээд эргээд Улаанбаатар хотыг хангах чадалтай үйлдвэр болж байгаа.

Энэ сүүний үйлдвэрийг дагаад тахианы хоолны үйлдвэр орж байгаа. 100 мянган хүнтэй хотыг хангаж чадах тахиа гэжээх. Гахайны махны үйлдвэр орж байгаа. Нэг үйлдвэр чинь дагаад хоёр, гурван үйлдвэр ордог юм байна шүү дээ.

Тэгэхээр ганцхан ийм үйлдвэр хийхэд л нэг салбар сэргэж байгаа юм чинь цаашдаа манай Ж.Батжаргал гишүүний ярьсан бүсчилсэн.../минут дуусав/

Г.Ганболд: Хариулья. Хэн хариулах вэ? 3 номер.

М.Ганхүлэг: Ц.Анандбазар гишүүний асуултад хариулья.

Тогтоолтой холбогдолтой ажлууд дээр анхааран ажиллаж байгаа. Жилийн турш олгох тухай асуудал тавьж байна.

Засгийн газрын тогтоолоороо сэрүүний улиралд олгогдоно гэдэг байдлаар батлагдаад явж байгаа.

Сэрүүний улирал гэдгээ бид бүхэн 11 сараас эхлээд 4 сарыг хүртэлх хугацаанд олгоод явж байгаа.

Тухайлсан саяын зарчмын саналууд дээр бид бүхэн цаашдаа анхаарч ажиллая. Тэгээд нэмэгдүүлээд явах юу чиглэлээр анхаарч ажиллая гэж хэлэх байна.

Тэжээлийн асуудлын хувьд ер нь улс өөрөө сүүний үйлдвэр байгуулаад, тэжээлийн үйлдвэр байгуулаад, аж ахуйн нэгжүүдтэйгээ өрсөлдөөд ажиллах энэ байдлаасаа бүрэн татгалзаж байгаа.

Тодорхой хэмжээнд өөрсдөө эдийн засгийн тооцоолол юмнуудаа гаргаад хувийн хэвшлүүд маань ажиллаад явах энэ бололцоог нь л олгох чиглэлээрээ цаашдаа гол бодлогоо барья гэдэг энэ бодлого дээр байгаа.

Тэжээлийн үйлдвэрлэлийн чиглэлээр 36 дугаар тогтоолын хүрээнд арилжааны банкнуудтайгаа хамтраад ажиллах бүрэн боломжууд нь байгаа. Энэ чиглэлийн үйлдвэрүүд эхнээсээ санхүүжилтүүдээ аваад ажиллаж байгаа туршлагауд байна.

Тэгэхээр энэ чиглэлийн үйлдвэр үйл ажиллагаа явуулахад банкны шалгуур үзүүлэлтүүдээ хангаад өөрсдөө ажиллаад явах боломжууд байгаа.

Ирэх жил үргэлжлүүлээд энэ зээл олгогдоно. 5 жилийн хугацаанд бизнесийн зээл энгийн аж ахуйн нэгж авахад 18, 19 хувь хувьтай байхад энэ хүнсний хувьсгалын хүрээнд олгож байгаа энэ зээлүүд нь 5-аас 6 хувийн хүүтэй, 3-аас 5 жилийн хугацаатай гээд нэлээн уян хатан зээлүүд байгаа юм.

Тэгээд бид өөрөө өөрсдөө яг энэ дээр тодорхой зээлүүд олгоод эхлэхээрээ ямар асуудал үүсдэг вэ гэдгийг нь Хөгжлийн банк, манай өмнөх жижиг, дунд үйлдвэрийн асуудлууд гээд гарсан.

Тийм учраас аль болох энэ бодлогын зарчмынхаа дагуу арилжааны банкаараа дамжуулаад тодорхой аж ахуйн нэгжүүдэд дэмжээд явах. Энэхүү шалгууруудыг нь бууруулах, зээлийн батлан даалтын сангаа илүү сайжруулах гэдэг энэ чиглэлээрээ цаашдаа арга хэмжээгээ аваад явна гэсэн байр суурьтай байгаа.

2023 оны дүнгээр амьд үхрийн импорт Францаас 258, Оросын Холбооны Улсаас 418. Нийтдээ 676 сайн чанарын үхрийг бид бүхэн импортоор оруулж ирсэн байна.

2024 онд тодорхой 3 улстай хэлэлцээр хийж ажиллахаар бид бүхэн ажиллаж байна.

Беларус дээр 9 мянган үхрийн асуудал яригдаад байгаа. Тодорхой дайнтай холбогдолтойгоор энэ асуудал гацаад байгаа асуудал байгаа юм.

Яг Булган аймаг дээрх холбогдолтой асуудлыг танд яг одоо би хэлэх боломжгүй байна. Үүнийг тодорхой сайдтай зөвлөж байгаад албан ёсны хариу өгөх нь зөв байх гэж бодож байна.

Г.Ганболд: Ц.Анандбазар гишүүн тодруулья.

Ц.Анандбазар: Баярлалаа.

Тэгээд та сая хэлсэн. Сүүний урамшуулалыг жилийн турш олгоорой. Таны нэр Монголд үлдэнэ шүү.

Яагаад гэвэл таныг сүүний хувьсгал хийсэн сайд гэж нэрлэнэ. Үүнийг цээжилж аварай.

Хоёрдугаар асуудал нь, түрүүн ярьсан. Малын сүү, сүүн бүтээгдэхүүний

үйлдвэрлэлийг явуулахад үнээнийхээ аманд хийх тэжээлийн асуудал онцгой чухал байгаа.

Энэ дээр Ш.Батсүх гэж доктор байсан. Царгас судалдаг.

Монгол оронд тохирох царгасны үрийг үйлдвэрлэлийн хэмжээнд хүргэхээд орхисон ийм судалгааны эрдэм шинжилгээний ажил байгаа юм.

Энэ царгас их чухал байгаа. Нэг боодол царгас өвс 14 боодол цагаан өвстэй тэнцдэг.

Ийм тэжээлийн ургамал байхгүй бол бид цаашдаа үнээний сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл ярих боломжгүй юм.

Тэгэхээр тэр царгасны үйлдвэрлэлийн бодлогыг маш том хэмжээнд авч ирээд 2025 оноос эхлээд энэ үрийг үйлдвэрлэлийн хэмжээнд авчрах бодлого хийх боломжтой юу?

Г.Ганболд: Гишүүд асуулт асуулаа. Би ганц хоёрхон зүйл тодруулчихъя.

Би харин санал хэллээ л гэж ойлгосон. Дараа нь нэмээд хариулт авчихъя.

Одоо бид Улаанбаатарын хэдэн үйлдвэрүүдэд л нийлүүлснийг л яваад байна л даа. Хөдөө орон нутгаас яг энэ уран урамшуулал авч байгаа аль аль аймаг байна вэ? Тэрийг тодруулаад өгөөч.

Энэ 24 үйлдвэрт хотын хэдэн үйлдвэр, орон нутгийн хэдэн үйлдвэр байна вэ?

Хуулиараа энэ чинь үйлдвэр болон цехэд тушаасан бол гэж байгаа шүү дээ.

Тэгэхээр орон нутгийн хүмүүс сайн мэдэхгүй л байгаа юм л даа. Ер нь орон нутгийн цехүүдэд тушаасан сүүний урамшуулал аваад ирэх юм бол энэ тавигдсан хөрөнгө мөнгө нь хэдэн хувьдаа зарцуулагдаж байгаа вэ? Ер нь 100 хувь авчхаад байна уу?

Яг сүү тушаасан үйлдвэрүүдэд тушаасныг нь яг мөнгө өгөхдөө яг яаж баталгаажуулдаг юм бэ? Хий тушаалт хийсэн байх боломж байх уу? Үйлдвэрт.

Тэрийг ер нь яаж шалгаж, хянаж явдаг юм? Энэ дээр нэг товчхон хариулт аваадахъя

3 номер. Сая Ц.Анандбазар гишүүний тэр царгасны асуултыг хариулчхаарай. Нэмээд.

Г.Ганхуяг: Сайн байцгаана уу? энэ сүүний урамшуулал олгосноор энэ малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч, орон нутгийн сүү үйлдвэрлэгчдийн тоо тоо нэлээн нэмэгдэж эхэлсэн байгаа.

2020 онд анх энэ сүүний урамшуулал явагдаж эхлэхэд зөвхөн Улаанбаатар, Төв, Сэлэнгэ, Дархан гэсэн, Улаанбаатараа орох юм бол 4 аймгийн асуудлууд яригддаг байсан бол 2021-2022 онд Орхон аймаг нэмэгдэж орж ирсэн.

2022-2023 онд Булган, Хөвсгөл аймгууд нэмэгдсэн. Энэ жилийн хувьд яг энэ дээр нэмэгдээд Баян-Өлгий, Ховд, Өвөрхангай, Дорнод гээд аймгууд нэмэгдсэн.

Тэгээд зөвхөн үнээний сүүнд олгодог байсан бол одоо бүх төрлийн малын сүүнд олгодог болсон.

Яг үүнтэй холбогдуулаад Өмнөговь аймаг энэ жилээс бас ингэний сүүнд олгогдохоор энэ асуудлууд нэмэгдэж орж ирсэн байгаа.

Г.Ганболд: 4 номер.

Г.Ганхуяг: Мал эмнэлгийн нэгдсэн систем гэж Монгол Улсын хэмжээнд нэвтэрсэн.

Энэ системээр өнөөдөр 237 түүхий эд, бүтээгдэхүүнийг цахим системээр хянаж байгаа. Манай хөдөө аж ахуйн салбар. Түүхий эд бүтээгдэхүүн, эвэр, туурай, өндөг гээд л сүү бүх л бүтээгдэхүүнд орж байгаа.

Өнөөдөр сүүтэй холбоотойгоор Монгол Улсын хэмжээнд мал эмнэлгийн цахим системээр “мал эмнэлгийн гэрчилгээгээр малчны данс”, “статистикийн мэдээлэл”, “**Нүүдэлчин**” аппликэйшн, e-баримт, үйлдвэрийн бүртгэлийн систем, Монголбанкны дансны нэгдсэн систем, Сангийн яамны Төрийн сангийн гүйлгээ, урамшууллын системүүд дээр тухайн иргэний овог, нэр, регистртэй нь тулгаж байгаад эцсийн бүх мэдээллүүдийг татаж аваад Дорж гэдэг хүн 10 үнээтэй бол 10 үнээнээс намрын улиралд өдөртөө 150 литр саам авна гэж үзэхэд сардаа 4.5 литр сүү гарч байна гэдгийг яг үйлдвэрлэг байдал тугалсан, хэзээ тугалласнаас нь шалтгаалаад тоо хэмжээг бүгдийг нь гаргаж байгаа.

Тийм учраас өнөөдөр манай сүүний иргэдэд орж байгаа, шууд малчны дансанд орж байгаа энэ цахим системээр зөрүүтэй мэдээлэл энд ерөөсөө гарахгүй байгаа.

Ер нь цаашдаа манай мал эмнэлгийн нэгдсэн систем Монгол орны 330 сум, нийт багаас мал амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнүүдийг

бүгдийг нь цахимаараа хянаад баталгаажуулаад гаргаад өгчих бололцоотой гэсэн үг.

Арьс шир, мах, бусад бүтээгдэхүүн дээр.

“Царгас” дээр Ш.Батсүх докторын царгас бол үнэн. Үүн дээр ялангуяа Төв аймгийн Цээл, бусад сумдууд дээр, Борнуур дээр энэ Бургалдай сортын царгасыг нутагшуулаад өнөөдөр Монголын эрчимжсэн мал аж ахуйн нэгжүүд энэ царгасаар тодорхой хэмжээнд хангагдаж байгаа.

Ямар ч байсан үр нь өөрөө нэг ургаж байж, олон наст ургамал учраас тодорхой хугацаа ордог ургамал.

Ямар ч байсан **“өвсний хаан”** бол мөн. Үүнийг Хөдөө аж ахуйн яам **“Малын тэжээл хөтөлбөр”**-ийн хүрээнд боловсруулагдаад нутагшуулаад нэлээн гаршуулсан ийм сайхан ургамал байгаа.

Үүнийг цаашдаа бэлчээр тэжээлийн бодлогын хүрээнд энэ “өвсний хаан” тэжээлийн нэг болон олон наст ургамлуудыг бүс нутгийн хүрээнд газар тариалангийн аж ахуйн нэгжүүдтэй сэлгээний бэлчээр маягаар тарих бодлого явж байгаа. Баярлалаа.

Г.Ганболд: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Ер нь бас амжилттай хэрэгжиж байгаа төсөл.

Их Хурлын дарга байсан Миесэгомбын Энхболд гуай үүнийг санаачилж байсан санагдаж байна.

Тэгээд ер нь цаашдаа олон аймгууд ороод ирэхээр энэ өөрөө жаахан хяналтаас гарч мэдэх зүйл.

Тэгээд ноолуур гэх юм бол ямааны тоо толгой “А” данснаасаа мэдээж хэдэн грамм гарах вэ гээд ингээд хянаад явчхаж боломжтой.

Сүү бол ингээд маш бүх аймгуудад яваад ирэх юм бол хянах боломжгүй. Хэдэн ч литр сүү саасан гэж ярих боломжтой зүйл л дээ. Урамшуулал нэлээн хавтгайрвал.

Тэгэхээр үүнийг тушаасан. Ер нь цаашдаа журмаа жаахан нарийсгаад тухайн компаниас тэр малчин руу яг шилжсэн сүүний мөнгөнд тулгуурлаж.

Хоёрдугаарт, ерөөсөө тухайн тэр сүү, бүтээгдэхүүнийг авсан компанийн татварын бодлоготой уялдуулж явахгүй бол хий бичилт хийгээд явах магадлал асар өндөр шүү. Энэ өөрөө. Цаашдаа хавтгайраад ирвэл.

Тэгээд үүнийг эхнээсээ жаахан уялдаа холбоотой, тэр шилжсэн мөнгө төгрөг, тэр татвартай нь уяж явахгүй бол их төвөгтэй асуудалд орно.

Үүнийг манай яамныхан хэрэгжүүлж байгаа байгууллагууд анхаарах байх гэж бодож байна.

Тэгээд саяын гишүүдийн хэлсэн зүйлүүдийг хэрэв бүхэлдээ хугацааны хувьд 2026 он гэж ойлгосон. Тийм ээ. 2026 он, 2027 он хүртэл юм байна.

Тэгээд сая гишүүдийн хэлж байгаа тэр яг үнэхээр улирлын шинжтэй хүйтний улиралд гэж өгч байгаа бол бас яг одоо тэр ногоо цагаа гараад, сүүг гарах хүртэл гэх юм бол хугацааг нь сунгахад болохгүй зүйл байхгүй байна.

Гэхдээ үүнийг санхүүжилтийнхээ эх үүсвэртэй сайн уяхгүй бол хугацааг нь сунгаад.

Одоо тэгээд бүх аймгууд мэдээд хүрээг нь тэлээд ирэх юм бол төсөв дээр нэлээн их хэмжээний мөнгө гарч ирэх ийм эрсдэлүүд байгаа.

Тэгээд үүнийг аль болохоор анхаарна байх гэж бодож байна.

Хоёр дахь асуудал хэлэлцэж дууслаа. Ажлын хэсэгт баярлалаа.

**Гурав. Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны
2022 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 05 дугаар тогтоолын
хэрэгжилт болон Жижиг, дунд үйлдвэрийн газрын үйл ажиллагааны
талаарх тайланг хэлэлцэх**

3 дахь асуудал. Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, төрийн санхүүгийн бүтцийг оновчтой болгох, эх үүсвэрийг нэмэгдүүлэх, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид орчин үеийн санхүүжилтийг нэвтрүүлэх, зах зээлийг тэлэх, борлуулалтыг нэмэгдүүлэх гэсэн сэдвээр мэдээлэл хийнэ.

Ажлын хэсгийг танилцуулъя.

М.Ганхүлэг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд, Я.Эрдэнэсайхан Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга, А.Гэрэлзаяа Жижиг, дунд үйлдвэрийн газрын Бодлого зохицуулалтын хэлтсийн дарга, Н.Энхтөр Зээл, төслийн хэлтсийн дарга гэсэн ажлын хэсэг байна.

Я.Эрдэнэсайхан дарга. Ажлын хэсгийн 2 номер.

Я.Эрдэнэсайхан: Та бүхэндээ өдрийн мэнд хүргэе.

2022 онд Улсын Их Хурлын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооноос 5 дугаар тогтоолоор 5 заалт бүхий тогтоол баталж жижиг, дунд

үйлдвэрлэлийн салбарын тодорхой асуудлуудыг шийдэх чиглэлийг Засгийн газарт өгсөн.

Ингээд нэг дэх асуудлын хүрээнд бид бүхэн 2022 онд олон улсын жижиг, дунд үйлдвэрийг дэмжих санхүүгийн бүтэц, тогтолцоо ер нь ямар арга хэрэгслээр хийж байгаа юм гэдэг талаар судалгааг эдийн засаг, нийгмийн хувьд ойролцоо 48 орны түвшинд их дээд сургуулийн багш нар, эрдэмтэн, судлаачидтай хамтраад судалгаа хийсэн.

Эндээс 48-аас 46, 47 нь яг жижиг, дунд үйлдвэрийг дэмжих тухайн улсын бүтэц байгаад байгаа.

Энэ санхүүжилт олгодог, хянадаг бүтэц маань банкны шаардлага хангахгүй, банкны хүнд нөхцөлөөс арай хөнгөн нөхцөлөөр тусгайлсан үйлдвэрлэгчдийг дэмжих зорилгоор бага хүүтэй, хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлийг олгодог.

Энэ боловсруулсан саналаа жижиг, дунд үйлдвэрийн корпорац байгуулах санал боловсруулаад Байнгын хорооны дэд хороо, Жижиг, дунд

Үйлдвэрийн хөгжлийн дэд хороо, тэгээд яам, олон улсын хөгжлийн байгууллагууд буюу Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк, ЖАЙКА, Америкийн Нэгдсэн Улсын Хөгжлийн агентлаг, Дэлхийн банк, Монгол талаасаа Монголын банкнуудын холбоо зэрэг байгууллагуудад саналыг хүргүүлсэн.

Бид ямар корпорац байх ёстой вэ гэхээр төр, хувийн хэвшил, доноруудын 33, 34 гэсэн санхүүжилтгэйгээр корпорац байгуулья гэдэг саналыг боловсруулсан.

Тэгээд банкуудын холбоотой саналаа тавиад нэлээн олон удаагийн уулзалт хийсний эцэст банкуудын холбоо хөрөнгө оруулалт хийх боломжгүй гэсэн саналыг өгсөн.

Тийм учраас санхүүжилтийн корпорац маань өнөөдөртөө яг байгуулагдаагүй. Яваагүй байгаа.

Ер нь олон улсынхаа жишгийг харах юм бол ийм санхүүжилтийн тусгайлсан бүтэц байх нь зөв гэсэн ийм байр суурьтай байгаа.

Хоёр нь, 10 их наядын хөтөлбөр дээр жижиг, дундын зээлийн эх үүсвэрийг шийдвэрлэх чиглэл өгсөн.

Энэ хүрээнд ажлын байрыг дэмжихтэй холбоотой хэсэг нь жижиг, дундын салбарт хамаарч байгаа. Энэ ажлын байрыг дэмжихэд нийтдээ 2 их наяд төгрөгийг 25 мянган зээлдэгчид 2021 он хүртэл олгосон байгаа. Эндээс мэдээж 110 мянган ажлын байр хадгалагдсан.

Тийм учраас энэ 10 их наяд дээр тусгагдсан жижиг, дундын салбар дахь ажлын байраа хадгалагдах хөтөлбөр үүргээ гүйцэтгэсэн гэж харж байгаа.

Гуравт нь, зээлийн эргэн төлөлтийг сайжруулах, авлага, өр төлбөрийг барагдуулах, хөрөнгөө татан төвлөрүүлэх үүрэг чиглэлийг өгсөн.

Энэ хүрээнд бид 2020-2023 оны хооронд 2020 онд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Жижиг, дунд үйлдвэрийн агентлаг байгуулагдсан.

Энэ агентлаг байгуулагдаад бусдад төлөх 123.0 тэрбум төгрөгийг төлсөн.

Энэ дотор Хөгжлийн банкны бонд, Засгийн газрын бондын төлбөрүүд байгаа.

Үүнээс гадна бид 88.0 тэрбум төгрөгийг жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэдээ 3 жилийн хугацаанд зээл хэлбэрээр олгосон байгаа.

2009 онд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан байгуулагдсанаасаа хойш 8400 зээлдэгчдэд зээл олгосон. Үүний 7200 нь зээлээ бүрэн төлөөд дууссан буюу 85, 86 хувь нь зээлээ бүрэн төлөөд дууссан байгаа.

Өнөөдрийн байдлаар 1200 гаруй зээлдэгчтэй байгаа.

Нийтдээ 1 их наяд төгрөгийн зээлийг энэ хугацаанд зээл болгож олгосон.

690 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг улсын төсөв, Засгийн газрын бонд, Хөгжлийн банкны бонд, бусад эх үүсвэрээс төвлөрүүлээд олгосон.

Энэ дотроос нийтдээ 53 мянган ажлын байр шинээр бий болгосон. 38 мянган ажлын байр хадгалсан.

Улсын төсөвт бид нарын тооцооллоор жилдээ энэ зээл олгосон 8 мянга гаруй аж ахуйн нэгжүүд улсын төсөвт 50.0 тэрбум төгрөгийн нийгмийн даатгал болон татварын нэмэр болж явж байгаа.

2023 оны хувьд бид 36.0 тэрбум төгрөгийг 265 аж ахуйн нэгжид зээл хэлбэрээр олгосон. Сонгон шалгаруулалтыг хийгээд олгочихсон байгаа.

Дөрөв дэх асуудлын хувьд, санал боловсруулах байгаа.

Жижиг, дунд үйлдвэрийн техник, технологийг шинэчлэх зорилготой.

Энэ хүрээнд хүнс, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах зориулалттай үндсэн хөрөнгөд бүртгэгдэх шинэ тоног төхөөрөмжийг гаалийн албан татвараас чөлөөлөх саналыг боловсруулаад Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлээд 2027 оны 01 сарын 01-ний өдөр хүртэл чөлөөлөхөөр Засгийн газрын тогтоол батлуулсан. 107 дугаар тогтоолоор.

Тавд нь, уулын уурхайн компани болон томоохон төсөл, хөтөлбөрүүдэд жижиг, дундын бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээнд нь оролцуулах үүрэг чиглэлийг өгсөн.

Энэ хүрээнд бид Канадын Засгийн газрын санхүүжилттэй “Мерит” төсөл байгаа. “Мерит” төслийнхөнтэй хамтраад 4 аймагт ажлын хэсэг байгуулаад ажилласан.

Энэ хүрээнд жишээ нь, 2019 онд “Мерит” төсөл эхлэхэд 200 хэдэн сая төгрөгийн л томоохон уурхайн компаниудад бэлтгэн нийлүүлэлт хийдэг байсан бол хамтарч ажилласны хүчинд

2023 онд гэхэд зөвхөн дээрх 4 аймаг дээр 4.6 тэрбум төгрөгийн борлуулалтыг уурхайн компаниудад нийлүүлсэн.

Бид дараагийн шат буюу Канадын Элчин сайдын яам, “Мерит” төслийнхөнд. Энэ төсөл сая оны эцэст ингээд дуусаж байгаа. Дараачийн шатыг нь үргэлжлүүлээч ээ гэдэг байдлаар Канадад байгаа Монгол Улсын Элчин сайдын яам зэрэг байгууллагууд хүсэлт тавиад ажиллаж байгаа.

Мөн бид Mining Week гэж ярьдаг. Уурхайн компаниудын уурхайн бүтээгдэхүүний долоо хоногийн арга хэмжээ болдог. Жил бүр.

Энэ арга хэмжээнд анх удаа 2023 онд жижиг, дунд үйлдвэрлэгчдийнхээ бараа, бүтээгдэхүүнийг танилцуулах жижиг үзэсгэлэн зохион байгуулсан.

Энэ дээр энэ дээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам сайдын зүгээс маш сайн дэмжлэг үзүүлсэн.

Энэ жилийн хувьд тухайн Mining Week дээр үзэсгэлэн гаргая гээд төлөвлөөгүй байсан юм билээ. Хоёр жил тутам хийдэг.

Ирэх жил нэлээн өргөн хүрээнд үзэсгэлэн хийнэ. Энэ дээр манайх ч гэсэн илүү оролцоотой оролцье гэдэг байдлаар харилцан ойлголцсон байгаа.

Мөн Худалдан авах ажиллагааны газрын ерөнхий гэрээнд хүнсний зориулалттай түүхий эд, бүтээгдэхүүнүүдийг ерөнхий гэрээгээр оруулах ажлыг Худалдан авах ажиллагааны газар, яам болон холбогдох байгууллагуудтайгаа ярилцаж оруулж чадсан.

Үүний хүчинд өнгөрсөн 2023 оны 11 сарын байдлаар гэхэд 34 нэр төрлийн 6500 ширхэг хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний борлуулалт хийсэн.

Эндээс нэг их тэрбум төгрөгийн худалдан авалтыг хийгээд 200 гаруй сая төгрөгийн хэмнэлтийг төсөвт бий болгосон ийм үр дүн гаргасан байгаа. Баярлалаа.

Г.Ганболд: Асуулт асуух гишүүд нэрсээ өгье.

Н.Наранбаатар гишүүн асууя.

Н.Наранбаатар: Танилцуулгыг сонслоо.

Уул уурхайн компаниуд томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч нартай хамтарч ажиллаж байгаа гэж байна. Тухайлбал, тодруулаад ямар ямар томоохон уур уурхайн компаниудтай хамтарч ажиллаж жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн хэдий хэмжээний ямар нэр төрлийн бүтээгдэхүүнийг нийлүүлж байна.

Тэр гэрээ байгуулсан гэж байна шүү дээ. Ашигт малтмал, газрын тосны газартай.

Гэрээндээ яг яаж тусгасан юм? Хэр үр дүнтэй. Гэрээний хэрэгжилт хэр байна гэсэн бодитой юм байвал хэлж өгөөч.

Тэгээд сая тоо хэлсэн. Их л бага л дүнтэй юм хэлчих шиг болох юм. 4 аймагт уу? Зөвхөн. Зөв зөв.

Тэгэхдээ Өмнөговийн хувьд Оюу Толгойтойгоо хамтарч ажиллаад юун 90 тэрбум гэж. 100 гаруй сая долларын л. Тэр жилдээ юу л нийлүүлээд байгаа бол л доо.

Тэгээд энэ нь хэр цаашаа бодитой, ахицтай явж байна гэдэг дээр нэг жаахан тодруулаад авчихмаар байна.

Эргэн төлөлт хэр байна? Одоо ер нь үлдэгдэлтэй хэчнээн аж ахуйн нэгж хэчнээн тэрбум төгрөгийн чанаргүй, муу актив гэж яриад байна уу. Тийм ээ. Үүнийхээ мэдээллийг өгөөч.

Эргэн төлөлт гайгүй явж байгаа юм шиг байна. Тэгээд төлөгдөхгүй байгаа шалтгаан нь юу байна вэ гэдэг дээр нэг тодруулчихъя.

Тэр нөгөө санал хүргүүлсэн гээд нэгдүгээр асуудал дээр олон улсын байгууллагууд руу. Тэрийгээ бас тодруулаад.

Заавал тэдэнтэй хамтарч ажиллах шаардлагатай байгаа юм уу? Нөгөө Засгийн газар хамтраад орчихоор зарим олон улсын байгууллагууд чинь зээл өгөхгүй байх тал байна уу, үгүй юу? Цэвэр аж ахуйн нэгжүүддээ өгнө, засаг руу өгөхгүй гэдэг шаардлага тавьж байгаа газрууд бас байж магадгүй.

Тэгээд энэ дээр заавал. Тэгээд ямар саналууд ирж байна вэ? Ямар хариу ирж байна вэ? Саналуудад гэдэг дээр нэг тодорхой хариулт өгчихвөл зүгээр байна.

Г.Ганболд: 2 номер.

Я.Эрдэнэсайхан: Н.Наранбаатар гишүүний асуултад хариулья.

Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан.

Уул уурхайн компаниуд томоохон компаниудтай бид хамтарч ажиллаж байгаа.

Таны хэлдэг Оюу Толгой, Эрдэнэт гээд компаниудад бид санал хүргүүлээд тухайн байгууллагууд худалдан авалт хийхдээ манайхаас тухайн чиглэлийн компаниудын саналыг авч шууд гэрээгээр болон бусад хэлбэрээр худалдан авалтууд хийж байгаа.

Н.Наранбаатар гишүүний хувьд жижиг, дунд үйлдвэрийг нэлээн сайн дэмждэг. Засаг дарга байхдаа жижиг, дунд үйлдвэрийн санд Өмнөговь аймгийн төсвөөс хөрөнгө мөнгө хуваарилаад анх орон нутгийн санхүүжилттэй жижиг, дунд үйлдвэрлэлийг төсөв мөнгө тавьж хамтарч сонгон шалгаруулах ажлыг эхлүүлж байсан.

Энэ хүрээнд миний санаж байгаагаар 2018, 2019 онд 1 тэрбум, дараа нь 2 тэрбум гээд мөнгүүдийг тавиад тухайн орон нутгийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зээл олгоод явж байсан.

Энэ маань улам өргөжөөд явж байгаа.

Хоёр дахь асуулт нь, Ашигт малтмал, газрын тосны газартай бид сая 11 сард гэрээ байгуулсан.

Энэ гэрээ маань ямар учиртай юм бэ гэхээр Ашигт малтмал, газрын тосны газар орон нутгуудад нэгжтэй болж байгаа юм билээ. Уул уурхайнхаа асуудлыг хариуцсан.

Тэгэхээр тэр хариуцсан нэгжээр нь дамжуулаад бид сая “Мерит” төслөөр 4 аймаг дээр бүтэц, дэмжлэг хийж үзлээ.

Тэгэхээр үнэхээр үр дүнтэй байдаг юм байна. Түрүүний хэлснээр 20 дахин нэмэгдэж байгаа. Уул уурхайн компаниудад жижиг жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн нийлүүлсэн бараа,

бүтээгдэхүүний тоо гурав, дөрөвхөн жилийн дотор.

Тэгэхээр үүнийг бүх аймгуудад нэвтрүүлбэ гэдэг ийм саналыг гаргаад “Мерит” төсөл, Канадын Элчин сайдын яамныхантай уулзахад Монгол Улсын жижиг, дунд үйлдвэрийн байгууллага нь дэмжиж байгаа юм байна. Тэгвэл Ашигт малтмал, газрын тосны газар буюу тухайн байгууллага нь ямар байр суурьтай байгаа юм бэ гэсэн.

Тэгэхээр бид энэ хоёр байгууллага хамтарч болж байгаа. Энэ төсөл хэрвээ үргэлжилбэл улс орны хэмжээнд үр дүнгээ өгөх төслийг үргэлжлүүлбэ гэдэг ийм санааны үндсэн дээр **MoU**¹[*memorandum of understanding*] байгуулаад дөнгөж сар гаруйхан болж байгаа.

Тэгээд тухайн байгууллагатай нэлээн ярилцаж явж байгаа. Энэ жилийн хувьд үүнийгээ бусад аймгууд дээрээ зөвхөн төсөл гэхгүйгээр хэрэгжүүлбэ гэсэн ийм санаа ярилцаад явж байгаа.

Эргэн төлөлтийн хувьд би түрүүн хэлсэн. 8400 зээлдэгчээс 7200 нь бүрэн төлөөд дууссан. Өөрөөр хэлбэл 85, 86 хувь нь бүрэн төлөгдсөн. Сан байгуулагдсанаасаа хойш.

Өнөөдрийн байдлаар 1200 гаруй зээлдэгчид идэвхтэй байна. Үүний 300 гаруй нь таны хэлдгээр муу зээл байгаа.

Энэ муу зээл дотроо бас нэлээн ангилагдаж байгаа. Жишээлбэл, яг өнөөдрийн байдлаар эзэн холбогдогч нь

¹ Харилцан ойлголцлын санамж бичиг буюу санамж бичиг нь талуудын аливаа үйл ажиллагаа явуулах, бизнесийн гүйлгээ хийх, шинэ түншлэл байгуулах хүсэл эрмэлзлийг тодорхойлсон үүрэг хүлээдэггүй гэрээ юм.

нас барчихсан 9 зээлдэгч байна. Гадагшаа оргоод гарчихсан 6 зээлдэгч байна. Прокурор дээр бид хамтраад ажиллаж байгаа 3, 4 зээлдэгч байна.

Гэх мэтчилэн ингээд бид секторлоод хуваагаад нийтдээ өнөөдөр 200 гаруйг нь шүүхийн журмаар хууль хяналтын байгууллагад өгөөд маргаад явж байгаа.

Энэ дээр нэлээн бэрхшээлүүд гардаг. Ерөөсөө зээл авснаа хүлээн зөвшөөрдөг. Гэхдээ төлөхгүй гэсэн ийм хэсгүүд байгаад байгаа юм.

Тэгэхээр 2020 онд бид Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг байгуулагдахдаа хууль тусгай активын хэлтэс гээд яг энэ зөрчилтэй хэсэг дээр ажиллах нэгжийг байгуулаад 5, 6 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байгаа. Энэ маань нэлээн үр дүнгээ өгч байгаа.

2020 оноос өмнө жилдээ энэ зөрчилтэй хэсгээс 2 тэрбум төгрөгийг л төвлөрүүлдэг байсан.

Бид 2023 онд гэхэд энэ зөрчилтэй хэсгээс 18.0 тэрбум төгрөг төвлөрүүлсэн.

Нийтдээ давхардсан тоогоор 900 гаруй.

Тэгэхээр хууль хяналтын байгууллага, шүүх дээр энэ нэлээн уддаг. Доод тал нь л гурав, дөрөн жил. Тэгээд дараа нь шүүхийн шийдвэр. Тэгээд нөгөө үнэлгээ дээр нь маргадаг. Тэгээд ерөөсөө төлөхгүй хоёр чих ав гэдэг ийм хэсэг ерөнхийдөө үлдчихээд байгаа.

Г.Ганболд: Тодруулах юм уу? Нэмж хариулья. 2 номер.

Я.Эрдэнэсайхан: Н.Наранбаатар гишүүний асуултад нэмж хариулья.

Жижиг, дунд үйлдвэрийн корпорац байгуулахтай холбоотой түрүүн нөгөө 48 орны судалгаан дээрээс энэ харагдаж байгаа.

Бид хамгийн гол хамтарч ажиллаж байгаа байгууллага ЖАЙКА байгаа.

ЖАЙКА-гийнхантай хамтраад 2017, 2018 онд судалгаа хийгээд жижиг, дунд үйлдвэрийн корпорац байгуулья гээд явж байтал 2018 онд нэг асуудал үүссэн. Ингээд энэ асуудал маань зогсчихсон.

Тэгээд 2020, 2021, 2022 гээд ер нь жил тутам ЖАЙКА-гийнхантай уулздаг. Тэгээд ЖАЙКА-гийнхан юу гэж хэлдэг вэ гэхээр Монгол Улсын өрийн тааз нэлээн өндөр байна. Макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг чинь харж байж бид дараагийн шатын санхүүжилт, корпорац байгуулах асуудлыг ярья гэдэг ийм байдлаар нар хүлээгдээд байгаа.

Тэгэхээр түрүүний хэлсэн төрийн зүгээс 34 хувьдаа ороод явахад жижиг, дунд үйлдвэрийн өнөөдөр байгаа активаар боломжтой.

Нөгөө хувийн байгуу сектор буюу банкнуудын холбоо татгалзчихсан. Олон улсын байгууллага бол ингээд харзнаад байгаа юм. Яг өнөөдрийн байдлаар байдалтай байгаад байгаа юм.

Г.Ганболд: Санал хэлэх гишүүн байвал хэлье.

Ж.Батжаргал гишүүн. Т.Аубакир гишүүний нэрийг оруулаад. Т.Аубакир гишүүн санал хэлье гээд байна. Т.Аубакир гишүүний нэрийг оруулчих.

Ж.Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Байнгын хорооноос гаргасан тогтоолын хэрэгжилт юмнуудыг нь анзаарсан. Тодорхой ажил, алхмууд хийгдсэн юм билээ.

Тэгэхээр одоо бидэнд анхаарах ёстой зүйл бол хоёр, гурван зүйл байгаад байгаа юм шиг байгаа юм. Би бол тэгж хардаг юм.

Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхийн тулд бид банк, санхүүгийн активуудыг ашиглах тухай асуудал. Ингэхийн тулд батлан даалтын сангийнхаа асуудлыг л онцгой анхаарах ёстой л доо. Нэг.

Хоёрдугаарт, энэ чиглэлээр тэндээс олгогдож байгаа зээлийн хугацааны асуудал нэн чухал байгаад байгаа.

Угаасаа наадах чинь жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжиж байгаа юм бол мэдээж хөрөнгийн зээлийн асуудал байгаа байхгүй юу. Тэгээд эргэн төлөлтийнхөө буюу анхны өртгөө нөхөхтэйгөө холбогдож хугацааны асуудал яригдах ёстой. Үүнийгээ бид зөв тооцох тухай асуудал байна гэж. Нэг.

Хүүгийн хувьд бид тэртээ тэргүй сүүлийн хоёр, гурван жил ямар ч байсан нэг тийм зөв менежмент гэмээр юм уу даа, юм явчихсан. Үүнийг харин яаж цааш нь тогтвортой авч явах вэ л гэдэг л асуудал байгаад байгаа юм.

Тодорхой хүүгийн зөрүүгийн хөнгөлөлт эдлүүлээд яваад байгаа нь үндсэндээ бидний зориод явсан өнөө бодлогын зээл буюу сангуудаар дамжаад явсан юм маань бараг нэг голдирол руугаа орлоо гэсэн санаа байхгүй юу.

Тэгэхээр үүнийг нэг харах ёстой гэж.

Хоёрдугаарт, ерөөсөө жижиг дунд үйлдвэрлэлийг өөрийг нь амь оруулья, тогтвортой үйлдвэрлэл байлгая гэвэл хэрэглэгчтэй нь уях тухай л асуудал л даа. Ерөөсөө уг үйлдвэрийн бүтээгдэхүүнийг.

Тэгэхээр зэрэг Монголд хэрэгжиж байгаа тэр тогтоолын 5 дахь заалт байгаа билүү, 4 дэх заалт байгаа билүү? Тэрийг л онцгой анхаарах ёстой юм. Томоохон төслүүд тэр том аж ахуйн нэгжүүдийн хэрэглээг жижиг, дунд үйлдвэрүүдээрээ хангуулах тухай асуудал дээр бид ахиухан хийх. Энэ судалгааг хийж харин энэ орон нутгууд, тэр олгох төслүүдийнхээ эрэмбэ дараа юмыг тогтохдоо үүнийг нэлээн анзаарч барих ёстой л зүйл байгаа юм.

Бэлэн бүтээгдэхүүнээ борлуулах зах зээлтэй ийм төслүүдээ илүүтэй дэмжиж явах замаар л орон нутагт жоохон үйлдвэр бий болох, ажлын байр бий болох, тэрнийг дагаад нэмүү өртөг бий болох ийм л бололцоо боломж л байна л гэж л ингэж хараад байгаа.

Дараагийн нэг зүйл бол энэ жижиг, дунд үйлдвэрүүд яг өөрөөрөө дагнаад бүх юмыг хийчдэггүй. Толгой компани гэдэг юм уу, тийм кластер сүлжээний л тухай л ойлголт.

Тодорхой томоохон аж ахуйн нэгжүүдийн захиалгыг жижиг, дунд үйлдвэрүүдээр хангуулдаг. Тэр нь өөрөө тэр захиалагч компанийнхаа эрэлт дээр суурилж явдаг энэ л арга ажиллагаа л байж гэмээ нь л явдаг. Японы тэр нэг суурьны бүтээгдэхүүн чинь яг л наад зарчим чинь шүү дээ.

Тэгэхээр энэ талаа бид нэлээн сайн харж, энэ үндэсний томоохон үйлдвэрүүдийн томоохон захиалгуудыг хангахад өөрийнх нь хүчин чадал, элдэв бусын юм эргэлзээ байгаад байгаа бол хамтарсан энэ жижиг үйлдвэрүүдээр дамжуулж хийх л ийм л үйл явц шүү дээ.

Тэгээд энэ талын юмыг л илүү харвал бидний тавиад байгаа зорилт юмнууд илүү их бодитой л ажил хэрэг болно л гэж би бодоод байдаг.

Түүнээс үйлдвэр гэдэг бол зүгээр тоног төхөөрөмж суурилуулснаар биш л дээ. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь аль нэг хэрэгцээг хангаж, буцаад өөртөө тэр хариу төлбөр нь орж ирж байгаа үйл явцаараа л жинхэнэ үйлдвэрлэл гэж л яригдах ёстой. Үүнийг л бид нэлээн сайн анхаарч ажиллаж чадвал ихээхэн зохилтой байх болов уу л гэсэн л бодол байна.

Г.Ганболд: Т.Аубакир гишүүн.

Т.Аубакир: Баярлалаа.

Яах вэ, энэ хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой биш байна.

Г.Ганболд дарга аа. Дараагийн долоо хоногийн хурал дээр манай Байнгын хорооныхон ч гэсэн хоёр асуудлыг оруулж ирээд хэдүүлээ бас нэг үйл явц энэ тэрийг нь сонсчихмоор байгаа юм.

Нэгдүгээрт, Эрдэнэбүрэнгийн цахилгаан станцын үйл явц ер нь яг ямаршуу явж байна?

Энэ Эрдэнэбүрэнгийн цахилгаан станц дээр тухайн тэр бүс нутагт газарт орсон айлуудын нөхөн олговрын асуудал гээд баахан өргөдөл, гомдол тойргийн гишүүдэд Ховдын, Увсын, Баян-Өлгийг

сонгочихсон гишүүд дээр маш олон өргөдөл, гомдол ирсэн байгаа учраас энэ нөхөн олговрын асуудал яг ямар шатандаа явж байна.

Тэр тухайн баригдаж байгаа цахилгаан станцын үйл ажиллагаа нь ямар түвшинд явж байгаа юм бэ гэдгийг нэг сонсчихмоор байгаа юм.

Энэ эрчим хүчний хомсдолтой холбоотой. Цаашдаа Монгол Улсын стратегийн бодлогын асуудал учраас нэгдүгээрт энэ асуудлыг сонсчихъё гэж.

Хоёрдугаарт, “Эрдэнэс Монгол” дээр байгаа Асгатын тэр уурхайг ашиглалтад оруулах, эдийн засгийн эргэлтэд оруулах асуудал маань яг ямар түвшинд явж байна. Асгатын явцыг сонсмоор байна.

“Эрдэнэс Монгол” дээр энэ Асгатыг хариуцсан мэргэжилтнүүдийг нь дуудаад яг явцыг нь сонсмоор байгаа юм.

Сая гурван ч сонгон шалгаруулалт зарласан. Хоёр нь амжилттай яваад, гурав дахь маань фэйлдчихлээ. Явах боломжгүй болчихлоо. Үүнийх нь явцыг сонсьё.

Үүнийг дараагийн хуралдааны хэлэлцэх асуудалд оруулж өгөөч ээ гэсэн хүсэлт байгаа юм. Хуралдаан даргалагчаас. Тийм.

Г.Ганболд: Ойлголоо. Тэрийг ирэх долоо хоногийн Байнгын хорооны хурлаар тогтоолын төслүүд, Асгаттай холбоотой өмнө нь бас тогтоол гарч байсан юм билээ. Тэрний биелэлтийг сонсох хүрээнд асуудлыг хэлэлцэж болно.

Байнгын хорооны 2022 оны 04 сард гарсан энэ 05 дугаар тогтоолын

хэрэгжилт яг үнэндээ заалт бүрээр нь үзэх юм бол жаахан хангалт муутай л байгаа юм л даа.

1 дүгээр заалт бол одоо ингээд корпорацын зохион байгуулалтад оруулахаас өгсүүлээд л. Тийм ээ.

2 дахь нь нөгөө 10 их наядын хөтөлбөрийн санхүүжилтээс эдийн засгийг эрчимжүүлэх. Эндээс жижиг, дунд үйлдвэрлэлийн эх үүсвэрийг олох.

3 дахь заалт бол эргэн төлөлт дээр жаахан анхаарсан байна л гэж ингэж ойлгож байна.

Тэгэхээр эргэн төлөлтийг дахиж эрчимжүүлэх хэрэгтэй. Одоо 1200 аж ахуйн нэгж гэдэг бол бас л их байна.

Одоо эндээс үнэхээр тийм зээлдэгч нь, тэгээд хамтран зээлдэгчгүй байж байгаад нас барсан энэ тэр асуудлууд байх юм бол үүнийг ойлгож үзэж болох байх.

Бусдынх нь хувьд энэ шүүх байгууллагаар яваад, бас энэ Хөгжлийн банкны төлбөр ч гэсэн нэлээн харьцангуй гайгүй төлөгдөж байна шүү дээ.

Тэгээд энэ хүрээнд жоохон эрчимтэй хөөцөлдөж үүнийг барагдуулах тал дээр анхаарах хэрэгтэй байгаа юм.

Тэгээд ер нь цаашдаа энэ жижиг, дунд үйлдвэрлэлийн зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх тал дээр л гол анхаарал хандуулах ёстой. Эргэн төлөлтөөрөө сайн санхүүжүүлэх ёстой. Эргэн төлөх баталгаатай төслүүдэд зээл олгох ёстой.

Барьцаа хөрөнгийг маш сайн авч байж өгөхгүй бол. Ер нь өмнө нь завхарч ирсний л ул мөр одоо энэ 1200 аж ахуйн

нэгж зээлээ төлөхгүй байгаад байна шүү дээ.

Тэгээд үүнийг эрчимжүүлэх тал дээр онцгой анхаарах хэрэгтэй байгаа юм.

Ер нь цаашдаа корпорацын зохион байгуулалтад ороод явна гэдэг ер нь л оновчтой хувилбар байгаа юм шүү.

Ер нь аж ахуйн тооцоонд ороод ингээд явах юм бол эргэн төлөлт шал өөр болоод явчихна л даа.

Тэгээд үүнийг нэг эргэж харах ёстой. Тэгээд энэ чиглэлээр яам, газрынхан хуучин замбараагүй байсныг бодох юм бол нэлээн цэгцдээ орж байгаа. Тэрийг бид ойлгож байгаа. Цэгцдээ орж байна.

Гэхдээ хамгийн гол нь цэгцдээ орж байна гээд эх үүсвэргүй суугаад байгаа нь тийм сайн зүйл биш. Өмнөхөө цэгцэлж байна гээд олигтой зээл ч олгодоггүй ингээд суугаад байх биш.

Аль болохоор зээл олгохдоо бид жил болгон гаднаас импортоор оруулж ирж байгаа бараа, бүтээгдэхүүн дээр л нэр төрөл зааж л ер нь. Энэ жил жишээлэх юм бол бид төрлийн төслүүдэд л өгнө шүү гэдэг юмнуудыг зааж явахгүй бол юу хамаагүй авдаг.

Тэгээд манайхны чинь нэг төрийн бодлогогүй байгаа юм бол ерөөсөө бүгдээрээ нэгнийгээ дуурайж бизнес хийнэ. Тэрийг нь санхүүжүүлсээр байгаад бүгдээрээ нэгнийгээ чирч унагадаг, дампуурдаг.

Орон нутгийн нөхцөл байдал ерөөсөө тийм шүү дээ. Эднийх нэг юм хийгээд байна. Цөм хийгээд байх шиг байна гээд л бүгдээрээ орчихдог.

Тэгэхээр зарим төрлийн дотооддоо бүрэн хангаад байгаа юмнуудад огт өгөхийг нь болиод. Тэр л бид нарын төрийн бодлого байхгүй юу. Ерөөсөө жижиг, дунд үйлдвэрлэлийн газар тусдаа энэ төрийн агентлаг болсны би зорилго нь тэр гээд байгаа шүү дээ. Танайх бол одоо ерөөсөө бодлогын газар болсон.

Тийм учраас бид ямар төрлийн бизнес эрхлэхэд олгох вэ гэдэг бодлогоо тодорхой болгоод л, тэр жилдээ энэ жил бид ийм төрлийн л юмыг, тодорхой төсөл байх юм бол санхүүжүүлнэ гэдгийг нь зарлаж явахгүй бол юу хамаагүй аваад

байх юм наадах чинь явахгүй болчхоод байгаа юм.

Тэгээд энэ дээр л онцгой анхаарч ажиллах ёстой гэж бодож байна.

Гурав дахь асуудлыг сонслоо. Ажлын хэсэгт баярлалаа.

Өнөөдрийн Байнгын хорооны хурлаар хэлэлцэх асуудал дууслаа.

Хуралдаанд идэвхтэй оролцсон Байнгын хорооны гишүүдэд баярлалаа. Хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. /алх цохив/

Хуралдаан 3 цаг 34 минут үргэлжилж, 13 цаг 59 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД